Ерөнхий сайдын мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга Ч.Золбаяр, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга С.Тэнгис, Цахим хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Билэгдэмбэрэл, Харилцаа холбооны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Х.Энхманлай, Харилцаа холбооны зохицуулах хорооны Зохицуулалтын бодлогыг хэрэгжүүлэх газрын дарга Б.Мягмарнаран, тус холбооны Өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын газрын дарга А.Лувсан-Очир, Хяналт давтамж хяналт, зохицуулалтын газрын дарга З.Амгалан, Зах зээлийн үнэлгээ, судалгааны газрын дарга Д.Ариунболд, Хуулийн хэлтсийн дарга Т.Ууганбат, “Үндэсний дата төв” Улсын төсөвт үйлдвэрийн газрын захирал М.Баттулга, “И-Монгол академи” Улсын төсөвт үйлдвэрийн газрын захирал Л.Энхбат нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний газрын дарга Ц.Батбаатар, мөн газрын Хяналт шалгалтын хэлтсийн дарга Ж.Лхагвасүрэн, мөн хэлтсийн ахлан зөвлөх Ч.Онончимэг, референт Ж.Монголжингоо нар байлцав.

Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал Төрийн цахим шилжилтийн өнөөгийн байдал, цаашдын зорилтуудын талаар мэдээлэл хийв.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа, О.Цогтгэрэл, Б.Пүрэвдорж нарын тавьсан асуултад Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Харилцаа холбооны зохицуулах хорооны Зохицуулалтын бодлогыг хэрэгжүүлэх газрын дарга Б.Мягмарнаран нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.13-т заасны дагуу Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл нарын тавьсан асуултад Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал хариулж, тайлбар хийв.

Чуулганы нэгдсэн хуралдаанд Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал Төрийн цахим шилжилтийн өнөөгийн байдал, цаашдын зорилтуудын талаар мэдээлэл хийлээ.

Уг асуудлыг 15 цаг 53 минутад хэлэлцэж дуусав.

Батлагдсан хуулиудын эцсийн найруулгыг танилцуулах

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар дараах хуулиудын эцсийн найруулгыг танилцуулав. Үүнд:

1.Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа. /15:54/

Дагалдан боловсруулсан:

2.Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа. /15:54/

3.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа. /15:55/

4.“Хуулийн төсөл буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа. /15:55/

Бусад. Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар 01 дүгээр сарын 02-ны өдөр төрсөн өдөр нь тохиосон Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал, 01 дүгээр сарын 06-ны өдөр төрсөн өдөр нь тохиосон Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарт Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс баяр хүргэж, мэндчилгээ дэвшүүлэв.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 5 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч М.Номиндулам, С.Энхзаяа нар хариуцан ажиллав.

Хуралдаан 3 цаг 43 минут үргэлжилж, 76 гишүүнээс 50 гишүүн хүрэлцэн ирж, 65.8 хувийн ирцтэйгээр 15 цаг 55 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ
2023 оны 01 дүгээр сарын 06-ны
өдөр, Баасан гараг
Төрийн ордон “Их хуралдай”
танхим
10 цаг 37 минут
НЭГДСЭН ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Занданишатар: Амгаланг айлтгаж мэндчилгээ дэвшүүлье. Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулганы 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн нэгдсэн хуралдаанаас мэдэгдье. Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Эхлээд хууль тогтоолын төсөл эцэслэн батална. Нийт 88 төсөл байгаа. 2 үндсэн хуулийг дагалдуулж, хамт өргөн мэдүүлсэн, холбогдуулан боловсруулсан нийт 88 хуулийн төслийг батална.

Хоёрт нь Монгол Улс, Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк хоорондын зээлийн хэлэлцээрийн соёрхон батлах асуудлыг үргэлжлүүлэн хэлэлцэнэ.

Гуравт нь “Зөвлөлдөх зөвлөл байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслөө хэлэлцэнэ.

Дөрөвт нь Хөрөнгө оруулалтын банкны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна.

Тавд нь “Хөгжлийн зорилтот хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Үдээс хойших нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээлэл Монгол Улсын Төрийн цахим шилжилтийн өнөөгийн байдал, цаашидын зорилтуудын талаар мэдээлэл сонсоно.

Дэгийн тухай хуулийн дагуу үг хэлэхээр Бөхчулууны Пүрэвдорж гишүүн асуудал нэмэх тул үг хүлээх зөвшөөрөл олгоно уу гэсэн албан бичиг ирүүлсэн байна. Ингээд Бөхчулууны Пүрэвдорж үг хэлнэ.

Б.Пүрэвдорж: Их Хурлын гишүүдийн өдрийн амрыг айлтгая. Тэгэхээр бидний нөхдийн өргөн барьсан тэтгэврийг тогтоохдоо цалингийн 7 жилийн дунджаар биш 5 жилийн дунджаар тогтоох, үүний үр дүнд дунджаар 150 мянга орчим төрийн тэтгэвэрт гарч байгаа ахмадууд очих ийм боломжийг бүрдүүлж байгаа. Тэгээд хууль хэрвээ батлагдчих юм бол дараа нь 2018 оны 1 сарын 1-ээс энэ хууль батлагдах хүртэл 7 жилээр тэтгэврээ бодуулсан тэр хүмүүсийг дахин 5 жилээр бодож хохироохгүй байх ийм хуулийн төсөл бас дахиад байгаа. Ийм 2 хуулийг яаралтай хэлэлцэх зайлиггүй шаардлага гарч ирж байна. Тэгэхээр зарим Их Хурлын гишүүд энэ хуулийг ингээд хөдөөгөөр явахаар чиний хуулийг зарим нь дэмжихгүй байна гэж ярьж байх юм. Яасан их худлаа хэлдэг хүмүүс вэ. Тийм юм байхгүй шүү дээ. Аль эсвэл та нар яг ингээд ихэнх нь Монгол Ардын намын гишүүд, ер нь бол Монгол Ардын намын зарим нэгэн гишүүд тэгэх юм л даа. Тэгэхээр та нарын хийж байгаа уулзалт бол ерөөсөө нэг өөрсдийг нь долоодог хүмүүстэй л уулзалт хийдэг юм байна. Тэгээд л манай Монгол Ардын нам манай гишүүн л хамгийн сайн ажиллаж байгаа ёстой зөв ажиллаж байгаа л гэдэг тийм хүмүүсийг цуглуулж байгаад уулзалт гэдэг юм уу ямар учиртай юм. Миний очсон газар болгон л хуулиа сайн хийгээрэй гээд л, тэгээд манай 7 биш 5 жилээр тэтгэврээ тогтоолгоцгооё гэж энэ групп дээр өдөр, шөнөгүй л ахмадууд юм бичигцгээх юм. Ийм хатуу байж болохгүй шүү дээ. Би бүр ингээд бүр даваадуулж, даваадуулж хэллээ гэхэд нэг 20 тэрбум төгрөгийн л зардал жилдээ гарах байх. Ийм бага мөнгө, одоо энэ чинь 40 их наяд төгрөгийн хулгайны хажууд чинь өчүүхэн мөнгө шүү дээ. 20

их наяд төгрөгийн төсвийн хажууд чинь өчүүхэн мөнгө шүү дээ. Ийм байж болмооргүй байна. Ийм амьд бурхад болсон ахмадууддаа хатуу хандмааргүй байна.

Тийм учраас өнөөдрийн даргын зөвлөлийн хурлаар Анужин Байнгын хорооны дарга аа, та санал оруулаад ажлын хэсгээ шинэхэн сайд байгаа дээр нь Чинзориг гишүүнээр хурдан ажлын хэсгийг нь хуралдуулаад анхны хэлэлцүүлэгт нь оруулах талаар та нэг санал гаргаад ишийдүүлээд өгөөч. Тэгээд нийгмийн даатгалын багц хууль гээд орчихгүй ийм хуультай холбоод л иргэдийг хохироогоод л, ахмадуудаа хохироогоод байгаад байх юм. Занданишатар дарга аа, таныг хөдөө очиход чинь хүмүүс маш их шаардана даа. Тийм учраас энэ дээр та нэг анхааралтай хандаач. Манай Одонтуяа дарга бол хурал дээр байнга л хэлдэг. Хэлээд л байгаа юм. Тэгээд та бүхнийг сайхан Монгол төрийг, Монгол улсыг өдий хүртэл авчирсан амьд бурхад болсон ахмадуудынхаа төлөө ажиллаач гэж уриалмаар байна.

Г.Занданишатар: Өнөөдрийн хэлэлцэх асуудалтай холбоогүй юм байна. Хууль тогтоолын төсөл эцэслэн батална. Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44.3-т “7 хоногийн Баасан гарагийн 10 цагаас нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулна. Хуралдааны ирц хуулийн төсөл эцэслэн батлах шаардлага хангахаар бусад өдөр, цагт хуулийн төслийг эхлэн батлах санал хураалт явуулж болно.” гэж заасан. Тэгэхээр хуулийн төсөл эцэслэн батлах санал хураалтыг түр, Тэгвэл зөвлөлдөх зөвлөлөө хэлэлцчихээд дараа нь 88 хуулиа эцэслэн баталъя. Соёрхон батлах ч гэсэн 39-өөр юм байна. Соёрхон батлахаа баталчих юм уу. Агар-Эрдэнэ дарга аа, тэгээд хуулийн төсөл эцэслэн болох санал хураалтыг “Зөвлөлдөх зөвлөл байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцээний дараа,

хуралдааны ирцийг бүрэн хангуулж явуулъя.

Дараагийн асуудалд орё.
“Зөвлөлдөх зөвлөл байгуулах тухай”
Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Дуламдоржийн Тогтохсүрэн танилцуулна. Индэрт урьж байна.

Д.Тогтохсүрэн: Улсын Их Хурлын даргын эрхэм гишүүд ээ.

Төрийн байгуулалтын байнгын хорооны 2023 оны 01 сарын 04-ний өдрийн хуралдаанаараа “Зөвлөлдөх зөвлөлийг байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолыг хэлэлцэн дэмжиж, 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх үед Улсын Их Хурлын гишүүдээс жендерийн эрх тэгш байдлыг хангах бодлогын хүрээнд зөвлөлийн бүрэлдэхүүнд эмэгтэй нэр дэвшигчдийн төлөөллийг оролцуулах санал гаргасан тул Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.3 дахь хэсэгт заасныг үндэслэн уг асуудлыг Төрийн байгуулалтын байнгын хороонд дахин хэлэлцүүлэхээр буцаасан болно.

Тус Байнгын хороо ажлын хэсгийн саналыг үндэслэн “Зөвлөлдөх зөвлөл байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн хуралдаанаар хэлэлцлээ.

Ажлын хэсгийн хуралдаанд оролцсон гишүүд нууц санал хураалт явуулж 136 нэр дэвшигчдээс хамгийн олон санал авсан. МҮХАҮТ-аас нэр дэвшүүлсэн, эдийн засагч Амартүвшин, Ардчилсан Үндсэн хууль тогтоогчдын холбооноос нэр дэвшүүлсэн, Эдийн засагч

Ганхуяг, Хувь иргэнээр нэр дэвшсэн, Эдийн засагч Отгонтөгс, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбооноос нэр дэвшүүлсэн, инженер технологич, Монгол Улсын зөвлөх инженер Х.Ганбаатар, Монгол Улсын Шинжлэх ухааны академиас нэр дэвшүүлсэн гүн ухаан, нийгмийн ухааны багш, академич Чулуунбаатар, Төрийн бус байгууллагаас нэр дэвшүүлсэн, Улс төрийн эдийн засагч, эрх зүйч Төр-Од, хувь иргэнээр нэр дэвшсэн, зураг, хөдөлмөрийн багш Г.Галбадрах, Радио, Электроникийн инженер Моондой, Бодлогод залуусын хяналт Төрийн бус байгууллагаас нэр дэвшүүлсэн, Эрх зүйч Мандхайхатан, МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлээс нэр дэвшүүлсэн судлаач Мөнхсайхан, МҮЭХ-ноос нэр дэвшүүлсэн Хөдөлмөрийн эдийн засагч Эрдэнэбат нарын 11 нэр дэвшигчийг Зөвлөлдөх зөвлөлийн бүрэлдэхүүн нэр дэвшүүлж тогтоолын төслийг боловсруулсан болно.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Зөвлөлдөх зөвлөл байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталж өгөхийг хүсье. Баярлалаа.

Г.Занданиатар: Илтгэгчид баярлалаа. Гишүүд үндсэндээ асуулт асууж хариулт авч үг хэлж дууссан. Асуулт, хариулт бол өчигдөр үндсэндээ явчихсан. Тэгээд бол асуулт хариулт байхгүй биз дээ. Шинээр биш л дээ. Асуулттай хүн байна уу? Асуулт, үгтэй хүн байна уу? Цэрэнпилийн Даваасүрэн гишүүнээр тасаллаа. Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Ц.Даваасүрэн: Та бүхний өглөөний амгаланг эрье. Үндсэн хуулийн тухай бол би байнга та бүгдэд сануулж байгаа. Энэ бол 7 хэмжигч 1 огтлох зүйл шүү. Энэ бол бидний дээд дүрэм. Эрх мэдлийн хуваарилалт, улс төрийн эрх мэдлийн хуваарилалт энэ дотор байгаа байхгүй юу. Тийм учраас би хэлээд байгаа шүү дээ. Одоогийн байгаа 2019 онд өөрчилсөн, одоо ахиад өөрчилье гэж байна. Тийм үү. Тэгвэл энэний дараа гарч ирсэн хүн дахиад өөрчлөлт хийх байхгүй юу. Тэрний дараагийнх дахиад өөрчилье гэнэ. Ингээд л өөрчлөөд л яваад л байвал энэ хууль сэг болно. Цэг болно. Одоо энд сууж байгаа та хэд ч гэсэн бас бодоорой. Энэ бол тоглоом биш. Бүгд тэгнэ, бүгд тэгж хүснэ. Дараагийн улс төрчид бүгдээрээ тэгж хүснэ. Нэг бол буцаана гэнэ. Сүүлд нэг ийм яриа гарсан юм байна лээ шүү дээ. Үгүй ээ, ер нь энэ давхар дээл дэмий ч юм уу гээд. Ингээд ахиад тэгээд эхэлчихсэн байна гэж байгаа байхгүй юу. Энэ чинь тоглоом биш шүү дээ. Энэ Үндсэн хууль чинь. Тийм учраас маш том хариуцлага энд байгаа гэдгийг би дахин, дахин хэлье. Маш том хариуцлага байгаа. Тийм учраас яг үндсэндээ энэ дээр бүр гар хүрэх дээрээ тулдаг юм бол юу та нар ард түмнийг төлөөлөх эрх байхгүй. Зүгээр тэр ард түмнээсээ зүгээр сонсдог юм байгаа биз. Тэрний дараа бол харин яг өөрчлөх дээрээ тулах юм бол ард нийтийн санал асуулга явахаас өөр ямар ч арга байхгүй. Үндсэн хууль дээр бол. Тэгж байж үндсэн хуулийн чинь дархлаа тогтохгүй бол цаашидаа Үндсэн хууль маань сүүлдээ бүр хачин юм болж хувирна шүү. Энэ чинь ерөөсөө эрх мэдлийн л том зохицуулалт шүү дээ. Хамгийн дээд дүрэм. Тэгээд эндээ ингээд гар хүрээд ингээд яваад байх юм сүүлдээ нөгөө нэг тэрэгний дугуй хийх гээд шүдний чигчий болдог билүү. Тэр шиг л хууль болно гэсэн үг шүү дээ. Би 1990-ээд онд хууль хийсэн улсуудыг бол хүндэтгэдэг. Тэд нар бол ажлын туршилагатай байсан. Мөнгөний шуналгүй байсан. Ер нь сум, сумын шилдгүүд ирсэн байхгүй юу. Бас улс

орныхоо том, том салбаруудад ажиллаж байсан шилдгүүд тэнд байж сууж байгаад бас маш ихийг бодож байж үндсэн хуулийн асуудлыг шийдсэн. Би тэднийг хүндэтгэдэг. Тийм учраас би Үндсэн хуулийн асуудал дээр анхааралтай бай гэдгийг бол байнга, байнга хэлж байгаа юм. Хэн нэгэн хүн өөртөө тохируулж болохгүй байхгүй юу. Би дахин хэлье. Дараагийн хүн ахиад өөртөө тохируулна. Тэрний дараагийн хүн ахиад өөртөө тохируулна. Ингээд яваад байх юм байгаа юм гэдгийг бас манай гишүүд маань бид бүгдээрээ маш сайн бодож байхгүй бол Үндсэн хууль гэдэг бол бусад хуулиас эрс ялгаатай зүйл шүү гэдгийг би бүр дахин, одоо аягүй бол нөгөө юу юм шиг байна л даа. Ерөөсөө анхны хэлэлцүүлгээрээ баталчих юм шиг байна л даа. Горимын санал байхгүйгээр. Тийм учраас би үг хэлж байгаа юм. Энэ бол Үндсэн хууль. Энэ бол бидний дээд дүрэм. Энийгээ үе үе ингэж оролдох нь үндэсний эрх ашиг, тусгаар тогтнолд нөлөөлж болзошгүй ийм зүйл гэдгийг би сануулах нь зүйтэй гэж бодож байна.

Г.Занданишатар: Үг хэллээ. Асуулт биш байна. Санал хураалт явуулна. Байнгын хорооны саналаар “Зөвлөлдөх зөвлөл байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоол төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Тэгэхдээ нэг ийм буруу ойлголт яваад байгаа нь бол ингээд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт гэж улс төрийн намууд, гишүүд олон хүмүүс ярьж байгаа. Тэгэхдээ Зөвлөлдөх зөвлөл, зөвлөлдөх санал асуулга явуулах асуудал бол санал асуулга буюу ард түмний санал бодлыг том фокус группийн судалгаа хийж тандах зорилготой болохоор тэр Үндсэн хууль гэдэг ганц ч үг тогтоол байхгүй шүү. Зөвлөлдөх зөвлөл ч гэсэн тэрийг анхаарч ажиллах хэрэгтэй. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах гээд зөвлөлдөх санал асуулга, нийгэм эдийн засгийн тулгамдсан асуудлыг тодорхойлох, энэ юунаас болоод байгаа

юм. Нийгмийн 30 жилийн гажуудал гэж яриад байгаа юм, энэ авлига хээл хахууль, сахилга хариуцлага энэ юмыг чинь яг ард түмэн юу гэж үзэж байгаа вэ гэдгийг том судалгаа, ард түмнийг төлөөлөх чадвар бүхий судалгаа хийгдэж байна л гэж ойлгох хэрэгтэй.

Ингээд Байнгын хорооны саналаар “Зөвлөлдөх зөвлөл байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Өнөөдрийн анхны санал хураалт учраас бүртгэлийн санал хураалт явуулъя. 33 гишүүн дэмжиж 78.6 хувийн саналаар санал дэмжигдлээ. Бүртгэлийн санал хураалт, 9 гишүүн бүртгэлд ороогүй байна шүү. Энэ хүмүүсийг ирцэд хасахаар тооцогдоно шүү. Бүртгэлийн санал хураалт явсан учраас Байнгын хорооны саналаар “Зөвлөлдөх зөвлөл байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт. 31 гишүүн дэмжиж 73.8 хувийн саналаар санал дэмжигдлээ. Тогтоолын төсөл батлагдлаа.

Тогтоолыг уншиж танилцуулъя. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг Зөвлөлдөх санал асуулгын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэг, 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын 2012 оны 80 дугаар тогтоолын 5 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь.

Зөвлөлдөж шийдье улсын хэмжээний зөвлөлдөх санал асуулгыг зохион байгуулах зөвлөлдөх зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Отгондаваагийн Амартүвшин, Гомбосүрэнгийн Галбадрах, Хуягийн Ганбаатар, Өлзийхутагийн Ганхуяг, Цэгмэдийн Мандхайхатан, Доржийн Моондой, Одонхүүгийн Мөнхсайхан, Банзрагчийн Отгонтөгс, Лхагважавын Төр-Од, Гэлэгпилийн Чулуунбаатар, Сүхбаатарын Эрдэнэбат.

Хоёр. Зөвлөлдөх санал асуулгын тухай хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх санал асуулгын дүнг нэгтгэж зөвлөмж гарган Улсын Их Хуралд танилцуулахыг Зөвлөлдөх зөвлөлд даалгасугай.

Энэ тогтоолыг 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр гэсэн байна. Найруулга дээр 6-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй. Энийг редакцын засвараар 6-ны өдөр гэж авлаа. Эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Та бүхэнд ажлын өндөр амжилт хүсье. Тогтоол батлагдлаа. Даргаа дотроосоо сонгоно.

Хууль тогтоолын төслүүдийг эцэслэн батална. Бүгдэд нь амжилт хүсье. Аливаа нөлөөнд автахгүй, чин шударгаар ажиллахыг хүсье.

10.53 цагт

Хуулийн төслүүд эцэслэн батална. Стандартчилал техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай, Хэмжил зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн, холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүд, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батална.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44.3-т зааснаар “Баасан гарагт хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулна.” гэж заасны дагуу хуралдааны ирц, хуулийн төсөл эцэслэн батлах шаардлага хангахаар бусад өдөр, цагт хуулийн төслүүдийг эцэслэн баталж

болно гэж заасны дагуу Байнгын хороод эцэслэн батлах хувилбаруудыг бэлтгэж, гишүүдэд тарааж эцэслэн батлуулахаар бэлтгэл бэлэн болсон байна. Бэлтгэл хангагдсан байна. Төслүүдийг эцэслэн батлах санал хураалт явуулна. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44.2-т нийт гишүүдийн олонх буюу 39 гишүүнээс дээш гишүүд дэмжсэнээр хуулийн төслийг эцэслэн баталсанд тооцно гэж заасан. Энэ дагуу санал хураалт явуулна. Санал хураалтаа явуулъя.

Стандартчилал техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Танхимын зүүн жигүүр цөөн хүнтэй харагдаж байна.

Тогтохоо дарга аа, санал хураалт явуулах уу.

Өнөөдөр төрсөн өдөр нь тохиож байгаа Улсын Их Хурлын гишүүнд мэндчилгээ дэвшүүлье. Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболд 01 дүгээр сарын 06-нд Мандаагийн Нямаа, Гүрийн Тогтох нарын ууган хүүхэд болж эхээс мэндэлжээ. Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболдод төрсөн өдрийн мэнд хүргэж, Монгол төрийн эрхэм биш ард түмний элч болсон танд болон танай гэр бүлийнхэнд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал сайн сайхныг хүсэн ерөөж мэндчилье.

Санал хураалт. Бүртгэлийн санал хураалт, бүртгэлийн санал хураалт.

Бүртгэлийн санал хураалт явуулж байна. Анандбазар, Анужин, Аубакир, Баатарбилэг, Батсуурь, Бат-Эрдэнэ, Бейсен, Болорчулуун, Бямбацогт, Ганибал, Даваасүрэн, Идэрбат, Ж.Мөнхбат, Г.Мөнхцэцэг, Ц.Туваан, Хүрэлбаатар, Цогтбаатар, Цогтгэрэл, Цэрэнпунцаг, Чинбүрэн, Б.Энхбаяр, Нямаагийн Энхболд нар саналаа.

Цогтгэрэл, Ганибал 2-ыг дуудчихаач.
Санал хураалт явуулъя.

Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт. Сайнбуянгийн Амарсайхан гишүүн үг хэлнэ.

С.Амарсайхан: Сая дэмжсэн санал өгсөн ороогүй байгаа учраас горимын санал гаргаж, саяын санал хураалтыг хүчингүй болгох, дахин санал хураалт явуулах санал оруулж байна.

Г.Занданишатар: Сайнбуянгийн Амарсайхан гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт. 84.4 хувийн саналаар саяны санал хураалтыг хүчингүйд тооцлоо. Гишүүд анхааралтай байгаарай. Засгийн газраас өргөн мэдүүлсэн хууль шүү дээ. Бямбацогт гишүүний санаачилсан биш.

Нөгөө 88 хуулиар Зөвшөөрлийн тухай хуулиар 1600 байсан зөвшөөрлийн тоог энэ хуулиар 362 болгож цөөлж байгаа хууль гэж ойлгож байгаа шүү дээ. Бейсен, Ганибал, Ж.Мөнхбат, Пүрэвдорж, Туваан, Цогтгэрэл нар эсрэг гараад байх юм. Хүнд суртал чирэгдлийг их бууруулах гэж байгаа хууль. 1 сарын 1-нээс хэрэгжих ёстой хууль. Хүчингүй болгох тооцсон, одоо ингээд эцэслэн батлах санал хураалт явуулах гэж байна. Санал хураалт явуулъя. Санал хураалт. Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн.

Б.Бат-Эрдэнэ: Миний кноп би уг нь бүртгүүлсэн юм сан. Тэгээд орсонгүй. Дахиад хүчингүй болгоод дахиад санал хураалгаж өгнө үү.

Г.Занданишатар: Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. 39 гишүүн дэмжиж саяны санал хураалтыг хүчингүйд тооцлоо. Горимын санал дэмжигдээж

хүчингүйд тооцсон учраас эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалтыг дахин явуулъя. Тогмидын Доржханд гишүүн.

Т.Доржханд: Их Хурлын дарга төхөөрөмж ажилласангүй. Санал хураалтыг хүчингүйд тооцож дахин санал оруулж өгнө үү. Баярлалаа.

Г.Занданишатар: Тогмидын Доржханд гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт. 82.6 хувийн саналаар энэ саналыг хүчингүйд тооцлоо. Хүчингүйд тооцсон учраас санал хураалт явуулна. Санал хураалт. 39 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Хэмжил зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 40 гишүүн дэмжиж хууль эцэслэн батлагдлаа. Хамт өргөн мэдүүлсэн Авто замын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 39 гишүүн дэмжиж хууль ажил нь батлагдлаа.

Авто тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 42 гишүүн дэмжиж хууль эцэслэн батлагдлаа.

Агаарын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 42 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Ажиллах хүчний ишлжилт хөдөлгөөний тухай хуулийн зарим хэсэг, заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 39 гишүүн дэмжиж хууль

эцэслэн батлагдлаа. Булгантуяа гишүүн ээ, Адыасүрэн гишүүн ээ.

Амьтны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 39 гишүүн дэмжиж хууль эцэслэн батлагдлаа.

Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 40 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Аудитын тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 41 гишүүн дэмжих хууль эцэслэн батлагдлаа.

10. Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Адыасүрэн гишүүн ээ, 41 гишүүн дэмжиж хууль эцэслэн батлагдлаа.

11. Байгалийн ургамлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 39 гишүүн дэмжиж хууль эцэслэн батлагдлаа.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Баттөмөр гишүүн ээ, Бат-Эрдэнэ гишүүн ээ, 40 гишүүн дэмжиж хууль эцэслэн батлагдлаа. Анандбазар, Болорчулуун 2 анхааралтай байгаарай.

13. Байгаль орчныг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 41

гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 42 гишүүн дэмжиж хууль эцэслэн батлагдлаа.

Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Аубакир, Идэрбат, Баатарбилэг 3. Цагаанхүүгийн Идэрбат гишүүн.

Ц.Идэрбат: Саяын санал хураалтад төхөөрөмж дээр бас жоохон алдаа гарлаа. Саяны санал хураалтыг хүчингүй болгож өгнө үү.

Г.Занданшатар: Идэрбат гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. 39 гишүүн дэмжиж, саяны санал хураалтыг хүчингүйд тооцлоо. Хүчингүйд тооцсон учраас санал хураалтыг дахин явуулъя. 39 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа. Яагаад сатааруулах ажиллагаа явуулаад байна.

Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 42 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Биеийн тамир, спортын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Хууль эцэслэн батлагдлаа. 41 гишүүн дэмжиж.

Гаалийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 42 гэсэн нь дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Гадаадын иргэний эрхийн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 40 гишүүн дэмжиж хууль эцэслэн батлагдлаа.

Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 39 гишүүн дэмжиж хууль эцэслэн батлагдлаа. Амарсайхан, Анандбазар, Одонтуяа гишүүд анхааралтай байгаарай.

Газрын хэвлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 40 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Галт зэвсгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Булгантуяа гишүүн ээ, 42 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Галын аюулгүй байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 42 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Гамшигаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалт явуулъя. 40 гишүүний дэмжиж хууль эцэслэн батлагдлаа.

Генетик нөөцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 39 гишүүн дэмжиж хууль эцэслэн батлагдлаа.

Гэрээт харуул хамгаалалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 40 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 41 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 40 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 41 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Зар сурталчилгааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя, 39 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 40 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль төслийг эцэслэн баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Анандбазар гишүүн кнопоо. 41 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 39 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Зэвсэгт хүчний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 39 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 42 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Иргэний нисэхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 40 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Кино урлагийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 41 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Кибер аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 40 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Булааны Бейсен гишүүн үг хэлнэ.

Б.Бейсен: Миний кноп ажиллаагүй. Дахин санал хураалт хийж өгнө үү.

Г.Занданшатар: Бейсен гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. 84.8 хувийн саналаар саяын санал хураалтыг хүчингүйд тооцлоо. Санал хураалтыг хүчингүйд тооцсон учраас санал хураалтыг дахиж

явуулъя. Ганбат гишүүн ээ картаа уншуул.

Малын генетик нөөцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалт явуулъя. 41 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

41.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 40 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Монгол Улсын хилийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Л.Энх-Амгалан гишүүн.

Л.Энх-Амгалан: Миний юу ажилласангүй. Санал хураалтын төхөөрөмж ажилласангүй. Дахиж санал хураалгаж өгнө үү.

Г.Занданшатар: Лувсанцэрэнгийн Энх-Амгалан гишүүний гарсан горимын саналаар санал хураалт явуулъя. 40 гишүүн дэмжиж горимын санал дэмжигдлээ. Дэмжигдсэн учраас санал хураалтыг дахиж явуулъя. Анандбазар гишүүн, Баттөмөр гишүүн. 41 гишүүн дэмжиж хууль эцэслэн батлагдлаа.

Музейн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 41 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Мэргэжлийн боловсрол сургалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 42 гишүүн дэмжиж хууль эцэслэн батлагдлаа.

Ойн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 41 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Онцгой албан татварын тэмдгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Баатарбилэг гишүүн ээ. Цогтбаатар гишүүн ээ. Адъяасүрэн гишүүн ээ. 42 гишүүнээр хууль эцэслэн батлагдлаа.

Өргөн нэвтрүүлгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 41 гишүүнээр хууль эцэслэн батлагдлаа.

Өрсөлдөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 41 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Радио долгионы тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 41 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 39 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Соёлын өвийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 41 гишүүн дэмжиж, хууль батлагдлаа.

Соёлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн томъёоллоор санал

хураалт явуулъя. 40 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 40 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Төмөр замын тээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 40 гишүүний дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Тусгай хамгаалалтай газар нутгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 42 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль эцэслэн баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 40 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

57.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 41 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Улсын нисэхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 41 гишүүн дэмжиж хууль эцэслэн батлагдлаа.

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн томъёоллоор санал хураалт. 39

гишүүн дэмжиж хууль эцэслэн батлагдлаа.

Ургамал хамгааллын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахад хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 42 гишүүн дэмжиж хууль эцэслэн батлагдлаа.

Усны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн томъёоллоор санал хураалт. 41 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн томъёоллоор санал хураалт. Нямаагийн Энхболд гишүүн ээ, 39 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Үндэсний төлбөрийн системийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн томъёоллоор санал хураалт. 41 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн томъёоллоор санал хураалт. 40 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн томъёоллоор санал хураалт. 41 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн томъёоллоор санал хураалт. 41 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Химийн хорт болон аюултай бодисын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт

орлуулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн томъёоллоор санал хураалт. Бадарчийн Жаргалмаа, Дамдины Цогтбаатар 2.

Энэ 7 хоногт төрсөн өдөр нь тохиож байгаа Улсын Их Хурлын гишүүнд мэндчилгээ дэвшүүлье. 1 сарын 2-нд Улсын Их Хурлын гишүүн Учрал Намсрайн Ням-Осор, Жамбалын Цэцэгмаа нарын ууган хүүхэд болж эхээс мэндэлжээ. Учрал гишүүндээ төрсөн өдрийн мэнд хүргэж, Монгол төрийн эрхэм түшээ ард түмний элч болсон танд болон танай гэр бүлд Улсын Их Хурлын гишүүдийн нэр өмнөөс аз жаргал, сайн сайхныг хүсэн ерөөе.

Учрал гишүүн үг хэлнэ.

Н.Учрал: Их Хурлын дарга, эрхэм гишүүддээ төрсөн өдрийн мэнд хүргэсэнд баярлалаа. Сая санал хураалт дээр бас төхөөрөмж ажилласангүй. Тэгээд дахиж санал хураах санал гаргаж байна.

Г.Занданшатар: Учрал гишүүний гарсан 3 саналаар санал хураалт авлаа. 76.6 хувийн саналаар санал хураалтыг хүчингүйд тооцлоо. Санал хураалтыг хүчингүйд тооцсон учраас дахин санал хураалт явуулъя. Цогтбаатар гишүүн ээ, 39 гишүүн дэмжиж хууль эцэслэн батлагдлаа.

68.Ховордсон амьтан, ургамал тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалт. 42 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Хог хаягдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт. 39 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Хот, суурины ус хангамж ариутгах, татуургын ашиглалтын тухай

хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 39 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

71.Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн.

Ц.Даваасүрэн: Уучлаарай би эндүүрээд дарчхаж. Дахин санал хураалт явуулж өгнө үү. Дарга аа, эндүүрээд дарчхаж.

Г.Занданшатар: Даваасүрэн гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. Горимын санал дэмжигдэж, санал хураалтыг хүчингүйд тооцлоо. Санал хураалтыг хүчингүйд тооцсон учраас дахин явуулъя. Өмнөх санал хураалтыг дахин явуулъя. 40 гишүүн нь дэмжиж хууль эцэслэн батлагдлаа.

Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 39 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 40 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Хувийн хамгаалалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 42 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Хувиргасан амьд организмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн

томъёоллоор санал хураалт явуулъя. 40 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн зарим хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 42 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 42 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Хүүхэд харах үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн томъёоллоор санал хураалт. 41 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Цахим гарын үсгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 41 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Цөмийн эергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн томъёоллоор санал хураалт. 40 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Шуудангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн томъёоллоор санал хураалт. 40 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Эцэслэн батлах санал хураалт дээр үг байхгүй юм байна. Уучлаарай гишүүн ээ. Энийг таны нөгөө санааг ойлгож байгаа. Хууль санаачлаад явахаас

өөр зам байхгүй. Энийг Чинзориг сайд, Чинбүрэн гишүүн 2 ярьж байгаад энийг зохицуулалт хийхгүй бол хүндрэлтэй болчихсон гээд байгаа юм. Санал хураалт явуулъя. 41 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 41 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Би уг нь уншуулсан юм. Тэгээд эсрэг гарчихлаа. Хурууны хээ уншигдаагүй юм шиг байна. Уг нь гэрэл нь асаж байгаа харагдсан юм. Тийм учраас энэ санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя. 42 гишүүн дэмжиж горимын санал дэмжигдсэн учраас санал хураалтыг дахиж явуулъя. 40 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн. Саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 40 гишүүн дэмжиж, тогтоолын төсөл батлагдлаа.

Холбогдуулан боловсруулсан Зөвшөөрлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 41 гишүүн дэмжлээ.

87.Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 43 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг

эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 40 гишүүн дэмжиж хууль эцэслэн батлагдлаа.

Гишүүд Ажлын хэсэгт баярлалаа. Хуулийн төслүүд эцэслэн батлагдлаа. Цаашидаа Тамгын газар, Нямбаатар сайд ч гэсэн Хууль тогтоомжийн хууль өргөн барихдаа багцлаад ер нь ингээд үндсэн нэг шинэчилсэн найруулга батлагдаж байгаа юм чинь тэр багц дагаж орсон хуулиуд нь эцэслэн батлах хэлэлцүүлэггүй юм чинь шууд хамтдаа батлагддаг байх зохицуулалтыг ер нь нэг бодох, өөр өөр тусдаа юу.

11.55 цагт

**Дараагийн асуудалд орёё,
дараагийнх нь бас Монгол Улс Азийн
дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк
хоорондын зээлийн хэлэлцээрийг
соёрхон батлах тухай хуулийн
төслийн соёрхон батлах асуудлыг
үргэлжлүүлэн хэлэлцэнэ.**

Гишүүд асуулт асууж, үг хэлж дууссан. Байнгын хорооны саналаар хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт. Цогт-Очирын Анандбазар гишүүн суу. Хуулиа эцэслэн батлах ёстой. Гишүүд асуулт асууж дууссан. Дэгийн тухай хуулийн дагуу нэгдсэн хуралдаанд хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулах бөгөөд Улсын Их Хурлын нийт гишүүний олонх дэмжсэн бол хуулийн төслийг эцэслэн баталсанд тооцно гэж заасан. Байнгын хорооны саналаар зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналыг нь томъёоллоор санал хураалт явуулъя. Эрхэм гишүүн Аубакир.

Т.Аубакир: Би сая саналаа өгсөн. Төхөөрөмж ажилласангүй. Дахиж санал хураалт явуулж өгнө үү.

Г.Занданшатар: Аубакир, Жаргалмаа 2 гишүүн дэмжсэн бол эцэслэн баталсанд тооцож...Аубакир

гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. 79.2 хувийн саналаар энэ саналыг хүчингүйд тооцлоо.

Санал хураалт дахиж явуулъя. Өчигдөр уншаад хуулийн төслийг татаад авсан. Засгийн газрын бичиг ирээд. Одоо анхааралтай байцгаая. Ингээд Байнгын хорооны саналаар хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалт явуулна. Мөнхбат гишүүн ээ, Цэрэнпунцаг гишүүн ээ анхааралтай байгаарай. Санал хураалт. Энх-Амгалан гишүүн. 42 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Хуулийн төслүүд батлагдлаа. Гишүүд, ажлын хэсэгт баярлалаа. 100 сая доллар чинь хэзээ орж ирэх юм бэ. Тэгээд нөөц нэмэгдэж ойлгож байгаа. Энийг уншиж танилцуулна.

Зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай

Нэгдүгээр зүйл. Монгол Улс, Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк хооронд 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдөр байгуулсан /Мөчлөг сөрсөн бодлогын арга хэмжээг дэмжих хөтөлбөр/-ийн зээлийн хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай. Эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Алга байна. Эцсийн найруулгыг сонсонд тооцлоо. /11:58/

11.58 цагт

Дараагийн асуудалд орно. Хөрөнгө оруулалтын банкны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна.

Ажлын хэсгийн гишүүдийг оруулъя.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор үргэлжлүүлэн санал хураалт явуулна. Гишүүд. Зарчмын зөрүүтэй саналын

томъёоллоор санал хураалт явуулна. Үргэлжлүүлээд явуулна.

11 дүгээр зүйл дээр саналууд гарсан. Өмнө нь хэлсэн. Тэгээд 11 дүгээр зүйлтэй холбогдуулж Улсын Их Хурлын гишүүн Тогмидын Доржханд үг хэлнэ.

Т.Доржханд: Баярлалаа. Өчигдөр 11, 15, 16 дээр уг нь горимын санал гаргасан юм. Тэгээд 15, 16 дээр нь саналыг хүлээж авсан. 11 санал маань нөгөө яригдаагүй байгаа. Тэгэхээр тухайн үед төхөөрөмж ажиллаагүй байсан. Тэгээд үүнтэй холбоотойгоор 11 дээр явуулсан саналыг хүчингүйд тооцож дахин санал хурааж өгнө үү гэсэн горимын санал гаргаж байна. Баярлалаа.

Г.Занданшатар: 11 байна уу 12 байна уу. Хуулийн 12, хуулийн 11. Саналын томъёоллуудын дарааллаар 12-т эрэмбэлэгдсэн заалтыг хүчингүйд тооцох саналыг Тогмидын Доржханд гишүүн гаргалаа. Тогмидын Доржханд гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. 57.8 хувийн саналаар Доржханд гишүүний гаргасан горимын санал дэмжигдлээ. Доржханд гишүүний горимын санал дэмжигдсэн учраас саналын томъёоллын 12 хуулийн төлийн 11 дүгээр зүйлийн талаарх санал хураалтыг дахиж явуулъя. 57.8 хувийн саналаар санал дэмжигдлээ. Төсөлд 11 дүгээр зүйл нэмэх, гадаад валют худалдах худалдан авах арилжаа гэсэн хэсэг дэмжигдлээ. Протокол тэмдэглэлээ. Үргэлжлүүлэн санал хураалтаа явуулъя.

19.Төслийн 12 дугаар зүйлийг 18 дугаар зүйл болгон дор дурдсанаар бүхэлд нь өөрчлөн найруулах:

“18 дугаар зүйл. Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк байгуулах тусгай зөвшөөрөл олгох

18.1.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк байгуулах тусгай зөвшөөрөл олгохыг хүссэн өргөдөл, бусад

баримт бичгийг Монголбанк хянахдаа дараах шаардлага хангасан эсэхийг тогтооно.

18.1.1.Хуулийн 16 дугаар зүйлд заасан шаардлага

18.1.2.Банкны тухай хуульд заасан Банкны хяналт шалгалт, албадлагын арга хэмжээг аливаа саадгүй, үр нөлөөтэй хэрэгжүүлэх боломжтой эсэх

18.2.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк байгуулах тусгай зөвшөөрөл олгохыг хүссэн өргөдлийг Монголбанк хүлээн авахдаа хуулийн 16 дугаар зүйлд заасан шаардлага 17 дугаар зүйлд заасан баримт бичгийн бүрдлийг хянах бөгөөд хэрэв нэмэлт баримт бичиг шаардлагатай бол уг нэмэлт баримт бичгийг бүрдүүлж өгсөн өдрийг өргөдөл хүлээн авсан өдөрт тооцсон. Санал гарсан ажлын хэсэг. Санал хураалт. 60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

20.Төслийн 13 дугаар зүйлийг 19 дүгээр зүйл болгон, доор дурдсанаар бүхэлд нь өөрчлөн найруулах:

“19 дүгээр зүйл.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк байгуулах тусгай зөвшөөрөл олгохоос татгалзах

19.1.Монголбанк дараах нөхцөлд хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк байгуулах тусгай зөвшөөрөл олгохоос татгалзана:

19.1.1.энэ хуулийн 5, 16 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаагүй;

19.1.2.Банкны тухай хуулийн 24.1-д заасан нөхцөл бүрдсэн.” Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. 57.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

21.Төслийн 14 дүгээр зүйлийг 20 дугаар зүйл болгон, доор дурдсанаар бүхэлд нь өөрчлөн найруулах:

“20 дугаар зүйл.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкныг бүртгэх

20.1.Энэ хуульд заасны дагуу Монголбанкнаас тусгай зөвшөөрөл авсан хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкныг улсын бүртгэлд бүртгүүлнэ.

20.2.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкныг улсын бүртгэлд бүртгэсэн тухай нийтэд мэдээлнэ. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 59.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

22.Төслийн 15 дугаар зүйлийг 21 дүгээр зүйл болгон, доор дурдсанаар бүхэлд нь өөрчлөн найруулах:

“21 дүгээр зүйл.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны нэр

21.1.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны нэр нь түүний оноосон нэр болон “хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк” гэсэн үгнээс бүрдэнэ.

21.2.Гадаад улсын банк, санхүүгийн байгууллагын үүсгэн байгуулсан хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны нэр нь толгой компанийн нэр болон “хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк” гэсэн үгнээс бүрдэнэ.

21.3.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны нэрийг Монголбанкны зөвшөөрөлтэйгөөр хуулийн дагуу өөрчилнө.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 54.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төслийн 15 дугаар зүйлтэйгээ бараг адилхан л байх юм. Тэгээд 2 л үг өөрчилсөн юм байна л даа.

23.Төслийн 16 дугаар зүйлийг 22 дугаар зүйл болгон, доор дурдсанаар бүхэлд нь өөрчлөн найруулах:

“22 дугаар зүйл.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк байгуулах тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох

22.1.Монголбанк хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк байгуулах тусгай зөвшөөрлийг дараах үндэслэлээр хүчингүй болгож, нийтэд зарлана:

22.1.1.хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкиг дампуурсан буюу төлбөрийн чадваргүй болсныг зарласан, эсхүл татан буулгах тухай эрх бүхий байгууллагын шийдвэр гарсан;

22.1.2.энэ хуулийн 5, 16 дугаар зүйлд заасан шаардлагыг хангахгүй болсон;

22.1.3.Банкны тухай хуулийн 27 дугаар зүйлд заасан үндэслэл бий болсон.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

24.Төслийн 17 дугаар зүйлийг бүхэлд нь хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 52.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

25.Төсөлд доор дурдсан агуулгатай Дөрөвдүгээр бүлгийн гарчиг нэмэх:

**“ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ТӨРӨЛЖСӨН БАНКНЫ
УДИРДЛАГА, ТАЙЛАН, ХЯНАЛТ
ШАЛГАЛТ”** санал гаргасан ажлын хэсэг.

Пүрэвдорж гишүүн үг хэлэх юм байна. Хэлэх юм уу. Тэгвэл санал хураалт. 52.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

26.Төсөлд доор дурдсан агуулгатай 23 дугаар зүйл шинээр нэмэх:

“23 дугаар зүйл.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны удирдлага

23.1.Гадаад улсын банк, санхүүгийн байгууллагаас үүсгэн байгуулсан хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх этгээдийг хөрөнгө оруулалтын банкны толгой компанийн удирдлагыг хэрэгжүүлэгч эрх бүхий этгээдээс томилно.

23.2.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны төлөөлөн удирдах зөвлөлийн хоёроос доошгүй гишүүн, гүйцэтгэх удирдлага нь төслийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын чиглэлээр мэргэшсэн, банк, санхүүгийн байгууллагад таваас доошгүй жил эрх бүхий албан тушаалтнаар ажилласан туршилагатай этгээд байна.

23.3.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны төлөөлөн удирдах зөвлөл таваас доошгүй гишүүнтэй байх ба хоёроос доошгүй хараат бус гишүүнтэй байна.

23.4.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны эрх бүхий албан тушаалтан нь тухайн банканд кастодиан, үнэлгээний болон аудитын үйлчилгээ үзүүлдэг хуулийн этгээд, компанийн эрх бүхий албан тушаалтан, үнэлгээчин, аудиторын холбогдох этгээд байхыг хориглоно.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 59.1 хувийн санал санал дэмжигдлээ.

27 Төсөлд доор дурдсан агуулгатай 24 дүгээр зүйл шинээр нэмэх:

“24 дүгээр зүйл.Санхүүгийн тайлан

24.1.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу санхүүгийн тайлан гаргана.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт 54.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Эдийн засгийн байнгын хорооны референт, ажлын хэсэг та хэд энэ үг

үсгийн найруулга дээрээ сайн анхаараарай. Түүрүн тэр тусгай зөвшөөрөл олгохоос татгалзах гэдэг дээр Банкны тухай хуулийн 24-д заасан нөхцөл бүрдсэн гэгчээж байгаа юм. Тэр чинь нөхцөл бүрдээд байх юм байхгүй. 24 чинь өөрөө тусгай зөвшөөрөл олгохоос татгалзах гэсэн хэсэг байгаа шүү дээ. Түүнийгээ эшлээд 24.1-д болон энд заасныг үндэслэл татгалзана гээд л бичих юмыг нөхцөл бүрдэнэ гэдэг чинь юу гэсэн үг юм. Өөр газраа болохоор олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартыг дагана гэсэн мөртөө энд олон улсын гэдгийг нь хаячхаж байгаа байхгүй юу. Тэгэхээр олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандарт, нягтлан бодох бүртгэлийн хуулийн дагуу санхүүгийн тайлан гаргана гэдэг юмнуудаа бас үг үсгүүд дээрээ харахгүй бол бас сүүлд нь.

28. Төсөлд доор дурдсан агуулгатай 25 дугаар зүйл шинээр нэмэх:

“25 дугаар зүйл. Хяналт шалгалт

25.1. Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк, түүний толгой компани, нэгдэлд тавих нэмэлт шаардлага, тэдгээрт хийх хяналт шалгалттай холбогдох харилцааг Банкны тухай хууль болон Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооны хамтран баталсан журмаар зохицуулна.

25.2. Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны үүсгэн байгуулагч гадаад улсын хуулийн этгээд бол тус этгээдийн оршин байгаа улсын санхүүгийн хянан зохицуулах эрх бүхий байгууллагатай Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо хамтарсан хяналт шалгалт хийж болно.

25.3. Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны үүсгэн байгуулагчийн оршин байгаа улсын санхүүгийн хянан зохицуулах эрх бүхий байгууллага энэ хуулийн дагуу үүсгэн байгуулж, бүртгэгдсэн хөрөнгө оруулалтын

төрөлжсөн банкны үйл ажиллагаанд Монголбанкны зөвшөөрлөөр хяналт шалгалт хийж болно.” Санал гаргасан ажлын хэсэг. Баттөмөрийн Энхбаяр гишүүн үг хэлнэ.

Б.Энхбаяр: Хуулийн нөгөө эрх олгосон юм уу эсвэл нэмэлт шаардлага тавьсан заалтууд хуульдаа нэн тодорхой бичигдэх нь 2 талын ач холбогдолтой байгаад байгаа юм. Нэг талаас гадаадын хөрөнгө оруулагч, дотоодын хөрөнгө оруулагч хөрөнгөө оруулсан тэр хүнийг аливаа төрийн шийдвэр гаргаж байгаа байгууллага, албан тушаалтны дур зоргоос хамгаалах, өөрөөр хэлбэл хуульд ерөнхий байвал тэр ерөнхий хууль дээр эрх бүхий байгууллага албан тушаалтан дураараа хуулийг тайлбарлаж өөр өөрөөр тайлбарлаж, нэмэлт бичиг баримтууд шаарддаг, үүний цаана авлига үүсдэг. Нөгөө талдаа хөрөнгө оруулагчаа эрсдэлд оруулдаг нэг ийм асуудал гардаг.

2 дахь асуудал нь ерөнхий байх тусмаа түүн дээр шийдвэр гаргасан байгууллага, албан тушаалтан, дараа нь хуулийн байгууллага дээр албан тушаалын байдлаа урвуулан ашигласан, эрх мэдлээ хэтрүүлсэн гэдэг авлига, албан тушаалын хэрэгт чирэгдэх хонгилдуулах ийм уут бий болгодог. Тийм учраас нэг талаас хөрөнгө оруулагчийг нөгөө талаас шийдвэр гаргаж байгаа албан тушаалтныг хамгаалж байхын тулд авлигаас урьдчилан сэргийлэхийн тулд хуулийн шаардлагууд, заалтууд нэн тодорхой байх ёстой байдаг. Сая бидний 19 дэх саналын томъёолол буюу энэ хуулийн 18.2-т хөрөнгө оруулалтын банк тусгай зөвшөөрлийн асуудлыг Монголбанк шийдвэрлэх дээр ийм юм биччихээж байгаа юм. Хэрэв нэмэлт баримт бичиг шаардлагатай бол яг ямар нэмэлт баримт бичиг юм бүү мэд. Хуульд зааснаас тэрийг хэн тодорхойлохыг бүү мэд. Монголбанкны Ерөнхийлөгч энийг тодорхойлох юм уу? Энийг нэг албан тушаалтан нь хэлээд байх юм уу. Нөгөө энийгээ аваад тэр энийгээ аваад ир. Энийгээ аваад ир гээд

юу нь мэдэгдэхгүй нэг ийм юм уут сая нэмчхэж байгаа юм. Энэ бол нөгөө хөрөнгө оруулагчдаа бол их л тодорхойгүй л байдал бий болгоно.

Одоо бидний санал хураах гэж байгаа. Сая унисан 25.1-д Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк, түүний толгой компани нэгдэлд тавих шаардлагыг журмаар зохицуулахаар бид батлах гээд байгаа юм. Хөрөнгө оруулалтын банканд тавих шаардлага гэдэг чинь өөрөө хуульдаа л би байх ёстой шүү дээ. Хуульд заагдаагүй бичиг баримт шаардлагууд Монголбанкны дараагийн нэг дарга нь нэг юм тавиад л дараагийн дарга нь нэг юм нэмж тавиад л дахиад нэг юм тавиад л ийм эрх олгосон, тодорхойгүй, хуулийн техникээс ер нь татгалзах хэв маяг руу яваад байгаа шүү дээ. Нөгөө процессын шударга ёс гэж яриад байгаа юм. Тэгээд хэрэг дээр хууль тогтоох эрх мэдлийг шилжүүлээд байгаа байхгүй юу. Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороонд. Тэгээд бид нар энэ хуульдаа энэ банк байгуулахад ямар шаардлага тавих вэ гэдгийг нь хуульдаа биччих л ёстой байхгүй юу. Тэгэнгүүт нэмэлт шаардлагыг нь дахиад л Монголбанк тавина. Энгийг нь өөрөө тогтооно гээд л ийм эрх олгоод байгаа байхгүй юу. Энэ нь юу юм бүү мэд. Тэгээд тэрийгээ хянан шалгах журмыг Монголбанк өөрөө тогтооно гэж байгаа юм. Өөрөө зөвшөөрөл олгоно, өөрөө шалгана, өөрөө нэмэлт шаардлага тавина, дахиад хянана. Тэр журмаа өөрөө гаргана. Өөрөө журмаа гаргаад угаасаа өөрөө хянана шүү дээ. Тэгэхээр хуульдаа ер нь бичих боломжтой харилцаануудыг нь бичмээр байгаад байгаа юм. Аль болох л бичмээр байгаа юм. Боломжтой. Боломжгүй юм байж болохыг бол ойлгоод байна. Тэгэхдээ энэ чинь боломжтой юмнуудыг бичмээр байгаад байгаа байхгүй юу.

Виртуал хөрөнгийн хууль дээр бас баахан тийм юм орж ирсэн шүү дээ. Ерөөсөө л ингээд л Санхүүгийн

зохицуулах хороо бүх эрх мэдлээ бараг тэр хууль нь өөрөө жоохон хууль. Хууль дээр нь юу байна вэ гэхээр 10 хэдэн журмыг Санхүүгийн зохицуулах хороо гаргана гэдэгт хууль болчихсон байхгүй юу ер нь бол. Хэрэг дээрээ бас нэг тиймэрхүү их олон журмуудыг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо тэгээд өөрөө түүгээрээ батална, шаардлагаа өөрөө нэмнэ гэдэг ийм хууль болчих гээд байна. Энэ нь бол би нөгөө хөрөнгө оруулагч талдаа энийг уншиж байгаа гаднын ч бай, дотнын ч бай хөрөнгө оруулагч чин гээд уншихаар бүх юм харагддаг байх. Ёстой байхгүй юу. Тэгэнгүүт энийг уншингуут харагдахгүй байгаад байгаа байхгүй юу. Тэнд нэг журам гарах юм байна. Тэр журмаар бас зохицуулах юм байна гээд ингээд л нэг ийм асуудал үүсээд байна. Тэгэхээр боломжтой юмнуудыг нь хуульдаа тодотгох ийм чиглэл өгөх бололцоо гарах болов уу яах бол гэсэн л ийм л.../минут дуусав/

Г.Занданшатар: Ганибалын Амартүвшин гишүүн ажлын хэсэг.

Г.Амартүвшин: Зарчмын хувьд Энхбаяр гишүүн маш зөв ярьж байна л даа. Ер нь бид нар аль болохоор зөвшөөрлийн хуулийн ер нь үзэл баримтлал ч гэсэн аль болохоор журам гэдэг юмаар тэр зөвшөөрлийн шинж чанартай ийм зохицуулалтыг хийхгүй байхыг хичээсэн. Энэ хууль дээр ч гэсэн ажлын хэсэг энэ дээр эргэж ажиллая. Ер нь бол зөв. Яагаад гэвэл журам ингэчихээр Монголбанкны хяналт шалгалтын байцаагч нар үнэхээр нэг даам гарчихсан нөхөд байдаг юм. Шалгалт хийх болгондоо учир битүүлэг тийм журам болон бусад гэсэн томъёоллоор нэлээн тийм хүнд суртал учруулдаг. Энэ бол практик дээр байдаг асуудал. Тэгэхлээр энийг бид нар тодорхой болгоё. Шаардлагатай бол бусад дагалдсан хуулиуддаа нэмэлт, өөрчлөлт оруулж маш тодорхой болгоё.

Г.Занданишатар: Тайлбар ч байхгүй л дэмжсэн, дэмжээгүй л үг хэлнэ. Цэдэндамбын Цэрэнпунцаг гишүүн.

Ц.Цэрэнпунцаг: Энхбаяр гишүүний асуудлыг бас дэд ажлын хэсгийнхэнтэй бид нар ярилцсан юм. Тэгээд Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо бол хамтарсан журам гээд банкны салбар, банк санхүүгийн салбарыг зохицуулдаг нүсэр олон журамтай юм билээ. Бараг 100 гаран журам байдаг. Тэгэхээр эд нарыгаа буцаагаад бүгдийг нь детальчлаад хуульдаа тусгаад явахаар их том нарийн процесс, нарийн деталиуд байгаа учраас бүгдийг нь тусгаад явбал энэ хууль чинь өөрөө яг хэсэг нь бол нүсэр юм болох юм байна гээд. Тэгээд энэ бол тэр бүх журмууд нэг нэгэнтэйгээ уялдаатай байдаг учраас нэг журмын нэг хэсгийг нь аваад л оруулаад явна гэдэг бол бас учир дутагдалтай. Бас л ийм асуудал гарч ирэх юм байна гээд энэ олон журмыг чинь бид нар алийг нь тусгаж, яаж бүгдийг нь юундаа тусгах вэ гэдэг бас хэцүү юм байна гэж ярьсан юм. Энхтайван дахиад тайлбарлаад нэмээд тайлбарлах уу?

Г.Занданишатар: Монголбанкны хянан шалгалтын журам энэ тэр бол тэр үедээ эрх зүйн акт шиг маш чанга л байдаг байсан. Одоо ч журам хүн тоохгүй болчихоор уул нь журмаар зохицуулж нааш цааш тоо хөдөлгөдөг юмнууд байдаг л даа. Тэгээд гүйцээн боловсруулах чиглэл өглөө.

Дараагийн асуудал. 29. Төслийн Тавдугаар бүлгийн гарчгийн “Хариуцлага” гэснийг “Бусад” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт 52.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

30.Төслийн 18 дугаар зүйлийг 26 дугаар зүйл болгон, доор дурдсанаар бүхэлд нь өөрчлөн найруулах:

“26 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

26.1.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хууль болон бусад холбогдох хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Бөхчулууны Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Миний хурууны хээ долоовор хуруун дээр бас жоохон будилаад байна. Сая долоовор хуруу хийчихсэн чинь кноп буруу дарагдчихлаа. Дахин санал хураалгаж өгнө үү.

Г.Занданишатар: Пүрэвдорж гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. 59.5 хувийн саналаар санал дэмжигдлээ. Бараг төсөл нь ч илүү байсан л юм байна даа. Горимын санал дэмжигдсэн учраас санал хураалтыг дахиж явуулъя. 59.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

31.Төсөлд доор дурдсан агуулгатай 27 дугаар зүйл шинээр нэмэх:

“27 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

27.1.Энэ хуулийг 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 57.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хоёр.Эдийн засгийн байнгын хороо дэмжээгүй санал:

1.Төслийн 5 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 5.2 дахь хэсэг шинээр нэмэх:

“5.2.Хөрөнгө оруулалтын банкны дүрмийн сан 500 тэрбум төгрөгөөс доошгүй байна.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдорж.

Бөхчулууны Пүрэвдорж гишүүн үг хэлнэ.

Б.Пүрэвдорж: Би 500 тэрбум байх тухай саналыг яагаад гаргасан бэ гэхээр анхны гишүүдийн 2016 онд өргөн барьсан төсөл дээр энэ байсан учраас энийг Монголбанк руу эрхийг нь авч байгаа хэдээр дүрмийн сангаа би болгохоо Монгол банк эрх авч байгаа учраас энийг 500 болгож өгч байгаа юм л даа. Тэгэхээр ер нь бол яах вэ 500 хадмал тоо тавивал буруу гэж бас ажлын хэсэг үзэж байгаа юм байна. Тэгэхдээ нэг зүйлийг бас хэлэхэд тооцох нэгжээр оруулмаар санагдаад байх юм. Өөрөөр хэлбэл тэдэн тооцох нэгжтэй тэнцүү байна гэж. Нэг тооцох нэгж нэг доллартой тэнцүү гэдэг. Тэгээд дүрмийн сан, хани уналт энэ тэр болохоор дүрмийн сан тухайн үед 500 тэрбум чинь 200 сая доллар байсан бол өнөөдөр 140 сая доллар болчихсон байна шүү дээ. Тэгэхээр тооцох нэгжээр оруулж өгөх юм бол нөгөө хани уналт боллоо гэхэд дүрмийн сангаа төгрөгөөр нэмэгдүүлэх тэр ажлуудаа хийх ёстой байхгүй юу даа. Ийм зүйлийг заавал оруулахгүй бол болохгүй байна. Тэгээд анхнаасаа бичээгүй л дээ. Тэгэхээр ер нь бол яах вэ? Монголбанк журмаа гаргахдаа бас тооцох нэгжийг бас харгалзаж үзэх ийм шаардлага гарч байна.

Хоёрдугаарт нь хууль дээр нэг этгээдээс татан төвлөрүүлэх хөрөнгө дээр хязгаар байхгүй байгаа. Энэ бол банкиг нэг этгээд татан төвлөрүүлэх хөрөнгөө нэмэгдүүлсээр байгаад тэр банкны бүрэн эзэн болох шийдвэр гаргах түвшинд нөлөөлөх ийм нөхцөл рүү аваачна. Энэ банк тэгэх юм эрсдэлд орно. Тийм учраас хэдийгээр банк дотоод болон хадгаламж болон бусад зүйлийг татан төвлөрүүлэхгүй ч гэсэн дүрмийн сангийн 20 хувь ч байдаг юм уу 30 хувь ч байдаг юм уу 50 хувь ч байдаг юм уу тэр хүртэлх хэмжээнд л нэг этгээдээс татан төвлөрүүлэх хөрөнгөө олон субъектээс авах юм яах вэ энэ банкны хариуцлага илүү сайжрах хяналт нь сайжраад илүү сайн болох ийм боломжтой байхгүй юу даа. Тэгээд энэ болгон дээр бас яг эцсийн хэлэлцүүлэг

дээр Цэрэнпунцаг Байнгын хорооны дарга энэ дээр бас нэг анхаарч үзээрэй. Миний хэлсэн үгтэй холбоотой Та бүхэн тэмдэглээд авах байх. Энэ хани уналтаас хэрхэн яаж дүрмийн сангийн хамгаалалтыг хийх вэ, яаж нэмэгдүүлэх вэ, дээрээс нь энэ банкны хариуцлага олон талт этгээдээс эх үүсвэр татах юм илүү олон талын хяналт орж ирээд банк илүү хариуцлагатай ажиллах ийм боломж бол бүрдэнэ гэж үзэж байгаа. Энэ дээр бас бодоорой гэж хэлье. Баярлалаа.

Г.Занданшатар: Саналаа татаж авч байгаа юм уу. Санал хураалт явуулъя. Гишүүд анхааралтай. Санал хураалт 59.5 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд

Төслийн гарчгаас “, өөрчлөлт” гэснийг, төслийн 1 дүгээр зүйлийн “, заалт” гэснийг, мөн зүйлийн 2 дахь заалтыг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 52.4 хувийн саналаар санал хэмжигдлээ.

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар санал хураалт явуулъя.

Төслийг хууль санаачлагчид нь буцаах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 57.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хууль санаачлагчид буцаах тухай Улсын Их Хурлын тогтоол батлагдсанд тооцлоо. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.10 дахь

хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь

Монгол Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан нарын 18 гишүүнээс 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдөр Монгол Улсын Их Хуралд Хөрөнгө оруулалтын банкны тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай төслийг буцаах нь зүйтэй гэсэн Байнгын хорооны санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдааны санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул уг төслийг хууль санаачилсан нь буцаасугай.

Эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Алга байна. Тогтоол батлагдсанд тооцлоо. Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Гишүүд ажлын хэсэгт баярлалаа. Хөрөнгө оруулалтын банкны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлж байна.

Ингээд үдээс өмнөх хуралдааныг завсарлуулж байна. Одоо даргын дэргэдэх зөвлөл хуралдана. Даргын дэргэх зөвлөлийн хуралтай.

12.30 цагт

ЗАВСАРЛАГА.

Г.Занданишатар: 14 цаг болсон байна. 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн үдээс хойших нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье. Үдээс хойших нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээлэл сонсоно.

Монгол Улсын Төрийн цахим шилжилтийн өнөөгийн нөхцөл байдал, цаашидын зорилтуудын талаар танилцуулна.

Цөөнхийн бүлэг асуулт асууж, хариулт авах учраас цөөнхийн гишүүдийг чуулганы танхимд урьж байна. Танхимд цөөнхийн бүлгийн гишүүдийг урьж байна. Монгол Улсын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 19.1-д заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг танилцуулъя. Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Төсвийн байнгын хороонд хуваарилсан байна. Засгийн газраас өргөн мэдүүлсэн.

Бооцоот морин уралдааны тухай хуулийн төсөл хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Хууль зүйн байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороонд хуваарилсан байна.

Бооцоот таавар, хонжворт сугалааны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Эдийн засгийн болон Хууль зүйн байнгын хороонд хуваарилсан.

Казиногийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд Засгийн газраас 12 дугаар сарын 26-ны өдөр мэдүүлсэн Эдийн засгийн болон Хууль зүйн байнгын хороонд хуваарилсан байна.

Одонтуяа гишүүн ээ, эхлүүлэх үү. Ардчилсан намын бүлгийн дарга Цогтгэрэл гишүүн асуулт асууж, үг хэлэх ёстой. Ардын намын бүлгээс Цагаанхүүгийн Идэрбат гишүүн мэтгэлцэнэ. Мэтгэлцэгчээр. Хэлэлцэх асуудалд орно.

Монгол Улсын төрийн цахим шилжилтийн өнөөгийн байдал, цаашидын зорилтуудын талаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Ням-Осорын Учрал мэдээлэл хийнэ. Индэрт урьж байна.

Н.Учрал: Улсын Их Хурлын дарга,
Эрхэм гишүүд ээ,

Илүү өндөр хурдаар илүү өргөн хүрээнд Монгол Улс цахим засаглал, цахим технологи, цахим соёлд шилжих зорилго, зорилтуудыг төрөөс баталсан бодлогын баримт бичгүүдэд нэн тодорхой заасан.

Та бүхний үзэл бодлоо уралдуулан хэлэлцүүлэн баталсан Хөгжлийн урт, дунд хугацааны 4 томоохон хөтөлбөр, цахим шилжилтийн хүрэх цэг, биелүүлэх зорилт, хийх ажил шийдэх асуудлуудыг иж бүрэн харуулсан газрын зураг гэж хэлж болно. Энэ бол Улсын Их Хурлаас баталсан Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Алсын хараа 2050, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, шинэ сэргэлтийн бодлого дунд хугацааны зорилтот хөтөлбөр юм. Хөгжлийн хөтөлбөрт төрийн үйлчилгээ үйл ажиллагааг цахимжуулах, хөдөө орон нутаг, иргэдийн харилцаа холбоо өндөр хурдны интернэт сүлжээнд холбох, Цахим мэдээллийн нэгдсэн сан, дэд бүтцийг бүтээн хөгжүүлэхээр төлөвлөсөн. Хөгжлийн бодлого, хөтөлбөрт тусган батлуулсан зорилтуудыг хэрэгжүүлж цахим шилжилтийг үндэсний хэмжээнд нэгдсэн бодлого, удирдлага, зохион байгуулалтаар хангах, эрчимжүүлэх чиг үүрэг бүхий харилцаа холбоо, мэдээлэл технологийн асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болох Цахим хөгжил, харилцаа холбооны яамыг 2022 оны 01 дүгээр сард Монгол Улсын түүхэнд анх удаа байгуулсан. Цахим хөгжил, харилцаа холбооны яам Монгол улсын хөгжлийн бодлого, хөтөлбөрүүдэд тусгасан зорилго, зорилтуудад нийцүүлэн цахим үндэстэн болох санаачилгыг бодит үр дүнд хүргэх үндсэн 6 зорилтыг дэвшүүлэн ажиллаж байна. Үүнд:

Дижитал дэд бүтцийн бэлэн байдлыг хангах, цахим засаглалыг

хөгжүүлэх, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, тоон бичиг үсгийн чадавхыг дээшлүүлэх, инновац үйлдвэрлэлийг хөгжүүлэх үндэсний хөгжлийн хурдасгуур байхад оршино.

1.Дижитал дэд бүтцийн бэлэн байдлыг хангах чиглэлээр

Харилцаа холбоо, мэдээлэл технологийн өдрөөс өдөрт өндөр хурдтайгаар өсөн нэмэгдэж байгаа эрэлт хэрэгцээнд нийцэхүйц суурь дэд бүтцийн бэлэн байдлыг хангах хүрээнд дамжуулах сүлжээний багтаамжийг өсгөх, үнэ тарифыг бууруулах бодлого боловсруулж сүүлийн 4 жил шат дараалсан арга хэмжээ авч ажилласны үр дүнд дамжуулах сүлжээний багтаамж 2017 онд 12.5 гигабайт байсан бол 2021 онд 2112 болж 168 дахин нэмэгдсэн. Сүлжээний хэрэглээ 3.8 гигабайт байсан бол 2021 онд 79.5 болж 20 дахин өсөж нэгж үнэ тариф дунджаар 39.5 мянган төгрөг болж 7.4 дахин хямдарлаа. Үнийн өсөлтийн олон тоо статистикийн дунд төдийлөн харагдаж онцлогдохгүй болохоос бус интернэтийн үнэ тариф мөн буурсан сайн мэдээ байна.

Үр дүн нь тоо статистикаар хязгаарлагдахгүй амьдралд гарч байгаа бодит чанарын өөрчлөлтөөр хэмжигдэнэ. Үнэ буурахын хэрээр орон даяар интернэт хэрэглээ өсөж байна. Олон улсын цахилгаан холбооны байгууллагаас гаргасан үзүүлэлтээр 2021 онд Монгол Улсын нийт хүн амын 84 хувь нь интернэт хэрэглэдэг, өрхийн 80 хувь нь интернэт хандалттай, 33 хувь нь компьютертой байна. 4G сүлжээнд хамрагдалтаар 143 орнууд 146-дугаар байрт, 3G сүлжээний хамрагдалтаар 144 орноос 14 дүгээр байранд орж байна. 2022 оны эхний хагас жилийн байдлаар харилцаа холбооны тусгай зөвшөөрөл үйлчилгээ эрхлэгч байгууллагуудад 11,915 хүн ажиллаж, үйл ажиллагааны орлого нь 909.7 тэрбум болж, өмнөх оны үеэс 19.8 хувь, төсөвт төвлөрүүлсэн орлого

нь 15 хувиар нэмэгдэж 151 тэрбум төгрөгт хүрлээ. Хот хоорондын шилэн кабелийн урт 40760 километр. Хот доторх шилэн кабелийн урт 7223 километрт хүрч, шилэн кабельд холбогдсон сумын тоо 227 боллоо. Интернэт гарцын багтаамж 570 гигабайт болж, өмнөх оны мөн үеэс 32 хувиар нэмэгдлээ.

Мөн Монгол Улсаар дамжиж байгаа олон улсын интернэтийн транзит урсгалын хэмжээ 2022 оны 6 сарын байдлаар 1410 гигабайт болж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 24.1 хувиар нэмэгдсэн байна. Улсын хэмжээнд нийт 1537 байрилд 4G сүлжээний бааз станц ажиллаж 4G сүлжээний нийт хэрэглэгчдийн тоо 2.9 сая болж мөн өмнөх оны үетэй харьцуулахад 9.37 хувиар, хэрэглэгчдийн үүсгэсэн дата хэрэглээ өмнөх оны үетэй харьцуулахад 26.2 хувиар өслөө. Өнөөгийн байдлаар Монгол Улсын нийт сумдын 97 хувь буюу 326 сум шилэн кабелийн сүлжээнд холбогдсон ба үлдсэн 5 сумыг 2025 онд багтаан дотоод, гадаадын эх үүсвэр, шилэн кабелийн сүлжээнд холбох ажлыг хийж гүйцэтгэнэ.

Дараагийн шатанд томоохон багуудыг шилэн кабелийн сүлжээнд холбохоор зорьж ажиллаж байна. Уг зорилтын хүрээнд 2022 онд бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн санхүүжилтээр Өвөрхангай аймгийн Уянга сумын Жаргалант багийг 60 километр урт шилэн кабелиар холболоо. Мөн Улаанбаатар хот болон зарим аймгийн харилцаа холбооны дэд бүтэц хүрээгүй захын гэр хорооллын 3500 өрхөд суурин интернэт үйлчилгээг хүргэх зорилгоор 154 километр урт шилэн кабель тус тус суурилуулж өндөр хурдны өргөн зурвасын суурин интернэт сүлжээг байгууллаа. Мөн алслагдсан 275 багт үүрэн холбооны 4G сүлжээ нэвтрүүлснээр 300 мянга орчим иргэн өндөр хурдны хөдөлгөөнт интернэтэд холбогдож мэдээ, мэдээлэл шуурхай авах, аялагч, амрагчид, харилцаа холбооны

бусад үйлчилгээг саадгүй, шуурхай авах боломжийг бүрдүүллээ.

Монгол Улсад Хөдөлгөөнт холбооны 5 дахь үеийн технологи болох 5G нэвтрүүлэхэд баримтлах чиглэл болон радио давтамжийн ашиглалт, үйлчилгээний төлбөрийн хэмжээ тогтоох аргачлалыг шинэчлэн баталж 5G технологийн техникийн туршилтыг амжилттай хийлээ. Хөдөлгөөнт холбооны дараа үеийн 5G үйлчилгээг 2023 оноос нэвтрүүлж эхлэхээр ажиллаж байна. 5G технологийг нэвтрүүлснээр өндөр хурдны интернэт машин хоорондын холбоо, юмсын интернэт үйлчилгээ хөгжиж, харилцаа холбоо, эрүүл мэнд, дэд бүтэц, тээвэр автоматжуулалтын салбарт томоохон дэвшилийг авчрах болно.

Сансар судлалыг хөгжүүлэх, үндэсний хиймэл дагуулыг хөөргөх, сансрын технологийн мэдээлэл боловсруулан ашиглах үйл ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр Монгол Улсад сансар судлалыг хөгжүүлэхэд баримтлах чиглэл, 2023 оноос 2033 оны стратегийг батлан хэрэгжүүлж эхэллээ. Улмаар харилцаа холбооны хиймэл дагуулыг бүтээх, хөөргөх, эзэмших, ашиглах техник эдийн засгийн урьдчилсан судалгааг хийж, хиймэл дагуулын төлөвлөлтийг шинэчлэн боловсруулж, Нэгдсэн үндэсний байгууллагын харьяа Олон улсын цахилгаан холбооны байгууллагад бүртгүүлээд байна. Энэ бол тэр бүр нүдэнд харагдаж, гарт баригддаггүй ч дижитал дэд бүтэц бүтээн байгуулж 24 цаг найдвартай ажиллагааг нь хангаж улс орон даяар Монгол Улсын иргэдийнхээ өдөр тутмын ажил амьдралд үр дүнг нь хүргэж байгаа харилцаа холбооны салбарын 12000 шахам инженер техникийн ажилтнууд, ажилчид, хувийн хэвшил ба төрийн хамтдаа үүрсэн ахиц амжилт, дэвшил юм.

2.Цахим засаглал хөгжүүлэх чиглэлээр

Цахим засаглал бол сайн засаглал. Хувь хүн бус технологи засагладаг тогтолцоо. Эдийн засгийн хувьд өндөр бүтээмж, өрсөлдөх чадвар, үр ашиг өгөөж нэмдэг засаглал. Шударга ёсны хувьд авлигын хөрс тэжээл болсон хүнд суртал, элдэв чирэгдлийг устгаж хэн бүхэнд ил тод, нээлттэй шилэн 24 цаг гэрэл асаах засаглал бол цахим засаглал. Цахим засаглалыг хөгжүүлэх талаар дараах ажлуудыг хийж зарим тулгамдсан асуудлыг шийдвэрлэлээ.

Цахим гарын үсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад тусгасны дагуу тоон гарын үсгийн ашиглалтыг нэмэгдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. 2022 оны 12 дугаар сарын 30-ны байдлаар 398974 иргэн, 85730 хуулийн этгээд, 14249 төрийн албан хаагч тоон гарын үсэгтэй болоод байна. Төрийн мэдээлэл солилцооны үндсэн систем ХУР-д төрийн 108 байгууллага, хувийн хэвшлийн 269 байгууллага холбогдож 566 төрлийн хязгаарлалттай мэдээллийг 1.1 тэрбум удаа солилцсон байна. Танилт нэвтрэлтийн дан системд 1689943 хэрэглэгч бүртгэгдэж төрийн 47 байгууллага, хувийн хэвшлийн 111 байгууллагын 218 систем ашиглаад байна. Төрийн үйлчилгээний И-Монголиа системд 71 төрийн байгууллагын 806 үйлчилгээг холбож, 1484723 хэрэглэгч бүртгүүлж 20.8 сая удаа цахим хэлбэрээр төрийн үйлчилгээг авч 123 тэрбум төгрөгийн шууд бус зардлыг хэмнэжээ.

Төрийн үйлчилгээний нэгдсэн систем буюу И-Монголиа системээр дамжуулан хүлээн авах боломжтой лавлагаа тодорхойлолтыг төрийн байгууллага, албан тушаалтан нотариатаар заавал гэрчлүүлэх шаардлагагүй боллоо. Иргэний болон жолооны үнэмлэх, төрсний, гэрлэсний, нас барсны, оршин суугаа хаягийн, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн зэрэг 74 лавлагаа, тодорхойлолт үүнд багтаж байна.

Төрийн мэдээлэл солилцооны И-Монголиа системээр нотариатын үйлчилгээ үзүүлсэн талаарх лавлагаа, тодорхойлолт, гэрээний цахим хувилбарыг олгох боломжийг хамтран бүрдүүлэх, цахимаар нотариатын үйлдэл хийх платформыг хөгжүүлэх, тоон гарын үсгээр иргэн, хуулийн этгээдийн хувийн байдлыг тогтоож баталгаажуулан үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, Нотариатын үйлчилгээ үзүүлэхэд нийтийн мэдээллийн дэд бүтцийг ашиглах зэрэг нотариаттай холбоотой асуудлуудыг цэгцлэхэд томоохон ахиц гаргаж ажиллаж байна.

Үйлчилгээний байгууллагууд иргэдээс заавал цаасан хэлбэрээр хэвлэж авч ирэхийг шаарддаг байсан лавлагаа, тодорхойлолтыг иргэний өөрийнх нь зөвшөөрлийн үндсэн дээр авах боломжийг бүрдүүлж lavlagaa.emongolia.mn цахим системийг 2022 оны 12 дугаар сард нэвтрүүлээ. Эхний 1 сарын хугацаанд 11 байгууллагын 69 нэр төрлийн лавлагаа, тодорхойлолтыг 15000 удаа олгосон үзүүлэлт байна.

Төрийн байгууллагын хэмжээнд албан хэрэг хөтлөлтөд ашиглагддаг хоорондоо ялгаатай холбогддоггүй 15 өөр системийг нэг дор холбосон docx цахим системийг нэвтрүүлснээр төрийн 5483 байгууллага дотоод удирдлагын нэгдсэн системийн өөр хоорондын ялгаатай байдлаас үл хамаарч цахим хэлбэрээр албан бичиг солилцдог болж цаг, мөнгө цаасны зардал хэмнэх боломж, өдөр тутмын ердийн хэвшил болж эхлэх эхлэл тавигдлаа.

Монгол Улс Нэгдсэн үндэсний байгууллагаас эрхлэн гаргадаг Цахим засаглалын хөгжлийн индексээр 2022 онд 18 байраар урагшилж 74 дүгээр байранд орлоо. Монгол Улсын Их Хурлаас 2021 оны 12 дугаар сарын 17-нд баталсан Нийтийн мэдээллийн ил тод байдлын хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах хууль, Кибер аюулгүй байдлын тухай

хууль, Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтэд анхаарч дээрх хуулиудыг дагалдан гарах 17 журмыг Засгийн газрын Тогтоол болон Цахим хөгжил Харилцаа холбооны сайдын тушаалаар батлуулан мөрдөж эхэллээ.

Цахим шилжилтийн хууль эрх зүйн орчин, цахим хувьсгалын тохироог бүрдүүлэхэд онцгой анхаарч ажилласан Улсын Их Хурал, Улсын Их Хурлын дарга, гишүүдэд талархал илэрхийлье.

Хууль зүй, дотоод хэргийн яамтай хамтран төрийн байгууллага хооронд болон төр хүн хуулийн этгээдийн цахим хэлбэрээр мэдээлэл солилцох нөхцөлийг сайжруулах, хүн, хуулийн этгээдийн төрийн байгууллагаас авах үйлчилгээний зардлыг бууруулах, төр цахим үйлчилгээ хийхтэй холбоотой хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхэд бэлтгэж байна. Хүчин төгөлдөр үйлчилж байгаа нийт 430 хуулийг судалж үзэхэд бичгээр буюу цаасан хэлбэрээр гэсэн агуулга бүхий үг хэллэгтэй 169 хуулийн 869 хэсэг илэрлээ. 169 хуулийн 869 заалт бүгдээрээ цахим шилжилтийн өмнө хөндөгдсөн цаасан саад юм. Цаасан хүнд суртлаас цахим хөнгөн сурталд хурдан шилжихийн тулд цаасаар, өөрийн биеэр, бичгээр гэх зэрэг үг хэллэгтэй хүний хүчин зүйлээс хамаарсан хүндрэлүүдийг арилгахаар ажиллаж байна.

Төрийн уламжлалт үйлчилгээг шинэ шатанд гаргаж, цахим төрийн үйлчилгээний нэр төрөл, чанар стандарт хүртээмжийг сайжруулах үндсэн чиг үүрэг бүхий төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрыг 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар Цахим хөгжил, харилцаа холбооны яамны дэргэд байгууллаа. Хурдан төрийн үйлчилгээний төв цэгүүдээ Монгол Улсын иргэний ажил, гэр хаанаас ч ойрхон байж хүрч

үйлчлэхээр бэлтгэлээ Бид базааж байна. Нийслэлийн 6 дүүргийн үйлчилгээний нэгдсэн төв, Улаанбаатар хот дахь Төрийн үйлчилгээний 59 цэг, 21 аймаг дахь Үйлчилгээний нэгдсэн төв, 309 сум суурин газар нийт 389 байришлд хурдан төрийн үйлчилгээний төв цэгүүд нээгдэж төр танд хурдан үйлчилнэ. Нэг цэгээр төрийн 443 төрлийн үйлчилгээг авах боломжийг бүрдүүлнэ.

Өнгөрсөн 30 жилийн туршид иргэн нь төрийнхөө зүг явж ирсэн бол энэ оны эхний улирлаас төр нь иргэн рүүгээ хүрч очин үйлчилдэг шинэ хандлага, шинэ соёл, шинэ стандарт, шинэ зүг чиг тогтоно гэсэн үг. Заавал Дүнжингарав шиг нэгдсэн үйлчилгээний төв рүү явах шаардлагагүй болно. Ажилдаа очих, гэртээ харих замдаа хаанаас ч ойрхон хурдан түцээр үйлчлүүлж цаг мөнгөө хэмнэнэ. Нэгдсэн үйлчилгээний төв дотор төрийн байгууллагуудын нэг цонхноос нөгөө цонх руу хооронд очдог оочир дараалал үүсгэдэг төлбөр мөнгө төлөх гэж нааш цааш явалгүй нэг цонхноос бүгдийг авах шийдлийг боловсруулсан.

Үүрэн холбооны операторууд, банкнууд франчайзын сүлжээ дэлгүүрүүд, түргэн хоолны салбарууд шиг стандарттай, соёлтой, хурдтай, хүртээмжтэй үйлчилж, төр хүнд суртлаас хөнгөн сурталд шилжихэд бодитой алхам хийнэ. Хурдан түцнээс эхний ээлжид и-монголиагаас гар утаснаасаа авдаг 2 дахин олон төрлийн үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлнэ. Иргэн бүрд ухаалаг гар утас, бичиг баримт хэвлэх төхөөрөмж байхгүй. Интернэтийн дата бүх хүнд хязгааргүй биш Хөдөө орон нутагт салбаргүй төрийн байгууллагаар ч аймаг сумаасаа үйлчлүүлэх өргөн сонголтыг нээж байна. Ховдоос хот руу Увсаас Улаанбаатар Луу алслагдсан сумаас аймгийн төв рүү мах, шөлөө базаагаад машин онгоцоор алга дарам цаасны төлөө ирж очих чирэгдлийг устгах болно.

3. Мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр

Цахим орчинд үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцоог бүрдүүлж орчин үеийн техник технологийг нэвтрүүлж төр, хувийн хэвшил, иргэний мэдээллийн аюулгүй байдлын мэдлэг, ойлголтыг дээшлүүлж мэдээллийн бүрэн бүтэн нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг хангах талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

Манай улсын кибер аюулгүй байдлыг хангах тогтолцоог бэхжүүлж, онц чухал мэдээллийн дэд бүтцийг хамгаалах, кибер аюулгүй байдлыг хангах, боловсон хүчнийг чадавхжуулах, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх, кибер халдлага, зөрчилтэй тэмцэх бүтцийг бүрдүүлэх зорилго бүхий кибер аюулгүй байдлын үндэсний стратегийг Засгийн газрын хуралдаанаар батлууллаа. Тус стратеги 5 үндсэн зорилттой бөгөөд 2027 он хүртэл 2 үе шаттайгаар хэрэгжинэ. Үндэсний аюулгүй байдал, нийгэм, эдийн засагт хохирол учруулж болохуйц мэдээллийн систем, мэдээллийн сүлжээ бүхий онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй төрийн 134 байгууллага, хувийн хэвшлийн 82 байгууллагыг тодорхойлж, Засгийн газрын 2022 оны 207 дугаар тогтоолоор жагсаалтыг батлууллаа. Эдгээр байгууллагууд кибер аюулгүй байдлыг өндөр түвшинд хангаж хариуцсан мэдээллийн системийн хэвийн тасралтгүй үйл ажиллагааг хангаснаар төрийн тогтвортой үйл ажиллагаа иргэдийн тайван амьдрах орчныг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой юм. Хүний хувийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах нь дэлхий дахинд тулгамдсан асуудал болоод байна. Монгол Улс хүний хувийн мэдээллийг хамгаалах хуультай болж, салбар бүрд хүний хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, аюулгүй байдлыг хангах, хүн өөрийн мэдээллийн эзэн байх эрхийг хамгаалсан зохицуулалтыг тодорхой болгосон.

Хуулийн хүрээнд хүний биометрик мэдээлэл буюу дахин давтагдашгүй биеийн өгөгдөл болох 637024 иргэний гарын хурууны хээ 2464 байгууллага цугларсан байсныг шалгаж тогтоон их цэвэрлэгээ хийлээ. Мөн хүний хувийн мэдээлэлд гуравдагч этгээд хандсан тухай мэдэгдэл хүргэх системийг 2022 оны 05 дугаар сарын 1-ээс нэвтрүүлж, 12 дугаар сарын 26-ны өдрийн байдлаар нийт 14457136 удаа иргэддээ мэдээллийг хүргэж хүргээд байна.

Олон улсын цахилгаан холбооны байгууллагаас 2 жил тутам гаргадаг кибер аюулгүй байдлын индексийн судалгаагаар манай улс 2017 онд 104 дүгээр байр, 2018 онд 85 дугаар байр, 2020 онд 120 дугаар байранд тус тус эрэмбэлэгдсэн. Дэлхий хавтгайрч даяаршиж, хил хязгааргүй болохын сүүдэртэй тал нь дэлхийн аль ч цэгээс хэн нэгэн этгээд компьютерын араас улс орнууд компаниудад кибер халдлага хийж, хувь хүний нууцад халдан хохироох болсон. Кибер халдлага нь биет байдлаар довтлох халдлагаас дутахгүй илүү уршиг учруулж хохироосон олон жишээг дэлхийгээс төдийгүй Монголоос харж болно. Өдөр тутам мэдээлэл хулгайлах, эд хөрөнгө залилах, хүний наймаа, хөдөлмөрийн мөлжлөг, айлган сүрдүүлэх гэх мэт үй олон дэлхийг хэрсэн гэмт хэргүүд гаарч байна.

Өнөөдрийн байдлаар төрөөс иргэн рүү чиглэсэн төрийн цахим үйлчилгээ, цахим системийн ер гаруй хувь нь Үндэсний дата төв УТҮГ-ын дэд бүтцийн шууд хамааралтай ажиллаж байна. Дата төв дээр байрлаж байгаа төрийн байгууллагын системүүд рүү 2022 оны байдлаар 22 тэрбум удаа хандалт хийгдэж байгаагаас 33 хувь нь халдлагын шинж чанартай хандалт хийгдсэн байна. Энэ тоо жил бүр нэмэгдэх хандлагатай байна. Бид өнгөрсөн хугацаанд төрийн байгууллагууд руу чиглэсэн халдлагыг тоолж чаддаг хэдий ч хувийн хэвшил рүү чиглэсэн халдлагыг өнөөдрийг хүртэл

нэгдсэн байдлаар хянах боломжгүй явж ирлээ.

Цаашид иргэн, хуулийн этгээдийн кибер халдлага, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох, хариу арга хэмжээ авах мэдээллийн системийг нөхөн сэргээх үйл ажиллагааг зохицуулж, мэргэжлийн удирдлагаар хангах, нийтийн төвийг байгуулан үйл ажиллагааг жигдрүүлж, кибер халдлага зөрчилтэй тэмцэх, олон улсын болон гадаад улсын байгууллагатай мэдээлэл солилцох, харилцан туршилага солилцох, хамтын ажиллагааг өргөжүүлэх бодлого барин ажиллаж байна.

Цаашид цахим орчинд хүний эрхийг хамгаалах, цахим хүчирхийлэл, цахим гадуурхлаас сэргийлэх, хүний эрхийг дээдэлсэн хууль эрх зүйн орчныг бүрдүүлж ажиллана.

4.Тоон бичиг үсгийн чадавхыг дээшлүүлэх чиглэлээр

Үндэсний статистикийн хороо, Харилцаа холбоо, мэдээлэл технологийн газар хамтран 2021 онд хийсэн өрхийн болон хувь хүний мэдээлэл харилцаа холбоо, технологийн хэрэглээ, судалгаанд оролцогчдын 43.8 хувь нь мэдээллийн ур чадвартай, 38.8 хувь нь харилцаа холбооны ур чадвартай, 27 хувь нь асуудал шийдвэрлэх ур чадвартай, 9.8 хувь нь программ хангамжийн ур чадвартай ердөө 6.4 хувь нь аюулгүй байдлын ур чадвартай гэдэг үзүүлэлт гарсан. Мэдээллийн аюулгүй байдлаа хамгаалах чадвар 10 хүний нэгд ч хүрэхгүй байна гэсэн үг. БНСУ-ын Үндэсний мэдээллийн нийгэмлэгийн агентлагийн буцалтгүй тусламжаар цахим ур чадвар олгох төвийг байгуулж шинэ оны босгон дээр үйл ажиллагааг нь эхлүүлээ.

Энэхүү төв нь бүх нийтийн цахим ур чадварыг нэмэгдүүлэх, тэр дундаа харааны бэрхшээлтэй иргэдэд төрийн үйлчилгээ хүртээмжтэй хүргэх талаарх

сургалт, судалгааг зохион байгуулж Үндэсний контент үйлдвэрлэгчдийг дэмжиж ажиллана. Мэдээллийн технологи, харилцаа холбооны салбарын хүний нөөц, ялангуяа төрийн албанд тулгамдаж байгааг онцгойлон анхаарах шаардлагатай. Төрийн байгууллагын 87 хувьд нь программ хангамж, мэдээллийн сүлжээ, мэдээллийн аюулгүй байдал, мэдээллийн технологи, мэдээллийн систем, өгөгдлийн шинжилгээ, хиймэл оюун ухаан, автоматжуулалтын систем хариуцан ажиллах нарийн мэргэжилтэн байхгүй байна. Энэхүү асуудлыг шийдвэрлэх хүрээнд мэдээллийн технологийн салбарт хүлээн зөвшөөрөгдсөн олон улсын мэргэжлийн холбоо стандартын байгууллагаас олгогддог сертификатын жагсаалтыг баталж дээрх мэргэжлээр их дээд сургууль төгсөж, дипломын боловсрол эзэмшээгүй ч олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн сертификат авсан ур чадвар эзэмисэн амжилтын бодит түүхтэй мэргэжилтнүүдийг мэдээллийн технологийн салбарт ажиллах боломжийг хангаж, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын тушаалыг гаргаж ажиллаж байна.

5.Инновац үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлээр

Мэдээллийн технологи, их өгөгдөл, хиймэл оюун ухаан, блокчэйнд суурилсан платформууд, программ хангамж, Үндэсний тоон контентыг хөгжүүлж, эдийн засгийн шинэ секторыг хөгжүүлэх инновац үйлдвэрлэл зорилтын хүрээнд оюун ухаанаа олборлоё санаачилгыг хэрэгжүүлж мэдээллийн технологийн салбарын эдийн засгийн салбарт эзлэх хувийг нэмэгдүүлэх, тус салбарын хүний нөөцийг чадавхжуулах хөрөнгө оруулалтыг татаж уул уурхайн түүхий эдэд суурилсан эдийн засгаас ухаан мэдлэг оюун санаагаа олборлон нэмүү өртөг үнэ цэн шингэсэн эдийн засгаа бүтээн босгохын төлөө ажиллаж байна. Үүний бодит эхлэл болгож төрийн программ хангамжийн их дэлгүүр

mindgolia.mn-ийг нээлээ. Одоогоор тус системд 121 компанийн 188 бүтээгдэхүүн тавигдаж том жижиг шинэ, хуучин гэлтгүй үнэн чанар аюулгүй байдал, хялбар шийдэл зэргээрээ гарааны ижил тэгш харьцуулсан чөлөөт өрсөлдөөнд орж байна.

Төрийн байгууллагууд программ хангамж бүтээж хөгжүүлэх гэж хувийн хэвшилтэйгээ өрсөлддөггүй, ажиллах хүчнийг нь булаалддаггүй тус тусдаа мөрөөдлийн жагсаалт гаргаж тендер зарлан өөр хаана ч ашиглагдахгүй холбогдохгүй системийг захиалдаг давхардал хийдэл үүсгэдэг оюуны өмч их кодыг нь нэхдэг ухаалаг бус худалдан авалтыг цэгцлэх, бүгдийг нэг дороос харьцуулан сонгох боломжийг бүрдүүлж байна.

Дэлгүүрийн туршилтын сарын хугацаанд төрийн өмчийн хөдөө орон нутгийн 248 сургууль нэгэн программыг хэрэглэснийхээ хэрээр төлөх нөхцөлөөр худалдан авч ашиглаж байна. Тус тусдаа тендер зарлахгүй, гар утсан дээрээсээ өөрт тохирох аппликэйшнийг сонгон татдаг шиг үүлэн системд суурилсан худалдан авалтын дэлхийн нийтлэг зарчмыг мөнгө ч тэр хэрээрээ үрж зардал чирэгдэл гаргахгүйгээр худалдаж авах нөхцөл бололцоог бүрдүүлээ.

Бид Windows программ хэрэглэхдээ оюуны өмчийг нэхдэггүй. Бүтээсэн Майкрософт андэйт хөгжүүлэлтийг нь хариуцдаг шиг хэрэглээний жишигийг энэхүү программ хангамжийн их дэлгүүр бий болгоно. Үр дүнд нь гарааны туршилагатай ямар ч Монгол компани сандал ширээ эд материал биш оюун ухаанаа олборлож бүтээсэн программ системээ үнэлүүлж, дэлхийд экспортлох боломж нэмэгдэнэ. Үйлдвэрийн том машин барилга яндангүй учраас нүдэнд харагддаггүй ч программ хангамжийн аж үйлдвэрийн салбарт 300 гаруй монгол компаниуд 2000 гаруй залуучууд ажиллаж хэд хэдэн улсад оюуны бүтээлээ экспортлоод байна.

Монгол газрын хэвлий дэх эрдэс баялгаас гадна Монгол хүний тархинд үйлдвэрлэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж экспортод гаргаж эхэлсэн залуучууддаа төр ядаж тус болдоггүй юм гэхэд улс болохгүй лай болохоос зай болох бодлогыг барьж ажиллах болно.

6. Үндэсний хөгжлийн хурдасгуур

Программ хангамж үйлдвэрлэгчдийг татварын бодлогоор дэмжиж мэдээллийн технологийн гарааны бизнес эрхлэгчид компаниудыг 2023 оны 01 дүгээр сараас эхлэн 5 жилийн хугацаанд мэдээллийн технологийн үйл ажиллагааны олсон орлогын албан татвараас чөлөөлөхөөр боллоо. Цахим хөгжил, Харилцаа холбооны яам, Барилга хот байгуулалтын яамтай хамтран Үндэсний хаягжилтын мэдээллийн нэгдсэн системд zip код шуудангийн нэгдсэн код, газар нэгжийн тайлбар зэрэг олон хаяг дугаарыг нэгтгэн нэгдсэн хаягтай болох шийдлийг боловсруулж байна. Энэ санг ил тод болгож хэрэглээнд нэвтрүүлснээр шуудангийн үйлчилгээ, газар зохион байгуулалт, такси, түргэн тусламж, онцгой байдал, бүтээгдэхүүн хүргэлт зэрэг төөрөгдөл саатал арилна.

Байгалийн баялгийн олборлолт тээвэрлэлт, борлуулалтын бүх үе шатыг ил тод, нээлттэй болгож, олон нийтийн хараа хяналтад бүрэн авах технологийн шийдлийг боловсруулна. Хулгай дээрэм, алдаа завхрал гарсан хойно нь хэн нэг хэсэг бүлэг буруутан хайдаг биш. Дахиж ийм үйлдэл давтагдах үндэс шалтгааныг уг үндсээр нь арилгах эхний санаачилга, 24 цаг гэрэл асаах технологийн шийдлүүдийг хувийн хэвшил, төрийн байгууллагууд гаргалаа. Хулгай хийх боломж л хулгайчийг төрүүлдэг. Тухайлбал, экспортын гол бүтээгдэхүүн нүүрсийг олборлохоос хилийн боомтод хүргэх чанарыг нь тогтоох, хэн, хэзээ хэдээр хэрхэн худалдаж, худалдан авч байгаа үйл явц, Биржийн арилжааг төрийн үйлчилгээний нэгдсэн системээр

дамжуулж ард нийтийн хараа хяналтад оруулах болно.

Хиймэл оюун ухаан цахим технологийг хуурах арга байдаггүй ээ. Хиймэл оюун ухаанд ах дүү хамаатан садан, хувийн ашиг сонирхол, ёс зүйн дутагдал байхгүй. Бурууг нурааж, зөвийг босгох технологийн шийдлийг өндөр хурдаар эрдэс баялаг тендер, худалдан авалт, төрийн үйлчилгээнд өргөн хүрээгээр нэвтрүүлэх нь шударга ёсыг тогтоох шалгарсан арга зам юм. Улсын хилээр нэвтрэх зорчигч, тээврийн хэрэгслийн бүртгэл, хяналт, мэдээллийн нэгдсэн систем, гадаадын иргэний виз бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан систем, Монгол Улсад суугаа гадаадын иргэдийн бүртгэл хяналтын мэдээллийн нэгдсэн системийг тус тус шинэчлэх ажилд салбар дундын зохицуулалтыг хангаж ажиллаж байна.

Зөрчлийн бүртгэл мэдээллийн нэгдсэн системийг 2023 оны 01 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хэрэглээнд нэвтрүүлээ. Анхан шатны 538, лавлагаа шатлалын 48 хувийн 60 гаруй эмнэлэг эрүүл мэндийн статистикийн программ, даатгалын системтэй холбогдон мэдээлэл солилцсоноор 49000 хэрэглэгчийн эрүүл мэндийн цахим карт өнөөдрийн байдлаар үүсээд байна. Монгол Улсын өнцөг булан бүрд ажиллаж амьдарч байгаа шилдэг багшийн бэлтгэсэн цахим хичээлийг суралцагч нь орон зай, цаг хугацаанаас үл хамааран насан туршидаа суралцах цахим контентын нэгдсэн санг Боловсрол, шинжлэх ухааны яамнаас санаачилж мэдлээ хэмээн сургалтын нэгдсэн платформыг нэвтрүүлж, 2022 оны 3 дугаар улирлын байдлаар 5017 багш 3642 контент боловсруулах санал ирүүлснээс 1862 хичээлийг байршуулж, нэг сая гаруй хэрэглэгч хандсан байна.

Баруун хязгаарт ажилладаг сайн багшийн хичээлийг говийн хүүхэд, зүүн аймгийн сурагч шавь орж болох нөхцөлийг бүрдүүлэх хэрэгтэй. Бяцхан

иргэдээ азтай, азгүйгээр нь ялгаварладаг цэцэрлэгийн сугалааг таслан зогсоосон. Засгийн газрын шийдвэр бодитой үр дүнгээ өгсөн.

Газрын кадастрын нэгдсэн системд газар өмчлөгч, эзэмшигч ашиглагчдын хүсэлтийг шийдвэрлэх, газрын бүртгэл баталгаажуулах, цахимжуулах ажлыг хэрэгжүүлснээр улсын хэмжээнд нийт өмчлөх эрх үүссэн 577180 газар, эзэмших эрх үүссэн 457534 газар, ашиглах эрх үүссэн 5963 газар буюу нийт 979697 газар тус тус бүртгэгдэж, баталгаажсан байна. Хот байгуулалтын кадастрын цахим системд иргэн хуулийн этгээд барилга барих хүсэлт гаргахаас эхлээд архитектур төлөвлөлтийн даалгавар, барилга байгууламжийн ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх Зөвшөөрөл болон ашиглалтад оруулах комиссын дүгнэлт гаргах зэрэг шат дараалсан үйл ажиллагааг цахим орчинд хүлээн авч түргэн шуурхай шийдвэрлэх боломжийг бүрдүүлж, салбар дундын уялдааг хангаж, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны зүгээс мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийг үнэлж нийтийн мэдээллийн системтэй холбож ажиллаж байна.

7.Засгийн газраас 2023 онд цахим шилжсэний талаар баримтлах бодлого чиглэл, хэрэгжүүлэх арга хэмжээний талаар

Цахим хөгжлийг дэмжих хуулиудын хэрэгжилтийг хангаж, цахим үндэстэн болгох үйл хэрэг, өндөр хурд нэмэх, мэдээллийн технологийн үр дүнг салбар бүрд иргэн бүхэнд хүргэх зорилгоор заавал биеэр эсхүл цаасаар мэдээлэл солицохоор заасан иргэн, хуулийн этгээд төртэй болон өөрөө хоорондоо хамтран ажиллах, үйлчилгээ авахад чирэгдэл учруулж болох хууль тогтоомжуудын судалгааг хийж, хууль хоорондын давхардал, хийдлийг арилгах зорилгоор зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа. Үндэсний дата төвийн

үйл ажиллагааг олон улсын дата төвийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлж, төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан Клауд провайдер хэлбэрт шилжүүлэн Үндэсний клауд дэд бүтцийг бий болгож, хоорондоо зохицдоггүй тоног төхөөрөмж, техник хангамж үүсгэдэг асуудлыг цэгцлэх ажлыг эхлүүлээ.

2023 оны 01 дүгээр сарын 1-ээс эхэлж хэрэгжсэн зөвшөөрлийн хуулийн дагуу зөвшөөрлийн нэгдсэн санг үүсгэж зөвшөөрөл олгох, сунгах, цуцлах үйл ажиллагааг бүрэн цахим хэлбэрт шилжүүлэх, түүнчлэн хуулийн этгээдийн улсын бүртгэлтэй холбоотой үйлчилгээ, санхүү, татвар болон нийгмийн даатгал зэрэг төрөөс хуулийн этгээдтэй холбоотой бүхий л үйл ажиллагааг цахим нэг цонхонд төвлөрүүлж, И-Монголиад холбож бизнес эрхлэхэд таатай нөхцөлийг бүрдүүлсэн И-Бизнес платформыг бий болгож энэ улиралдаа багтааж хэрэглэгчдэд танилцуулахад бэлэн болоод байна. Энэ платформ нээгдсэнээр хүн, хуулийн этгээд дэлхийн хаана ч байсан Монголд компани байгуулах, тусгай зөвшөөрөл авах, сунгах, татвар, нийгмийн даатгалаа төлөх боломжтой болох ёстой. Бизнесийн үйл ажиллагаа Ил тод тунгалаг болж, гадаадын хөрөнгө оруулагчдын итгэл нэмэгдэж, хамтран ажиллах сонирхлыг татах боломжийг бүрдүүлэхэд Улсын Их Хурлын эрхэм гишүүд та бүхнийг дэмжиж ажиллахыг хүсэж байна.

Монгол Улсын Засгийн газар, Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн Ассоциацитай хамтран хэрэгжүүлэх “Ухаалаг Засаг 2” төслийн хүрээнд төрийн цахим үйлчилгээний суурь дэд бүтэц болох үндсэн болон дэмжих системийг өргөтгөн хөгжүүлж бүх шатны төрийн байгууллагыг холбох дундын үүлэн шийдлийг нэвтрүүлж тоон гарын үсгийн дэд бүтцийг иж бүрнээр нь шинэчиллээ. Үндэсний дата төвийн хүчин чадлыг нэмэгдүүлж, кибер аюулгүй

байдлыг хангах дижитал эдийн засгийн өсөлтийг дэмжинэ.

Сансар судлалыг хөгжүүлэх зорилгоор сансрын эмэгтэй нисгэгч бэлтгэх, сансар судлалаар ОХУ-ын Роскосмостой хамтран ажиллаж байна. Бээжинд төвтэй Ази, Номхон далайн сансрын хамтын ажиллагааны байгууллагын буцалтгүй тусламжаар МУИС-ийн Шинжлэх ухааны их сургуулийн Газар зүйн танхимд БНХАУ-ын цаг уурын FI 2 хиймэл дагуулаас мэдээ хүлээн авах газрын станцын лабораторийг байгуулаа. Хиймэл дагуулын газрын станц ашиглалтад орсноор Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийг хамарсан байгаль цаг уурын мэдээллийг цаг тутамд авч ашиглах боломж бүрдэнэ.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Цахим шилжилтийг бүрэн хийж, тоон бичиг соёл түгэн дэлгэрэхийн их үндэс, итгэл найдвар нь Монголын ард түмэн юм. Аливаа шинэ соёл хандлагад нэгэн зэрэг хурдан суралцдаг, дасан зохицдог онцгой шинж чанартай мэдээлэл солилцооны хурдаар агуу их эзэнт гүрний тулгыг тулж, галыг асаасан их түүхтэй. Хорьдугаар зуунд бүх нийтээрээ бичиг үсэг тайлагдсан амжилтаараа Юнеско-ийн шагнал хүртэж байсан Бахархалтай Монголчууд 21-дүгээр зуунд тоон бичиг соёлыг үндэстнээрээ хурдтай өөриймшүүлэн хэвшил болгож чадсан улс үндэстэн болно гэдэгт итгэл төгс байна.

Цахим шийдлээр хүнд суртлыг хална. Цахим биржээр нүүрс газрын баялагтай ард иргэдийн хараа хяналтыг тогтооно. Цахим танхимаар үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хүндэтгэн хүлээн авч төр ба иргэн үргэлж холбоотой байна. Цахим дэвшилээр бизнес, хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлнэ. Энэхүү шинэчлэлийг илүү үр дүнтэй

хэрэгжүүлэхийн төлөө Монгол Улсын Засгийн газар цаашид хичээн ажиллах болно. Өсөлт үр дүн өгөөж бүтээмжийн төлөө илүү өндөр хурдаар илүү өргөн хүртээмжтэйгээр шийдье. Цахимаар засъя.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданишатар: Мэдээлэл хийлээ. Ням-Осорын Учрал сайд баярлалаа. Одоо Цөөнхийг төлөөлж үг хэлэхгүй гэсэн. Одоо мэдээлэлтэй холбогдуулан Цахим хөгжил, харилцаа холбооны сайд болон ажлын хэсгийн гишүүдээс асуулт асууж, үг хэлэх цөөнхийн бүлгийн гишүүдийг бүртгэе. Цогтгэрэл гишүүнээр тасаллаа. Салдангийн Одонтуяа гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

С.Одонтуяа: Тэгэхээр энэ мэдээлэлдээ бас дэлгэрэнгүй танилцлаа. Бас байгуулагдаад удаагүй гэхэд бас залуу хүний хурд байгаа байх. Их олон чухал ажлуудыг амжуулсан байна. Тэгээд ерөнхийдөө 6 чиглэлээр бас гол юмаа танилцуулж байна. Тэгэхээр энэ 6 чиглэлийг бүгдийг нь сонслоо. Мэдлээ. Хэд хэдэн зүйл асууя. Ер нь энэ бүх цахим шилжилт цахим нэвтрэлт кибер аюулгүй байдал энэ бүх зүйлийн суурь нь хүний эрхийг баталгаажуулсан байх ёстой, хүний эрхийг зөрчөөгүй байх ёстой. Тэгэхээр танай байгууллагад ер нь байгууллага чинь хэдэн хүнтэй юм бэ. Хэдэн харьяа газартай юм бэ. Хүний эрхийн асуудал хариуцсан ийм тусгайлсан яг мэргэжилтэн баг хамт олон ажилладаггүй. Хүний эрхийн үндэсний комисстой хэр холбоотой ажилладаг вэ. Та нарын энэ гаргаад байгаа энэ сайхан зүйлүүд чинь хүний эрхийн зөрчил бий болгочихгүй байгаа гэсэн ийм зүйлүүд нэгдүгээрт асууя.

2-т энэ НҮБ-ын Цахим засаглал хөгжлийн индексээр 74 дүгээр байрт сайхан орсон гэж байна. Гэтэл кибер аюулгүй байдлаараа бүр 85-аас 120 луу ухарсан гээд 2020 оны байдлаар. Тэгэхээр

энэ яагаад ингээд ухраад байдаг юм бол гэсэн 2 дахь асуулт.

3 дахь нь би бас энэ хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын чиглэлээр нэлээд зүйл ажилладаг Юнисеф-тэй бас их хамтарч ажилладаг. Тэгэхээр Юнисеф-ийн жил болгон гаргадаг энэ хүүхдийг цахим халдлагаас хамгаалах жил бүрийн илтгэл гэж байгаа. Энэ илтгэл дээр Монгол Улс хамгийн эрсдэл өндөртэй орны тоонд орчихсон байгаа. Тэгэхээр энэ хүүхдийг цахим халдлагаас хамгаалах дээр яг юу хийж байна вэ. Энэ чиглэл дээр бас танай байгууллага дээр тусгайлан манай эмэгтэй гишүүд бид нар очиж бас танилцмаар байна. Яагаад гэхлээр бид нар Хүүхэд хамгааллын хуульд нэг л өгүүлбэр байдаг юм. Интернэтийн компаниуд нь өөрсдөө тэр айлд код өгнө, Кодоороо орно ч гэдэг юм уу. Гэтэл тэр нэг их хэрэгждэггүй юм шиг л санагддаг шүү дээ. Тэгээд манайх олон л насанд хүрээгүй хүүхдүүд байдаг хэр нь хэзээ ч тийм код мууд ингээд л бас нэг яадаггүй. Тусгайлсан тийм асуудлууд байхгүй учраас энэ цахим халдлагаас хамгаалагдаж чадаж байна уу үгүй юу. Ер нь бид нар хүүхдээ хамгаалж чадахгүй Улс орон Үндэсний аюулгүй байдал гэж их яриаад хэрэггүй л юм байгаа юм.

3 дахь асуудал та нар энэ ургийн бичгийг их хөгжүүлж байна гээд. Энэ маш зөв. Ер нь 12012-2016 онд ч гэсэн манай эмэгтэй гишүүдийн бүлэг бас нэг ургийн бичгийг аль болохоор дэлгэрүүлж, хөтлүүлэх талаар юмнууд хийе гэж нэлээд олон санаачилгыг гаргаж байсан юм. Тэгэхээр энийгээ их сайхан сурталчилмаар байна. Хууль сурталчлах ажил нь жосоохон тааруу байна уу даа гэж би хардаг юм. Яагаад гэхээр би өөрөө бас энэ интернэтэд нэлээд их мэдээлэл авдаг. Твиттер, фейсбүүк, инстаграм тэгээд л бусад энэ сайтуудын мэдээлэл харж байхад Монголд нэг ийм цахимаар ийм ийм юмнууд явж байна шүү гэдэг нь миний нүдэнд бол шууд тусахаар харагддаггүй. Тэгэхээр энэ чиглэл дээр та нар тийм ялангуяа хүүхэд

залуучуудад таалагдахаар таарахаар анхаарлыг нь татахаар контентуудыг л хийхгүй хүмүүс чинь энэ их мэдээллийн юм дотор жингээд явчихдаг. ЦЕГ-ын тэр гэр бүл хөгжлийн хэлтсийнхэн харин яг хүний анхааралд өртөхөөр ингэж юмаа сурталчлаад байгаа байхгүй юу. Намайг алгас гэдэг ч юм уу. Уураа байр ч билүү гээд.

Тэгэхээр нэг ер нь ингээд цахим юм чинь бид нар төр бодлогоороо л иргэдээ чиглүүлж байх ёстой шүү дээ. Тэгэхээр энэ чиглэл дээр та нар бас хэр ажиллаж байгаа юм бол гэдгийг асууя. Дээрээс нь энэ фейсбүүкийг ер нь цэгцлэх тийм асуудал байгаа юу. Өөрөөр хэлбэл ингэж байгаа юм л даа. Энэ дээр 2 асуудал байгаа юм. Нэг нь аюулгүй байдал. Манайх шиг ийм хүн ам цөөтэй газар, ерөөсөө троллууд хөлсний хүмүүсээр энэ бүх юмыг чинь удирдан залах боломж бүрдээд эхэллээ шүү дээ. Сонгуулийг залах боломж бүрдлээ, хүмүүсийг гутаах, доромжлох энэ бүх зүйлүүд чинь хэрээс хэтэрч байна шүү дээ. Мэдээж ардчилсан оронд хүн үг хэлээ чөлөөтэй илэрхийлнэ. Гэхдээ өөрийн хаягтай бүртгэлтэй, ийм зурагтай ийм зүйлийг бусад бүх орон шаардаж байгаа шүү дээ. Тэгэхээр манайх хэн дуртай нь 100 хаяг нээчхээд л троллоор хүнийг бөмбөгдөөд нэр төрийг нь гутаадаг. Ийм зүйл цэгцлэх үү гэдгийг асууя. Тэгээд фейсбүүкээс хүмүүс ерөнхийдөө нэг хэрүүл сенсац л харж байна. Тэгэхээр фейсбүүкээр бид нарын амьдрал яваад байгаа учраас энэ дээр зориулсан гоё ийм цахим контент ер нь бий болох юм уу? Бид нар чинь хуучин телевизээрээ тэр үлгэрээ сонсдог ч юм уу нэг ийм үндэсний контент. Одоо энэ Монгол залуучуудын чинь тэр эх оронч үзэлтэй, өрсөлдөх чадвартай, эрүүл чийрэг бие бялдартай, эрх чөлөөтэй, хариуцлагатай байхад энэ цахимаар чинь л бид нар нөлөөлөх гэж үзнэ шүү дээ. Тэгэхээр энэ чиглэлээр та нар хэр.../минут дуусав/

Г.Занданишатар: Хэн хариулах уу? Учрал сайд. Ням-Осорын Учрал сайд хариулна.

Н.Учрал: Одонтуяа гишүүнд баярлалаа. Асуултад хариулъя. Хувь хүний мэдээлэл хамгаалах хуулийг та бид хамтдаа Их Хурлаас 2021 онд баталсан. Хувь хүний мэдээлэл хамгаалах хуулийн хамгийн том дэвшил төрийн мэдээлэл солилцож байгаа бол иргэнээсээ мэдээллийг хэрвээ үйлчилгээ үзүүлэхдээ ашигласан тухайн иргэндээ мэдэгддэг, өөрийнх нь зөвшөөрлөөр мэдэгддэг байх ийм сайн зохицуулалт орсон. Өмнө нь бол энэ хууль гараагүй байхад хувь хүний ямар нэгэн мэдээллийг ашиглаж байгаа үгүйг иргэн ч мэддэггүй. Тэгээд өөр зорилгоор ашиглаж байгаа эсэхдээ хяналт тавьж чаддаггүй байсан. Энэ сайн дэвшил гарсан учраас мэдэгдэх хуудсаар бол мэдээлэл очдог болсон. Тэгээд энэ хуулийг бол анхаарч байна. Дээрээс нь хүний эрхийг хангах чиглэлээр манай яамны дэргэд кибер аюулгүй байдлын бодлогын газар ажилладаг. Энэ нь хувь хүний мэдээлэл хамгаалах асуудлыг хариуцдаг. Хүний эрхийн комисс дээр бол энэ хуулийн дагуу хувь хүний мэдээлэл хамгаалах тусдаа нэгж байгуулагдсан. Хүний эрхийн үндэсний комисстой Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын хамтарсан ажлын хэсэг байгуулагдсан. Хуулиараа хүний эрхийн комиссын саналыг үндэслээд нөгөө дуу бичлэгийн төхөөрөмж, дүрсний төхөөрөмж, дууны төхөөрөмж энэ хувь хүний мэдээлэл хамгаалахтай холбоотой журмуудыг хүний эрхийн комиссын саналыг үндэслээд сайдын тушаалаар Засгийн газрын тогтоолоор батлах ёстой. Энэ хуулиудыг дагасан нийт 37 журмын хүрээнд энэ ажлууд хийгдсэн. Тэгэхээр Хүний эрхийн үндэсний комисстой бол хуулийн хүрээнд шууд хамтарч ажиллаж байгаа. Бүх асуудлууд дээр хүний эрхийн комиссын саналыг үндэслэдэг. Хувь хүний мэдээлэл хамгаалал нэгжтэй ажилладаг. Манай яамны хувьд бол бүтэц бол 87 ажилтан, албан хаагчидтай. Тэгээд дэргэдээ

мэдээж энэ төрийн өмчит компаниуд бодлогынхоо хүрээнд энэ бусад байгууллагуудтай Харилцаа холбооны зохицуулах хороотой бодлогынхоо хүрээнд хамтраад ажиллаад ирсэн.

2-дугаар тэр асуулт кибер аюулгүй байдлын асуудал дээр бид бас онцгой анхаарч байна. Кибер аюулгүй байдлаар ард яваагийн шалтгаан иргэд тоон бичгийн үсгийн чадавх 43 хувьтай байгаагаас бас иргэд нөгөө кибер халдлагад өртөх магадлал их байдаг. Янз бүрийн явуулсан мессеж янз бүрийн зүйлүүд дээр хариу өгчихдөг. Тэгээд хувийнхаа аккаунтуудыг халдлагад өртчихдөг ч гэдэг юм уу, дээрээс нь Монгол Улсад кибер аюулгүй байдлын хууль ерөөсөө 1990 оноос хойш нэг ч гараагүй. Түүнээсээ болоод серт төвүүд гээд олон улсын байгууллагууд ерөөсөө харьцаж чаддаггүй байсан. Бид анх удаа Кибер аюулгүй байдлын хуулийг батлан гаргаснаараа хувийн байгууллагуудыг хариуцах нөгөө паблик төв нөгөө төрийн мэдээллийн сүлжээнд холбогдсон байгууллагуудтай харилцах үндэсний төв гээд нөгөө халдлагад хариу өрөх төвүүдийг байгуулах үндэсний стратегитай болох нийтлэг журамтай болсон. Тэгэхээр бид цаашидаа олон улстайгаа харилцах ч гэсэн нөхцөлүүд бүрдэж байгаа.

Угийн бичгийг хөтлөх ажлыг бол нэлээн онцгой анхаараад хувийн хэвшилүүд энэ дээр олон санаачилга гаргасан. Үүнийг ХУР системтэй холбож байна. Цагаан сарын өмнө угийн бичиг хөтлөх цахим системийг нээнэ. Их Хурлын тогтоол бол батлагдсан байдаг. Ерөнхийлөгчийн бас санаачилга байгаа. Тэгээд энэ ажлыг бол бас хэрэгжүүлж ажиллана.

Г.Занданшатар: Учрал гишүүн гүйцээж хариулъя.

Н.Учрал: Хууль сурталчлах ажлууд дээр бол үнэхээр дутмаг байгаа. Үүнд анхаарахаас өөр арга байхгүй. Ялангуяа

тоон бичиг үсгийн чадварыг дээшлүүлэх чиглэлээр залуучууд хүүхдүүдэд зориулсан цахим контентуудыг хийж хэвшүүлэх ажлыг эхлүүлж байна. Ерөнхий сайдын санаачилгаар үндэсний тоон бичиг үсгийн чадварыг өргөжин хөгжүүлэх том ажил бол аян өрнөж эхэлнэ. Бид нар энэ контентууд дээрээ бас анхаарна гэдгийг хэлье. Тэр фейсбүүк бусад энэ сошиал медиа дээр зохицуулалтуудыг хийхэд бол бэрхшээлтэй. Харин бусад Эрүүгийн хууль, Зөрчлийн хууль бусад нэр хүндэд нь халдсан, гүтгэсэн доромжилсон зохицуулалтаар явж байгаа. Гэхдээ бид цахим орчинд хүний эрхийг хамгаалах хүүхдийг тэдгээрийн хүмүүжил, төлөвшилд сөрөг нөлөө үзүүлэхүйц мэдээлэл хамгаалах тухай хууль гэсэн хэд хэдэн хуулийн төслийг боловсруулж байгаа. Тэгээд энэ хуулийн төслүүдийг Улсын Их Хуралд удахгүй бас өргөн мэдүүлнэ.

Г.Занданшатар: 86.

Б.Мягмарнаран: Сайн байцаана уу. Харилцаа холбооны зохицуулах хорооны Зохицуулалтын бодлогыг хэрэгжүүлэх газрын дарга Мягмарнаран. Одонтуяа гишүүний хариултад нэмэлт мэдээлэл өгье. Цахим орчинд хүүхэд хамгааллын асуудлаар Харилцаа холбооны зохицуулах хороо, Цагдаагийн ерөнхий газартай хамтраад Хүүхэд хамгааллын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэгт заасны дагуу хүүхдэд сөрөг нөлөөлөхүйц контент, түүнийг тархалтыг бууруулах тодорхой арга хэмжээ авах заалтуудыг тэр хуулийн хүрээнд хэд хэдэн түвшний арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа. Хамгийн түрүүнд бол бид бүхэн 2013 оноос <http://ekids.mn/> гэх цахим хуудсыг хөтлөн ажилладаг. Энэ цахим хуудасны үндсэн зорилго бол хүүхэд, багш, сурган хүмүүжүүлэгч, эцэг эхэд зориулсан цахим орчинд яаж зохистой зөв ашиглах вэ? хэрхэн өөрийгөө цахим орчинд хамгаалах вэ? чиглэлээр тодорхой контентуудыг бид бүхэн тогтмол баяжуулж арга хэмжээ авч явдаг. Үүний хүрээнд бол

нийт л 300 орчим нийтлэл, видео шторк гэвэл 103 ширхэг, нөлөөллийн постерыг 162 ширхэг, сургалтын материал 60 ширхгийг гаргасан явж байгаа. Тэгээд жил болгон үүнийг холбогдох энэ платформуудын хөгжилтэй уялдуулан баяжуулж явдаг.

Мөн дээр нь дараагийн арга хэмжээ нь болохоороо олон нийтэд зориулсан нөлөөллийн аяныг холбогдох байгууллагуудтай хамтарч хэрэгжүүлдэг байгаа. Түрүүн дурдсан Цагдаагийн ерөнхий газартай хамтраад бид бүхэн жил болгон арга хэмжээ зохион байгуулдаг. 2017 онд Цахим орчин дахь гадуурхал чиглэлээр бид нар 10000 орчим сурагч, хүүхдүүдийг хамрагдуулсан арга хэмжээ зохион байгуулж байсан. 2018 онд цахим орчинд зөв болгоё гэдэг нөлөөллийн аянг явуулсан байгаа. 2019 онд цахим орчны хүүхэд хамгаалал чиглэлээр үндэсний хэмжээний семинарыг зохион байгуулсан. 2021 онд цахим орчны зохицуулалт гэсэн мэтгэлцээний тэмцээнийг бүх сургуулиудын 345 ахлах ангийн сурагчдыг хамруулсан байдлаар зохион байгуулсан байгаа. 2022 онд цахим соёл аяныг бас амжилттай зохион байгуулсан. Энэ нь бол олон нийтэд нөгөө дижитал лeтpас гээд байгаа. Цахим орчинд яг зөв мэдээлэл өгч, зохистой хэрэглээ талаараа ийм арга хэмжээ авсан байгаа.

Дараагийн арга хэмжээ нь болохоор бид бүхэн олон улсын платформуудтай бас хамтарч ажиллах хэрэгцээ шаардлага гардаг. Яагаад вэ гэхээр нөгөө тарж байгаа мэдээ мэдээллүүд маань өөрсдөө янз бүрийн цахим хуудас түрүүний Фейсбүүк, мета гэх мэт хуудаснууд дээр гараад байдаг болохоор бид бүхэн ажиллах шаардлагатай байдаг. Тэгээд бид бүхэн 2012 оноос *blacklist.mn* цахим хуудсыг хязгаарлах тийм системийг хөтөлж ажиллаж байгаа. Тэгээд үүнийхээ хүрээнд бол домэйн нэрээр нь хязгаарлах арга хэмжээг авдаг. Зөрчилтэй контенттой цахим хуудсыг. Бид бүхэн бас мета буюу

фейсбүүк компанитай 2018 оноос ажиллаж 2019 оноос Ногоон суваг *government kids channel* гэж байгаа. Энийг авч хэрэгжүүлж ажиллаж байна. Түүнтэй холбоотой фейсбүүк, инстаграм дээр гарсан зөрчилтэй контент хаягуудыг хүргүүлж холбогдох арга хэмжээг авч ашиглаж байна.

Мөн 2021 оны 5 сараас алфавет буюу гүүгэл компанийн ютүб.../минут дуусав/

Г.Занданишатар: Одонгийн Цогтгэрэл гишүүн.

О.Цогтгэрэл: Төрийн цахим шилжилтийн талаар тайлан орж ирж байна. Мэдээлэл цахим шилжилт, ер нь энэ дижитализэйшн гэдэг юм өөрөө бас өнөө цагийн Монголчуудын хувьд хүн төрөлхтний бас хөгжил дэвшилээс хүртэх асар их том газар зүйн таатай биш байришлд орон зайн хол ойрын ялгааг арилгасан, асар их том олон асуудлыг шийдэх боломжтой ийм түүхэн боломж гэж бид бүгд бас тал талаасаа үзэх ёстой ийм л салбар. Яг үнэндээ бол энийг дамжаад тэр иргэний ахуй амьдрал, нөгөө талдаа энэ авлига, хээл хахууль, ил тод байдал, олон зүйлийг зөвхөн энэ технологийг хөгжил дэвшилээр шийдэх боломж бололцоотой ийм л салбар. Тэгээд засгийн энэ тайланг бид нар бас эргүүлж үзлээ. Яг энэ тайлангуудыг харахад болж байгаа зүйлүүд байх шиг байна. Бас болохгүй талаас нь бас энэ ажил хэргийн үүднээс бас ингээд ярья. Яг одоо үнэндээ энэ тайлан бол ингээд уншихлаар Засгийн газраас юу хийж байгаа буюу нэг тийм хуучнаар бол нийлүүлэлтийн шинжтэй. Нийлүүлэлтийн шинжтэй гэдэг нь хэрэглэгч яг ингэснээр юуг хожсон юм. Монгол иргэн яг юуг хожсон юм. Ажил хэргээ амжуулах цаг хугацаа нь хэдэн хувиар хэдэн минут, секундээр яг яаж илүү үр ашигтай болсон юм. Бүтээмж хэрхэн яаж дээшилсэн юм. Эдийн засгийн ил тод байдал бусад салбарууддаа яаж нөлөөлсөн юм гэдэг Иргэн талаасаа тэр

эрэлт талаасаа асуудлыг ерөөсөө харсан ганц ч өгүүлбэр энэ дотор алга. Яг л үндсэндээ цахим яамны дотооддоо биедээ илгээмээр тайлан шиг л ийм ажил хэргийн л гүйцэтгэлийг тайлан харагдаж байна. Тэгэхээр эндээс би бас дараагийн нөгөө 20 минут дээр асуулт бас асуух юм. Одоо цөөхөн ганц 2 асуулт асуучихъя. Ер нь энэ цахимжилт гэдгийгээ өөрийг нь яг юу гэж ойлгож байгаа юм. Явал цахим шилжилт хийчихлээ гэж үзэх гээд байгаа юм. Тэрнийхээ хаана нь яваа юм. Ер нь цахим шилжилт гэдэг нь өөрөө яг юу юм. Явал цахим шилжилт болох юм. Баахан шилэн кабель тавиад 3G, 4G, 5G болоод ингээд ороод байвал Монгол Улс цахим шилжчихлээ гэж үзэх юм уу. Иргэн талаасаа бас тайлбарлаж өгөхийг хүсье.

Хоёрдугаарт нь яг дахиад тэр иргэн хүн дээр ямар үр дүнгүүд гарсан юм. Магадгүй энэ гудамжинд түгжрээд байгаа түгжрэлийн асуудал хүртэл бид нар энэ цахим шилжилт гэдэг зүйлээ цахимжилт гэдэг зүйлээ мэдээллийн технологио зөв зүйтэй хандлага чиглэлд бас явахгүй байгаагийн нэг илрэл энэ юм болов уу л гэж харж байна л даа.

Тэгээд гуравдугаарт, түрүүн НҮБ-ын гэж байна лээ. Тэр цахим засаглал талаасаа индекс байсан уу. Засгийн газар талаасаа байсан уу. Миний харснаар дэлхийн эдийн засгийн форумгаас гаргадаг судалгаан дээр цахим өрсөлдөх байдал гэж байна л даа. Улс орнуудыг гаргасан байна. 63 улс орж эхэнд нь Дани улс, Америк гээд орж. 63-д нь Венесуэл гэж улс орж, 62-т нь Монгол гэсэн нэр байна л даа. Тэгэхээр эндээс яг юу гэсэн ямар аль нь үнэн тайл нэг нь засаг талаасаа нэг нь Монгол Улс өөрөө 63-62-т байгаад Засгийн газрын шилжилт нь яваад байна гэсэн үг юм уу. Тэгэхээр эхлээд энэ нэг 3 асуултад хариулт авчихъя. Тэр ер нь цахим шилжилт гэдгийгээ өөрийг нь яг юу гэж ойлгож байгаа юм.

Хоёрдугаарт нь иргэн хүн дээр яг энэ тайлангийн хүрээн дээр иргэн хүн дээр ямар давуу талууд гарч байгаа юм.

Гуравдугаарт нь тэр энэ индекстэй холбоотой хариултууд авчихъя.

Г.Занданшатар: Ням-Осорын Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя. Тэгээд бас шүүмжийг хүлээж авч байна. Цахим засаглал гэдэг бол өөрөө яг иргэн талаасаа харах юм бол энэ дэвшилтэт технологи, цахимжилт нь өөрөө амьдралыг энгийн, хялбар болгоход л орших ёстой. Технологи ашигласнаараа амьдрал энгийн, хялбар л болох ёстой. Тэгж байж л иргэд эндээс хожно. Дээрээс нь аливаа бүх зүйл ил тод нээлттэй болох ёстой. Тэгээд ар өврийн хаалгагүй болгох ёстой. Энэ нь өөрөө бүхэлдээ авлигагүй нийгмийг л бүтээдэг. Тийм учраас би бас илтгэл дээр хэлсэн. Хиймэл оюун ухаанд арын хаалга алга. Аль намын гишүүнчлэл хамаа алга, ашиг сонирхлын зөрчил алга. Тийм учраас технологиор шийдчихсэн асуудлыг бол хэн нэгэн нөлөөлөх бололцоо бол үүсдэггүй учраас энэ авлигагүй нийгмийг бүтээхэд цахим засаглал хамгийн сайн хэрэгсэл байдаг юм гэдгийг дэлхийн улс үндэстнүүд харуулж байна. Тэр индексийн хувьд бол дэлхийд олон индекс байгаа. Миний сая дурдсан цахим засаглалын индекс НҮБ-ээс гаргадаг. Энэ засаглалын индекс бол индикаторууд. Ерөнхийдөө тухайн төрийн байгууллагуудаас хэрхэн манлайлал үзүүлээд засаглалын хувьд ямар дэвшилүүд гарч байгаа вэ гэдэг дээр бол цахим засаглалын индекс нөлөөлж байгаа.

Тийм учраас өнгөрсөн хугацаанд хийж хэрэгжүүлсэн Их Хурал нь хуулиа гаргасан, хуулийн хүрээнд хувь хүний мэдээллийг хамгаалсан, нийтийн мэдээллийн дэд бүтцээ хуульчилж өгсөн, кибер аюулгүй байдлын орчинтой болсон. Үүнийг нь дамжуулаад И-

Монголиа нэгдсэн платформ гаргаад, ХУР системээрээ дамжуулаад сервис үзүүлээд төр иргэдээсээ цаасаа нэхэхээ больж байгаа. Энэ дэвшил юм гэдгээр 18 байр урагшилсан.

Тэгвэл сая таны дурдсан энэ өрсөлдөх чадварын индекс. Энэ дижитал өрсөлдөх чадварын индекс гэдэг бол төр, хувийн хэвшил, мэргэжлийн байгууллага, эрдэмтэн судлаачдын хамтрах буюу бидний ярьж занисанаар эко систем. Ерөөсөө манай улсад эко систем бүрдээгүй. Жишээ нь угийн бичиг хөтлөх систем хийе гэхэд төр дахиад тендер зарладаг. Тэгээд төр тендер зарлаад 10 жил тэрийг хөтөлсөн хувийн салбарын тэр цахим системийг дахиж өөрөө хийж эхэлдэг. Мэргэжлийн холбоодын төлөөлөл оруулаагүйгээс болоод дэлхийн олон төслүүд унадаг. Худалдан авалт нь ухаалаг байж чаддаггүй. Мэргэжлийн хүмүүс экспертүүд түүнд нь орж үнэлэлт, дүгнэлт өгдөггүй.

Тийм ч учраас өнөөдөр цахим эрүүл мэнд төсөл буруу хэрэгжсэн. Үр дүн нь аудит өнөөдөр 30 хувь ч хүрэхгүй дүгнэж байна гэдэг бол худалдан авалт нь ухаалаг байгаагүй. Тэгэхээр бид хамгийн эхлээд энэ хамтын ажиллагааг өргөжүүлэх хүрээнд ерөөсөө л төр хувийн хэвшил, мэргэжлийн холбоод, энэ эрдэмтэн судлаачдын хамтарсан байдлаар ажлуудыг зохион байгуулъя гэж шийдээ, хамгийн эхний ажил программ хангамжийн худалдан авалтыг шилэн болгочихсон. И-тендерт mindgolia.mn уягдсан. Хэн ч давхардал хийдэл гаргахгүй гээд тэндээс худалдаж авч байгаа юм. Нэг гараанаас орсон компаниуд шууд өрсөлдөх боломжийг mindgolia.mn нээсэн. Энэ энэ цаг өрсөлдөх чадвар.../минут дуусав/

Г.Занданшатар: Тодруулах юм уу? Нэмж хариулах юм уу. Ням-Осорын Учрал гишүүн гүйцээж хариулъя.

Н.Учрал: Иргэн талд жишээ нь бид нар өнгөрсөн хугацаанд иргэн талд 2,

3-хан хүнтэй тэр компаниудыг mindgolia.mn дээр шилэн болгочихлоо. Хэн ч өрсөлдөх бололцоотой болгосон. Өнгөрсөн хугацаанд 15 нэр төрлийн дотоод бичиг солилцооны систем хэрэглэдэг байсан. Төрийн байгууллага хоорондоо уялдаагүй. Нийслэл болоод байна. Сангийн яам дотроо болоод байна гэсэн мөртөө хоорондоо солилцдоггүй. 8 тэрбум төгрөгийн цаасны хэмнэлтийг үүсгэж эхэлж байгаа юм. 15 системийг зүгээр л холбочихсон. Хоорондоо бичгээ солилцоно. Иргэн эндээс хожно. Хувь хүн ч байна уу, иргэн ч байна уу төрд гомдол санал гаргах бол шууд тэр цахимаар явуулах нөхцөлийг нь бүрдүүлээд тэрийг албан бичигт тооцъё гэж. Өнөөдөр шүүх хуралдааны товыг хойшлуулахын тулд бичгээр аваачаад шүүх дээр очиж саналаа өгдгийг болиулах хэрэгтэй шүү дээ. Тэгээд цахим систем хэрэгжүүлсэн мөртөө хууль дээр давхардал, хийдэл гаргаад байна гэхээр 169 хуулийн нэмэлт өөрчлөлтийг Их Хуралд өргөн барина. Тэр дүрэм журмын түгжэрэл хамт явж байж энэ технологийн дэвшилтэйгээ уялдсанаараа амьдралыг энгийн, хялбар болгоход өөрөө энэ цахим засаглал, цахим шилжилт бол бас үр дүнгээ өгнө гэж байгаа юм. Тэгээд цахим, цахим гээд ингээд ярихаар бол бид нарын амьдралаас их хол юм яриад байгаа юм шиг сонсогддог. Гэсэн хэдий ч өөрөө энэ цаасан хүнд суртлаасаа цахим хөнгөн сурталд шилжье гэх юм бол энэ цахим шилжилт дэвшилтэт технологи чинь амьдралыг энгийн хялбар болгоно. Үнэхээр 24 цаг энэ бүх хаалттай гэсэн зүйлүүд дээр гэрэл асна гэдэг чинь өөрөө энэ технологийн дэвшил юм байна.

Тэгээд түрүүн бас Цогтгэрэл гишүүний хэлж байгаагаар иргэд яг шууд яаж мэдэрч эхлэх юм бэ гэхээр энэ нэг цэгийн үйлчилгээ яг нэг цэг шиг ажиллаж эхэлнэ. Би энд онцгой анхаарч байгаа. Монгол Улсын Засгийн газар үүнд онцгой анхаарч байгаа. Бид нар улсын хэмжээнд төрөөс ямар нэгэн шинэ байр байшин барьж, хүн амьтан цалинжуулахгүйгээр Цахилгаан холбоо компани, энэ сүлжээ

компани, шуудан компани, операторынхаа компаниудаар дээрээс нь энэ франчайзын олон дэлгүүр, үйлчилгээний төвүүдээр дамжуулаад аутсорсинг хийгээд улсын хэмжээнд 395 нэг цэгийг ажиллуулж эхэлнэ. Энэ нэг цэг байхгүй газруудаар өнөөдөр Голомт, Хаан банк, Төрийн банк энэ хувийн Киоск нэвтрүүлж байгаа компаниудтай нийлүүлээд улсын хэмжээнд 600 гаруй киоск гарна. Энэ киоск дээр очиход төрийн бүх үйлчилгээг үзүүлнэ. Цаашлаад энэ дээр бид нар банкнуудтай ярихад зээлийг ч олгох бололцоотой. Тэгээд ерөөсөө төрийн үйлчилгээ хаанаас ч ойрхон байх л ийм л нөхцөлийг бүрдүүлж, Улаанбаатарт ирээд заавал оюуны өмчөөр баталгаажуулдаг биш. Тэр Увс аймгийн суманд очиж үйлчилгээгээ авчихдаг. Нэг ёсондоо бол сая өнгөрсөн хугацаанд тэр лавлагаа нэхэхгүй, нэхэмжлэх нь нэхэхгүй болгох ажлыг хийчихлээ. Тэгэхээр лавлагаа нэхэхгүй болохоор Төрийн банк ингээд нэвтрүүлээд эхэлсэн. Одоо бол Хас банк ингээд орчихлоо гэхээр банкн дээр очиход нэг удаагийн паспорт иргэн үзүүлэхэд өөр юм нэхэхгүй. Нийгмийн даатгалынх нь мэдээллийг иргэний зөвшөөрснөөр татаад, татварын мэдээллийг иргэний зөвшөөрснөөр татаад ингээд үзчихдэг.

Тэгэхээр хувийнхан өөрөө давхар мэдээллээ буюу тухайн хүн аль банк дээр ямар зээлтэй байсан бэ гэдэг мэдээлэл нь тэр банкны санд байвал түүнийг төрдөө солилцох ёстой байхгүй юу. Бид нар ерөөсөө дата эксчэйнж хийж чадаагүй. Би энэ ажлыг аваад гол бодсон зарчим бол энэ үйлчилгээ иргэдэд хүрэх ёстой юм байна. Иргэн талаасаа харъя гэдэг үүднээсээ гар утасгүй байгаа иргэдэд харааны бэрхшээлтэй иргэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд тэр дата интернэтгүй иргэдэд хүргэх үүднээс сонголтуудыг л өгье. Иргэн гар утсаараа үйлчилгээ авч болно. Нэг цэг дээрээ аваачиж болно. Киоскоос авч болно. Бүх төрлийн сонголтыг өгсөн цагт энэ хүнд

суртал буурна гэж ингэж ойлгож байгаа юм.

Г.Занданишатар: Бөхчулууны Пүрэвдорж гишүүн асуулт асууна. Хүн хариулж байхад битгий хурал үймүүлж бай. Үүнээс хойш. Өнөөдөр бас чи сануулгатай л байгаа даа.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр мэдээж энэ цахим шилжилт хамгийн том ажлуудын нэг. Тэгээд яамтай болсон нь бас тодорхой хэмжээгээр энэ ажлыг урагшлуулах тийм зайлиггүй шаардлага гарч байгаа учраас яамтай болгоод энийгээ нэлээн үр дүнд хүргэнэ гэж харж байгаа. Урьд нь нэг тийм сайд хариуцдаггүй, Ерөнхий сайдын доор явдаг. Тэгээд Ерөнхий сайдын ажил нь хүч хүрдэггүй. Ийм байдлаар нэг хавсарга маягаар явсан. Энийг яамтай болгохоор илүү урагшаа алхана гэж харж байгаа юм. Тэгээд бас тодорхой мэдэгдэж байгаа зүйл байна. Тэгэхдээ л одоо яая даа. Нэг машин товчоогоор гарахад л шууд гарч чадахгүй л хэмжээний ажил ч урагшаа явахгүй л байгаад байгаа юм. Энэ дээр бол шүүмжлэлтэй. Иймэрхүү ажлуудыг иргэдийн нүдэн дээр гарт баригдах, нүдэнд харагдах тэр зүйлүүдийг л хийвэл маш сайн байна л гэж танд зөвлөх байна.

Тэгэхээр Зөвшөөрлийн тухай хууль гарсан. Зөвшөөрлийн ер нь өнөөдрийн энэ Монгол Ардын намын Их Хурлын бас хамгийн сайн хуулиудын нэг Зөвшөөрлийн тухай хууль байгаа. Нийтдээ 1600 орчим зөвшөөрөл авдаг байсан бол энийг багасгаад 362 болгосон байгаа. Тэгээд 362 болгосон энэ зөвшөөрөл чинь дотроо энгийн болон тусгай зөвшөөрлүүд байж байгаа. Тэгэхээр хамгийн эхний ээлжид энгийн зөвшөөрлүүдийг маш хурдан цахимжуулах гэрээсээ, оффисоосоо бүх материалуудаа өгчихдөг. Янз янзын төрийн одоо жишээ нь ямарваа нэгэн зөвшөөрөл авлаа гэхэд Аж ахуйн нэгжийн гэрчилгээ гэхэд зүгээр шууд линкийг нь оруулаад л өөрөө хэлбэл тэр чинь төрд байгаа мэдээ шүү дээ. Тэр

линкийг нь татаад оруулаад явчих хэмжээний тэгээд нэг ганц 2 сканердах бичиг баримт байдаг түүнийгээ гар утсаараа сканердаад явуулчих ийм амархан программ хангамжийг хийгээд энүүгээрээ зөвшөөрөл олгох ажил чинь хамгийн чухал байгаа шүү. Мэдээж тусгай зөвшөөрлүүд нарийн шалгуурууд байгаа. Энэ дээрээ мэдээж тусгай зөвшөөрөл учраас тодорхой яам, Тамгын газрын үүдээр орох зайлиггүй шаардлага гарах байх. Бусад энгийн зөвшөөрөл ерөөсөө л гэрээсээ л хандаад авчихдаг ийм л программ хангамжийг яаралтай хийх хэрэгтэй байна. Тэгээд энэ зөвшөөрлийн хуулиар чинь 362-оос бусад үйл ажиллагаа ямарваа нэгэн байгууллага, хувь хүн үйл ажиллагаа явуулаа гэхэд ямар ч тийм зөвшөөрөл авах шаардлага байхгүй. Шууд үйл ажиллагаагаа явуулна. Тэгээд саяын нөгөө энгийн зөвшөөрөл гэхэд албан тушаалтан руу хандаад нөгөө линкээ явуулаад бүх аппликэйшнээ бөглөөд явуулаа гэхэд зөвшөөрлөө бөглөөд явуулаа гэхэд 21 хоногийн дотор ирэхгүй бол шууд нөгөө компани үйл ажиллагаа явуулах, зөвшөөрлийг нь хэвлэхдэг тийм л аппликэйшнийг л яаралтай хийх хэрэгтэй байна. Тэгээд энэ зөвшөөрлийн хууль 1 сарын 1-ээс хэрэгжиж байгаа. Тэгээд энэ бол таны хувьд хамгийн нэн тэргүүний иргэдийн гарт баригдсан. Өөрөөр хэлбэл энэ Их Хурлаас гаргасан хамгийн сайн хуулийг хамгийн энгийн хэрэглээ болгож чадах нь бол хамгийн нэн тэргүүний ажил шүү гэдгийг л хэлье. Тэгээд энэ дээр ямар санаа бодолтой байна. Хөрөнгө оруулалт энэ тэрээ тэр аппликэйшнийхээ хөрөнгө оруулалт маш сайн аппликэйшин хийх тэрний төлбөрөө яаж олох вэ. Энэ талаар би бас тэр Дэлхийн банкныхантай уулзсан. 3 сая долларын программ хангамжийг хийх талаар ярилцсан байгаа. Тэгээд энэ тал дээр бүгдээрээ сайн ямар ямар зүйл хийж байгаа вэ. Энэ дээр тодорхой хариултууд авъя.

Г.Занданшатар: Ням-Осорын Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Пүрэвдорж гишүүнд баярлалаа. Тэгээд миний хувьд би бас хувийн хэвшилд ажиллаж байсан хүний хувьд аливаа асуудлыг их зардал гаргаж, төрөөс мөнгө гаргаж хийхийг ерөөсөө хүсдэггүй. Салбар болгоны уялдааг хангаад арга эвийг нь олоод ажиллахыг л хүсдэг. Цахим хөгжлийн яам бол ер нь салбар дундын яам л юм байна лээ. Бүх яамны үйл ажиллагаанд оролцдог. Хуулиараа бид нар бол өөрөө мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх, тухайн яамны авах гээд байгаа программ хангамжид нь дүгнэлт гаргах, нийтийн мэдээллийн тэр үндэсний системтэйгээ холбох ажлыг зохион байгуулах ийм үүрэгтэй. Тэгэхээр энэ ажлыг л хийх ёстой. Анх намайг томилогдоход бол software авна, цахим түрийвч хийнэ гээд л худалдан авалт зарлалаа гээд л төсөв суулгая л гэсэн. Тэгээд би дэмжээгүй. Хувийнхан бүгдээрээ төлбөрийн систем хийчхээд байхад яахаараа бид нар хийдэг юм бэ. Нэг ч программ хангамжийн төсөв мөнгө тавиагүй шүү дээ. Энэ оны төсөв дээр манай яам. Гэхдээ mindgolia.mn гээд программ хангамжийн 100 гаруй бүтээгдэхүүн орчихсон. Энэ системийг бид нар хувийн хэвшлийн түншлэлээр нэг ч төгрөг гаргахгүйгээр хийсэн. 110 ТҮЦ машин Дата төв дээр байдаг байсан. Хаан Банк, Голомт банк, Хувийн киоскууд нийлээд бараг 500 гаруй ТҮЦ байхад төрийн үйлчилгээний ХҮР-аас мэдээллээ өгөхгүй л гацаагаад байсан. Өгсний хүрээнд улсаас нэг ч төгрөг гаргахгүйгээр 610 киосктой болж байгаа. Нэг цэгийн үйлчилгээг байгуулахад барилга авна, сандал ширээ авна гэдэг байсан. Үүний хүрээнд бид цахилгаан холбоо, шуудан сүлжээ компаниараа дэмжээд 400 орчим нэг цэгийг улсын хэмжээнд байгуулж байна. Ингээд ямар нэгэн зардал гаргахгүйгээр хийж болж байгаа. Тэгэхээр би Пүрэвдорж гишүүнд хэлэхэд энэ и-бизнес бол миний ажлын 3 том ажлын нэг. Би энэ 1 жилийн хугацаанд надад байгаа хугацаанд энэ ажлыг үр дүнд хүргэнэ. Тэгэхээр и-бизнес бол Засгийн газрын зүгээс Эдийн засгийн хөгжлийн сайд,

Шадар сайд, надаар ахлуулаад e-business.mn дээр би өөрөө сууж байгаа. Ажлын хэсгийг ахлаад. Яагаад гэхээр манай Пүрэвдорж гишүүн бол байнга энийг шаардаж байгаа. Тийм учраас бүр энэ дээр онцгой анхаарна.

Танд хэлэхэд ухаалаг засгийн хүрээнд бид нар энэ зөвшөөрлийн санг байгуулах дээр төсөв мөнгө нэмэх, тоног төхөөрөмж, лицензүүд дээр төсөв мөнгө тавьж ухаалаг засагт хүсэлтээ илэрхийлж ажлын даалгаварт суулгасан. Гэхдээ энэ Цагаан сарын өмнө 2 сарын 15-аас өмнө бол бид нар e-business.mn одоо license.mn гээд Сангийн яаман дээр байгаа, Улаанбаатар дээр ibonline гээд байгаа etongolia дээр бас хэдийн зөвшөөрлүүд байгаа. 208 зөвшөөрлийг бол цахимжуулах ажлыг эхний хэмжээнд 2 сарын 15-ны дотор нээж танд үзүүлж 208-ыг бол улсаас нэг ч төгрөг гаргахгүйгээр 2 сарын 15-ны дотор танд би үзүүлж урина гэж хэлье.

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 109.11-д заасны дагуу D-parliament.mn цахим хэлэлцүүлгийн платформ дээр байршуулсан Ерөнхий сайдын мэдээлэлтэй холбогдуулан иргэдээс ирүүлсэн саналууд дээр үндэслэж бүлгүүдийн төлөөлөл, намын бүлгүүдийн төлөөлөл Засгийн газрын гишүүнээс асуулт асууна. Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн Цагаанхүүгийн Идэрбат Засгийн газрын гишүүнээс асуулт асууна. Асуулт, хариулт 20 минут үргэлжилнэ. Шууд явна.

Ц.Идэрбат: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу Засгийн газрын мэдээлэлтэй холбогдуулаад тухайн сэдвээр сонирхсон

асуултаа ирүүлэх бололцоог Улсын Их Хурлын цахим хуудсанд 5 хоногийн өмнө байршуулах ийм хуулийн зохицуулалттай. Энэ хуулийн зохицуулалтын дагуу өнөөдрийн Засгийн газрын мэдээлэлтэй холбогдуулаад иргэдээс 6 асуулт ирсэн байна. Энийг би бас багцалж асууя гэж бодож байна.

Нэгдүгээрт, иргэн Батбаяраас манайд хамгийн сайн цахимжсан салбар нь аль вэ. Мөн нөгөө талдаа цахимжаагүй салбар нь аль юм бэ. Яагаад гэсэн ийм асуултыг асуусан байна.

Хоёрдугаарт, иргэн Баттулгаас хөдөөгийн иргэдийг аймаг, нийслэл рүү эмнэлгийн тусламж үйлчилгээ авахаар очиход 13А гэж маягт нэхэх юм. Цахим үндэстэн болж байгаа биз дээ. Энийг цаасаар нэгдэх юм байна.

Гуравт иргэн Лхаасүрэн цахим систем бол төрийн хулгайгүй болох ганц чухал зүйл. Төрийн байгууллагын бүх мөнгөн гүйлгээг ил болгох хэрэгтэй гэсэн ийм 3 асуулт иргэдээс бас ирсэн байна. Тэгээд энэ 3 асуултад хариултаа авчхаад, дараагийн асуултуудаа тавья.

Н.Учрал: Идэрбат гишүүний асуултад хариулъя. Манай улсад бол хамгийн сайн цахимжсан салбар дээр судалгаа хийж үзэхэд Монгол Улсад банкны салбарын хувьд нийт бүртгэлтэй цахим хэрэглэгч 6.2 сая байна. Банк бус санхүүгийн байгууллагын харилцагч бол нийт бас 4.8 сая орчим. Энэ бол яах вэ 92 хувь нь бараг нөгөө финтекийн харилцагч нар гэж бас үзэж байгаа. Ер нь банкны салбар маш сайн цахимжсан гэж хэлэх боломж бололцоотой. Тэгээд бид бол одоо төрийн зүгээс арилжааны банкнуудтайгаа Монголбанктай хамтраад ийм хамтын уялдааг илүү их сайжруулж ажиллаж байна. Үүний хүрээнд саяын тэр лавлагаа, дээрээс нь тэр нэхэмжлэлүүдийг одоо шийдвэрлэнэ. Нэг банканд тушаасан мөнгөө аваад тийшээ очоод ир гэдэг энэ байдлыг

зогсоохын тулд аль ч банкны теллер, ажилтан эдийн засагч тухайн иргэний зөвшөөрснөөр *lavлагаa.mn* рүүгээ орлоо. Лавлагаагаа, нэхэмжлэхээ бусад мэдээллүүдийг татаад авах буюу нөгөө хооронд нь гүйлгээд байх. Дээрээс нь банкнууд хоорондоо мэдээлэл солилцдог болж байгаа. Банкнууд хоорондоо гэхээр нэг банк дээр хэдий хэмжээний зээлтэй байгаа нь нөгөө банк иргэний зөвшөөрлөөр харж чаддаг. Тэгээд хуульд заасны дагуу анхны банкны дансыг нээлгэхэд очоод дансаа нэг удаа л аль ч банк дээр нээсэн дараагийн банк дээр очих шаардлагагүйгээр данс нээдэг нөхцөлийг бүрдүүлэх ажил чухал. Тийм учраас хийж байна.

Дээрээс нь банкны салбарт бид нар цаашидаа тоон гарын үсгийг нэвтрүүлж эхэлнэ. Энэ *e-business* ч гэсэн үүнтэй холбоотой учраас сайн цахимжсан салбар ер нь санхүүгийн салбар юм байна гэж бас хэлж болох байх.

Хоёрдугаар иргэний асуулт тэр 13А маягтын асуудал байгаа. Та бүхэн мэдээж байгаа. Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжсэн цахим эрүүл мэнд төсөл үндэсний тэр олон улсын аудитын байгууллага дүгнэлт гаргаад чанаргүй гээд дүгнэгдсэн. Энэ бол төрийн бас тогтворгүй байдалтай бас мэдээж холбоотой байх. Үе үед олон сайд нар бас томилогдоод. Тэгээд ажил эхлээд явж байтал дараагийн удирдлагууд ирдэг ч гэдэг юм уу, дээрээс нь хамгийн нөхцөл байдал яг бодитоор үнэн дүгнэлт хийлгэе гэвэл ухаалаг худалдан авалт хийж л чадаагүй. Эрүүл мэндийн яамд яг сайн ИТ-ийн мэргэжилтэн авъя гэхээр цалин хөлс, нөхцөл бололцооны хувьд мэдээж тэр шалгуур хангасан хүнийг авахад маш хэцүү. Тийм учраас даалгавар гаргахдаа буюу төр өөрөө юу хүсэж байгаагаа худалдан авалтаараа зарлаад нөгөө тал хийх гэж байгаа тал нь яг ямар зүйлийг хүссэнийг нь хийж өгөх дээрээ хоорондоо бүрэн ойлголцож чаддаггүй. Энэ нь болохоор мэргэжлийн хүмүүс бас дутмаг байсантай холбоотой. Тийм учраас бид

мэргэжлийн яам байгуулагдсан учраас энэ худалдан авалтууд дээр нь туслалцаа үзүүлээд Эрүүл мэндийн яамтай, Цахим хөгжил, харилцаа холбооны яам хамтраад бас ажлын хэсэг байгуулаад цахим эрүүл мэнд төслийг юунаас болсон бэ гэдэг дүгнэлтийг гаргасан. Дээрээс нь цаашидад хувийн хэвшлийн түншлэлээр хэрхэн энэ ажлыг урагшлуулах вэ гэдэг дээр бас дүгнэлтийг гаргасан. Тэгэхээр иргэд бас үүн дээр зөв ойлгох ёстой. Эрүүл мэндийн салбарт сайн цахимжсан сайн дэвшилүүд бол гарч байгаа. Тийм ч учраас би та бүхэнд бас и-картыг хэлсэн. Дээрээс нь одоо нэгдүгээр шатлалын эмнэлгүүд бол бүгдээрээ цагаа захиалгаа онлайнаар, утсаар захидаг болсон. Одоо энэ и-картыг илүү их идэвхжүүлж, мэдээллийн санг нь сайжруулах ажлууд бол хийгдэнэ. 13А маягтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг 2023 оны 2 дугаар улиралд багтааж бид нар энэ эрүүл мэндийн төсөлтэй холбогдохгүйгээр манай яамны зүгээс дэмжиж ажиллаж хэрэглээнд нэвтрүүлнэ гэдгийг хэлье.

Ц.Идэрбат: Баярлалаа. Сая Засгийн газрын гишүүн Учрал сайдаас энэ цахим харилцаа холбоотой хийж хэрэгжүүлж байгаа ажил дээр бас нэлээн танилцуулгууд хийлээ. Одоогоос сар гаруйн өмнө шиг санаж байна. Оны өмнө. Ер нь энэ төрийн үйлчилгээ энэ иргэд өөрийнхөө мэдээллийг аваад төрийн болон хувийн хэвшлийн бүх л хэлбэрээр үйлчлүүлэхэд нотариатаар батлуулах шаардлагагүй болоод 74 нэр төрлийн бичиг баримт гэдэг ийм зүйлийг хэлж ярьсан. Гэтэл 2023 оны 1 сарын 2-ны өдөр MN25 дугаар телевизийн 25 цаг мэдээллийн хөтөлбөрөөр энэ хэрэгжихгүй байна. Ард иргэдийгээ арилжааны банк дээр очиход нөгөө л нэг иргэний үнэмлэхээ батлуулаад ир, нийгмийн даатгалын дэвтрээ нотариатаар батлуулаад ир гэдэг ийм шаардлагууд яваад байна гэдэг ийм зүйл бас яригдсан. Энэ дээр бас яг ямар тайлбар хэлэх вэ. Үнэхээр бидний ярьж байгаа зүйл яг амьдрал дээр бас яг

буухгүй байгаа юм уу гэдэг ийм зүйл байгаа юм.

Хоёрдугаарт, ер нь харилцаа холбооны салбар зөвхөн 2 хүн хоорондоо холбогдох салбар биш болсон. Энэ дэлхийтэй холбогдох, тэр битгий хэл банк, санхүү, мэдээллийн хэрэгсэл гээд олон зүйлүүд байна. Тэгэхээр энэ дээр Монгол Улсын энэ газар зүйн нөхцөл байдал энэ тархай бутархай байдаг энэ олон зүйлүүдээс болоод энэ үүрэн холбоонд хөдөөгийн багуудыг холбох асуудлууд бас сүүлийн үед эрчтэй яригдаж байгаа юм. Иргэд ч гэсэн энийг маш ихээр хүсэж байгаа. Шаардаж байгаа. Яагаад гэвэл одоо хөдөө малчин гэхээрээ бүх зүйлээс алслагдсан, таслагдсан байхыг бас хүсэхгүй байна. Тэгээд энэ дээр гол зохицуулалт хийдэг, энэ бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан гэж байгаа. Яг энэ үүргийн сангийн санхүүжилтээр явах юм ер нь хэдэн жилд энэ багуудыг бид нар үүрэн холбооны сүлжээнд холбох боломжтой юм. Цаашдаа энэ Монгол улсын энэ 1600 баг яг хөдөө алслагдсан гээд үзэх юм энэ чинь 1200-аад баг байгаа. Энэ багуудыг бид нар ер нь яаж үүрэн холбооны сүлжээнд холбох юм бэ гэдэг ямар хэтийн төлөвлөгөө байгаа вэ гэдэг дээр.

Дараагийнх нь өнгөрсөн 2022 оны намрын, хаврын чуулгануудаар энэ цахим шилжилтийн олон хуулиудыг Улсын Их Хурлаас баталсан. Цахим гарын үсэгтэй холбоотой нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль гээд хуулиуд баталсан. Мэдээж төрийн үйлчилгээ хөнгөн шуурхай болгоход зориулагдсан энэ цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилт би бүр тоо байгаараа гарах бололцоотой гэж ингэж үзэж байгаа. Насанд хүрсэн 2 сая 200 мянган хүний хэд нь өнөөдөр бас цахим гарын үсэг аваад байна. Энийг авхуулахын тулд бусад мэргэжлийн байгууллагууд яаж хамтарч ажиллаж байна. Ялангуяа Улсын бүртгэлийн газар гэх мэтчилэнгүйг.

Дараагийнх нь Нийтийн Мэдээллийн ил тод байдлын тухай хууль гэж. Энэ бол бас өнөөдөр шударга ёс үгүйлэгдэж байгаа, төрийн шилэн тунгалаг байдал үгүйлэгдэж байгаа ийм цаг үед би цаг үеэ олсон хууль гэж ингэж хардаг. Албан тушаалтнуудад хяналт тавих, мэдэх эрхээ хангах, хардах эрхээ ч эдлэх ийм л бололцоотой хууль. Энэ хуулийн хэрэгжилт бас ямархуу шатанд явж байгаа вэ гэдэг дээр энэ 3 зүйл дээр бас асууя гэж бодож байна.

Н.Учрал: Идэрбат гишүүний асуултад хариулъя.

Нотариаттай холбоотой 74 төрлийн лавлагааг Нотариатчидын холбоо бол өөрсдөө зөвшөөрөөд бид бол ямар нэгэн лавлагаа нэхэхгүй гэдгээ зөвшөөрөөд бид нар хамтраад гэрээ хийгээд ажиллаж байгаа юм. Нотариат бол би нотариатчид өөрсдөө нэхээд байгаа гэж бас бодохгүй байгаа юм. Дахиад тэр нөгөө цаана нь байгаа байгууллага нь нэхээд байгаа учраас энийг нотариатаар батлуулаад ир гээд хүсдэг. Тэгээд нотариатууд, нотариатч хүмүүс өөрсдөө юу гэж байгаа вэ гэхээр тухайн иргэн хүрч ирээд би энийг заавал нотариатаар батлуулъя гэхээр чинь би батална шүү дээ гэдэг ийм тайлбар хэлээд байгаа юм. Тэгээд ер нь бүхэлдээ ийм хандлагын өөрчлөлт хийхгүй болохгүй байна. Анх энэ лавлагааг нэхэхээ больё гээд хэлсэн чинь бүгдээрээ өөр өөр системтэй учраас болохгүй байна гэхээр нь *lavлагаа.emongolig.mn*-ээр ороод та нар OTP буюу *one time passport* гээд гар утсаараа явуулчих, гар утас биш и-монгол аппликэйшин руу ороод и-монголоороо явуулчих, ухаалаг утасгүй бол мессежээрээ явуулчих гээд шийдсэн. Тэгсэн чинь банкнууд өөрийн дотоод журамтай гэдэг зарим нь тайлбарыг хэлээд байдаг. Тэгээд заримдаа лавлагаанууд нэхдэг асуудал үүсээд байгаа юм. Тэгэхээр иргэд, төр, хувь бүгдээрээ энэ шийдэл рүүгээ хандлагын өөрчлөлтийг хийе л гэж би хүсээд байгаа юм. Нотариатчидын танхим бол ямар

нэгэн байдлаар лавлагаа нэхэхгүй, манай системийг хэрэглэе гэсэн. Хувийн байгууллагууд ч гэсэн энийг хэрэглэхийг бид нар гэрээ хийгээд өгье. Арилжааны банкнууд ч гэсэн энийг нэвтрүүл. Өнгөрсөн хугацаанд төрийн лавлагааны системийн ашиглалтын судалгаа гаргахад Ариг банк, Богд банк, Голомт банк, Капитрон, Мбанк, Тээвэр хөгжил, Төрийн банк, Хаан банк, Хас банк, Худалдаа хөгжлийн банк дээрээс нь хувийн байгууллагуудаас Юнител гээд ингээд аваад үздэг. Лавлагааны тоон мэдээллүүд систем хэрэглэгчдийн тоон мэдээллүүд гэхээр бараг 2023 оны 1 сарын 4-ний байдлаар гээд 3675 удаа гээд ингээд тоонууд нь нэмэгдээд яваад байгаа юм. Ер нь бол жишээ нь Төрийн банкны бүх салбар нэлээд сайн ажиллаж байна. Ямар нэгэн зүйл нэхэхгүй. Тийм учраас Төрийн банктэй үйлчилгээ үзүүлэх гэж байгаа бол нотариат дээр очиход нотариатаас заавал ямар нэгэн юм хүсээд байх шаардлага байхгүй. Нотариат таны иргэний үнэмлэхийг тамга дараа мөнгө аваад баталж байгаа юм байхгүй.

Тэгэхээр үндэсний хэмжээнд бүгдээрээ энэ төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газраар дамжуулаад төрийн нэг цэгийн үйлчилгээгээ нэг төгөлдөржүүлээд, тэгээд иргэд ч гэсэн хувийн хэвшил ч гэсэн төрийн байгууллагууд ч гэсэн өөрсдөө шахаад энэ системүүдээ хэрэглээд эхлээч ээ. Тэгээд бүгдээрээ ийм хандлагын өөрчлөлт хийе гэдгийг хэлмээр байна.

Тоон гарын үсгийн хувьд бол одоогийн байдлаар 483.953 олгогдсон. Тоон гарын үсэг. Гэхдээ хэрэглээ тийм сайн биш байгаа. Хэрэглээ нь сайн биш байгаа гэх нь ийм хөшүүрэг хэрэгтэй. Цахим гарын үсгийн хууль батлагдаад 10 жил болоход бид нар 30 хэдэн мянга гаргасны чинь шалтгаан нь юун дээр байсан бэ гэхээр дандаа Нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан дээр нөгөө и-тендерт оролцоход тонн гарын үсэг уншуулдаг байсан. Тэгэхээр тэнд нь

нэг ийм хөшүүрэг хаахаар тоон гарын үсыг хэрэглэдэг. Түүн шиг төрийн байгууллагууд өөрсдөөсөө яаж эхлэх ёстой. Тэгээд бичгээ солилцоход 15 системийг бид нар уяад док икс дээр уячихаар тухайн яам ямар систем хэрэглэдгээсээ үл хамаараад хоорондоо бичиг солилцдог болчихсон байхгүй юу одоо. Их Хуралтай ч гэсэн холбогдсон. Тэгээд бид нар бичгийг нь солилцохдоо тоон гарын үсгийг хэрэглээд хэвшчихье. Өөрсдөөсөө. Их Хурлын гишүүд, төрийн байгууллагууд өөрсдөө тоон гарын үсгээ хэрэглээд хэвишье. Тоон гарын үсэг cloud дээр гар утсан дээрээ тавиад л явуулж байхад энд ямар нэгэн асуудал үүсэхгүй шүү дээ. Өнөөдөр төрийн байгууллагын дарга нар өөрөө цаасан дээр зурчхаад туслах нь тоон гарын үсгийг нь дараад байгаа шүү дээ. Тэгээд энийгээ болимоор байгаа байхгүй юу. Тэр хандлагын өөрчлөлтийг хүн бүр хамтарч хэрэгжүүлэх нь бол чухал байна гэдгийг хэлмээр байна.

Ц.Идэрбат: 2 дахь асуудал буюу энэ алслагдсан бүх багуудыг үүрэн холбооны сүлжээнд холбох энэ асуудлыг ер нь улс орон даяар яаж холбоно гэж төлөвлөж байгаа вэ. Хэзээ ер нь энэ ажил дуусна гэж харж байгаа. Том ямар зорилт байгаа вэ. Би түрүүнд нэлээн тодорхой хэлсэн шүү дээ. Хөдөөгийн малчид өнөөдөр холбоо харилцаа гэдэг зөвхөн утсаар ярих хэрэгсэл биш болжээ. Тэнд хэн ч тийм холбоо харилцаагүй байхыг хүсэхгүй байна. Өнөөдөр та бид ч гэсэн сүлжээ 1 цаг тасрахад ямар их юмнаас хоцордог билээ, Ямар их төвөг чирэгдэл учирдаг билээ. Тэгэхээр тийм юмнаас малчид мөн сүлжээтэй байхыг хүсээд байна. Тэгэхээр энэ бас цахим үндэстэн болоход бас нэлээдгүй том жин дарах том ажил байх гэж ингэж үзэж байгаа. Хариултаа авъя.

Н.Учрал: Цахим шилжилт бол ийм хатуу болон зөөлөн дэд бүтэц дээр явдаг. Хатуу дэд бүтэц гэхээр бол төмөр замаар бол тэр төмөр замыг нь тавьж байна. Хатуу дэд бүтэц бол одоо бидний

яриад байгаа шилэн кабелиар интернэт сүлжээнд холбож байна. Энэ сайн зам дээр вагон явах ёстой шүү дээ. Тэр вагон нь бол өөрөө зөөлөн дэд бүтэц ямар нэгэн гацаа тотгоргүйгээр явах ёстой. Тэгэхээр хатуу дэд бүтэц хөгжүүлээгүй цахим шилжилт гэж байхгүй. Тэгээд түрүүн бас гишүүд хэлж байсан. Малаа ингэж тоолдог орон Монголд байхгүй. Дэлхийд байхгүй байна гэж. Ингэж мал тоолохгүй гээд. Тэгвэл мал тоолох ганцхан л арга байгаа шүү дээ. Хиймэл дагуул хөөргөнө. Тэгж байж малаа тоолно, модоо тоолно шүү дээ. Тэрнээс биш бид өөрөөр яаж шийдэх вэ гэдэг ийм асуудал.

Тэгэхээр Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан байгуулагдсанаас хойш 2009-2022 онд нийтдээ 472 багийг сүлжээнд холбоод 38 тэрбум төгрөг зарцуулсан юм байна. Өнгөрсөн хугацаанд. Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан болон улсын төсвөөр жилд дунджаар нэг 40 орчим багийг л холбодог байсан. Одоо бол өнгөрсөн онд бол төр, хувийн хэвшлийн түншлэлээр нийтдээ 275 багт 4G сүлжээ оруулсан. 275 багт. Энэ бол маш том тоо гэсэн үг. Ойрын 5 жилдээ л байгаагүй ийм том тоо. Үүний дэвшил нь бол юу вэ гэхээр хувийн хэвшлийн орж байгаа газар, төр нь давхцаж ордоггүй. Ингээд хамтын ажиллагааны үр дүнд. Тэгэхээр бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан гээд операторууд өөрсдөө бүрдүүлдэг төсвөөс тусдаа бүрдүүлдэг хамгийн эрүүл нэг сан байгаа шүү дээ. Энэ бол манай оператор компаниуд өөрсдөө энэ мөнгийг бүрдүүлдэг. Тэгээд энэ дээр өөрсдөө хяналт тавих бололцоог нь бид нар бүрдүүлж өгөөд бүх нийтийн үйлчилгээний үүргийн санг ийм хяналттай болгож байгаа. Мөнгийг нь өөрсдөө бүрдүүлдэг хүмүүс үүнийгээ хяна. Тэгээд тэр шилэн кабелийг оруулахаа хамтраад хэрэгжүүлэе гэж үзэж байгаа юм. Ер нь бол бусад багуудыг холбох ажлыг төлөвлөгөө гаргаж байна. Тэгээд бас Их Хурлын гишүүдэд бас аймгуудын дарга нартай гэрээ хэлцэл хийх үеэр бол яг эцсийн

байдлаар танилцуулна. Одоо судалгаа хийгдээд явж байна. Энэ жил бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангаар гаднын зээл тусламжаар гээд дээрээс нь хувийн хэвшлийн санхүүжилтээр гээд хамтарч хэрэгжүүлнэ.

Ц.Идэрбат: Дараагийн асуулт. Би бас тэр нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилт. Тэр бол би хэлээд байгаа. Иргэдэд өнгөрсөн чуулганы завсарлагаагаар явахдаа энэ талаар маш сайн хэлсэн. Иргэд маш их сонирхож байгаа. Тэр хардах эрх, мэдэх эрх. Энэ бүх зүйлүүд маань энэ хуулийн хэрэгжилтээр бүрэн хангагдаад явах юм байна гэдэг ийм зүйлийг ярьж байгаа. Хэн нэгэн албан тушаалтны туслах байдаг юм уу нарийн бичиг байдаг юм уу тэр хүмүүсийн үүдэнд очиж тэдний өдрийн тэр шийдвэрийг харъя гэж хад мөргөхгүйгээр зөвхөн өөрөө ороод хараад үзээд явчих ийм бололцоотой ийм л зорилготой хууль. Тэгэхээр энэ хуулийн хэрэгжилт бас яг амьдрал дээр ямар байдалтай байгаа вэ гэдэг дээр холбогдох агентлагийнхан хариулаач.

Н.Учрал: Нийтийн мэдээллийн ил тод байдлын хууль бол авлигын эсрэг маш том хууль. Хүний мэдэх эрхийг хангасан. 68 нэр төрлийн мэдээллийг ил болгосон. Үүргийг мэдээлэл хариуцагч нарт хүлээлгэсэн. И-Монголиагаар дамжаад иргэнд тухайн таны тийм мэдээллийг ашиглалаа гээд мессеж ирээд байгаа чинь нотификэйшин ирээд байгаа чинь мэдээж хариуцагч нараас явуулж байгаа мэдээлэл шүү дээ. Газар зүй, геодезийн мэдээллийг та авлаа. Та газрын мэдээллийг авлаа. Бүртгэлийн мэдээллийг авлаа гээд тань руу илгээгээд байгаа ч таны зөвшөөрлөөр. Тэгэхээр мэдээлэл хариуцагч нар энэ 68 төрлийн мэдээллийг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл өөрийнхөө вэб хуудсаараа мэдээлэл өгөх үүрэг хүлээж байгаа юм. Энэ хуулийн хэрэгжилтийг хангуулахаар Хууль зүй, дотоод хэргийн яам, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын хамтарсан орон тооны бус зөвлөл

хуулиар ажиллах ёстой. Зөвлөлийг байгуулаад Хууль зүйн сайд ахлаад явж байгаа. Бид нар тайлангуудыг сонсдог. Одоо бол энэ 50-аас дээш гараагүй 48 орчим хувьтай л байна. Үнэлгээ хийхэд. Нэг ёсондоо төрийн байгууллагууд мэдээллээ хариуцагч нар мэдээллээ ил тод болгохгүй байна. Газар зохион байгуулалт ил болох л ёстой, Ерөнхий төлөвлөлт ил болох л ёстой. Өнөөдөр орон сууцанд орох гэж байгаа иргэн тухайн орон сууцыг улсын комисс юу гэж дүгнэсэн юм. Комиссын дүгнэлт дотор мэргэжлийн хяналт нь юу гэж дүгнэсэн юм. Барилга хөгжлийн төв нь юу гэж дүгнэсэн юм, чанар шаардлага хангаж байсан юм уу эсэх асуудлыг харж байж тухайн орон сууцыг худалдаж авах ёстой. Үгүй бол үл хөдлөх авдаг, тэгээд л бараг 2, 3 сар хүрэхтэй үгүйтэй дээврээс нь ус гоожчихдог. Тэгээд бас нэг ар, өврийн хаалга хэрэглээд комисс хүлээгээд авчихсан л гээд ийм юм яриад байна. Комиссын дүгнэлт ил болох л ёстой. Улаанбаатар хотын түгжрэл өнөөдөр 2 давхар байрны зөвшөөрөл авчраад 20 давхар байшин барьчихсантай л холбоотой шүү дээ. Энэ чинь ил болох л ёстой. Уул уурхайн лицензүүд ил болох л ёстой, Дархан цаазтай уул газрыг хашаалчихсан хүмүүсийн нэр ус ил болох л ёстой. Өнөөдөр энэ хулгай дээрэм, авлига ил тод нийгмийг бий болгоё гээд байгаа иргэдийн шаардлага дээр хараад үзэхээр ил болго л гэж хүсэж байна шүү дээ иргэд. 24 цаг гэрэл асааж өгөөч. Энэ харанхуй хананы цаана нууц гэж хаахаа болиоч л гэж байна шүү дээ. Тийм учраас энэ төрийн өмчийн компаниуд ТҮЗ-ийн гишүүдийг ил болгох ёстой шүү дээ. Энэ хуулиар. Тэгэхээр энэ 50 хувьд ч хүрэхгүй байгаа. 48 хувьтай. Их Хурлын гишүүд үүнийг шахаж шаардаж өгөөч гэж би хүсэж байна. Төрийн байгууллагууд мэдээлэл хариуцагч нар энэ мэдээллийг ил болго. Тэгж байж цаашаа бид нар бас илүү урагштай явах юм байна. Нийтийн мэдээллийн ил тод байдлын хуульд заасан 68 төрлийн бусад мэдээллийг хааж байгаа биш. Мэдээллийн эзний зөвшөөрлөөр цуглуулж, боловсруулж

ашиглах эрх нь байгаа. Тэрнээс хааж байгаа юм биш. Энэ 68 бол зөвшөөрөл авах шаардлага байхгүйгээр олон нийтээр ил болох ёстой гэж ингээж үзэж байгаа юм. Бид тэгээд и-танхим гээд.../минут дуусав/

Г.Занданшатар: Асуулт хариултын цаг дууссан байна. Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн, Ардчилсан намын бүлгийн дарга Одонгийн Цогтгэрэл Засгийн газрын гишүүнээс асуулт асууна. Асуулт хариулт 20 минут үргэлжилнэ.

О.Цогтгэрэл: Цөөхөн асуулт байна. Энэ хариулт ер нь энд бид нар цахим шилжилт, дижитал шилжилт гэдэг чинь өөрөө дижитал цаана тоон гэсэн утгатай. Тоогоор бүгдийг илэрхийлэх гэдэг утга үүний цаана явж байгаа. Тэгэхээр цахим шилжилтээсээ гадна энэ ажлынхаа үр дүн болоод энэ хариултууд дээр хэлж байгаад аль болох тоотой бас хариулж өгөхийг хүсье. Жишээ нь иргэн юу хожсон бэ гэдэг асуулт дээр би бараг бас тоо сонссонгүй. Ерөнхий зүйлүүд сонслоо. Ер нь тэр явал шилжилт хийсэн гэж үзэх юм, юуг дижитал шилжилт гээд байгаа юм гэдэг тэр ойлголт дор бас тоог нь авахыг хүссэн. Иргэний асуултаас ихэнх нь асуугдах шиг болсон. Тэр нэг юуны нөгөө нээлттэй данс. Цахим дансны ил тод байдлыг хөтлөлт. Тэр дээр яг төрийн байгууллагууд ямар хувьтай, ямар биелэлттэй явж байгаа билээ. Тэр дээр нэг тоо хэлж өгөөч. Тэр иргэний асуулт дээр тэр жаахан дутуу үлдчих шиг болсон.

Дараагийн нэг үндсэн асуулт нь. Ер нь явсаар байгаад Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас хийж байгаа ажил гэдэг чинь төрийн мөнгөөр татвар төлөгчдийн мөнгөөр хийж байгаа ажил. Татвар төлөгчдийн мөнгөөр хийж байгаа ажил яг ямар үр өгөөжтэй хийгдэж байгаа вэ гэдэг эцсийн дүндээ өнөөдрийн энэ тайлангийн утга учир бас

байгаа байх гэж бодож байна. Жишээ нь энэ дээр нэг тоо харахад Америкийн нэгдсэн улс тайлан дээр ч явж байсан. 58 тэрбум доллар цахим шилжилтэд зарцуулж байна гээд. Энийг 330 сая хүнд хуваахаар 170 доллар орчим гарч байх шиг байна. Гэтэл манай цахим шилжилтэд ямар хэмжээний мөнгө зарцуулсан бэ. Зарим эх сурвалжуудаас 900 тэрбум төгрөг зарцуулжээ гэдэг тоо бас явдаг. Тэгэхээр энэ цахим шилжилтэд зарцуулж байгаа энэ нийт төсвийн мөнгөнийхөө үр өгөөжийн талаар нэг мэдээлэл өгөөч. Би нэг мэдээлэл харсан. Зөвхөн эрүүл мэндийн цахим программ хангамжийн асуудал дээр 19.5 сая долларын гэрээ хийгээд одоо 10-аад сая доллар нь гарчихсан байгаа гээ. Энэ дээр Дэлхийн банкнаас хэрэгжиж байгаа төсөл юм. Дэлхийн банкнаас энэ төсөлдөө өөрт нь аудит хийлгэсэн нэг ийм дүгнэлт байна л даа. Энэ дээр гэрээний нийцлийн ерөнхий түвшин 29 хувьтай. Энэ 7 жил хэрэгжиж байгаа төсөл юм байна. 29 хувьтай. 20-оод сая доллар буюу бараг 70, 80-аад тэрбум төгрөгийн үнэтэй төсөл одоо бараг хэрэгжээд дуусаж байх ёстой. 7 жил явж байгаа төсөл. Гэрээний нийцэл 29 хувьтай, стандарт программ хангамж 52 хувьтай. Тусгай программ хангамж 31, бичиг баримтын нийцэл 13 хувьтай, зорилт ба үр дүн 0 гэсэн. Энэ яг Дэлхийн банкны аудитын дүгнэлт л байна л даа. Энэ дүгнэлттэй холбоотой бас нэг мэдээлэл өгөөч.

Дахиад дээрээс нь тэр татвар төлөгчдийн мөнгө хэрхэн үр дүнтэй зарцуулагдаж байгаа вэ. Энэ 900 тэрбум төгрөг гэдэг хэр баталгаатай мөнгө юм. Эндээс би зөвхөн нэг төслийг нь эрүүл мэндийн одоо үндсэндээ цахим эрүүл мэнд төслийн тухай л нэг жишээ асуулаа. Энэ 2 дээр тодорхой болж өгвөл тоон утгатай тайлбарууд өгөөч.

Н.Учрал: Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя. Өнгөрсөн хугацаанд 2010-2021 оны хооронд яам болон тэдгээрийн харьяа байгууллагуудад нийт

904 цахим төсөл, хөтөлбөр хэрэгжсэн гээд бид дүгнэлт гаргасан. 919 тэрбум 150 сая төгрөг. Ийм судалгаа. Эдгээр төсөл хөтөлбөрийн 43 хувь нь хандивлагч орнуудын зээл, буцалтгүй тусламж. 53 хувь нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн. 53 хувь нь. Үр дүнг бол хэмжихэд их бэрхшээлтэй. Ер нь бол энэ төсөл хөтөлбөрүүд жишээ нь олон улсын зээл санхүүжилтээр хийгдсэн төсөл хөтөлбөрүүд бол аудитын байгууллагын дүгнэлт гаргаад, жишээ нь саяын таны тэр 29 хувь гэдэг чинь гаргачхаж байгаа болохоос биш бид нар энийг хөндлөнгөөс дүгнээд хэмжиж болохуйц зүйл биш. Нөгөө 640 хүүхдийн сургууль баригдсан уу, баригдсан гэдэг шиг яг ийм тооцоолуур биш. Тэгэхээр энэ дээр би яг үр дүн нь хэд байсан гэдгийг хэлэхэд бэрхшээлтэй. Дижитал бол мэдээж энэ тоон гэсэн утгыг агуулж байгаа учраас тодорхой ярья. Иргэн төрийн үйлчилгээ авахдаа үйлчилгээ үзүүлж байгаа руу ирж буцах үйл ажиллагааны зардал, иргэн төрийн үйлчилгээ авахдаа зарцуулж байгаа хугацаанаас үүдэлтэй зардал, иргэдэд төрийн үйлчилгээ авахад шаардагдах зардлууд гээд бид нар бүх нарийвчилсан статистикуудыг харьцуулаад зардлын тооцоог бол гаргаад ер нь И-Монголиа нийт амжилттай авсан үйлчилгээ буюу цаасыг хэдэн хувь хэмнэсэн юм бэ гэхэд л жишээ нь бодитоор 4 тэрбум төгрөгийн цаасан хэмнэлт хийж байна. Цаашаа бол 15 систем нэгдээд бид нар цааснаас бүтэн салчих юм бол 8 тэрбум төгрөг жилд бичиг солилцоогоор хэмнэх бололцоо бол байна гэдгийг бол бас харж байгаа. Энэ бас тодорхой дэвшил бол гарна. Эдийн засгийн үр өгөөжийн хувьд жишээ нь төрөөс албан бичиг цахим солилцоогоор жишээ нь ингээд унааны зардал, бичиг баримтын зардал, цаг хугацаанаас үүдэлтэй зардал гэхэд л шууд дээр нь нэмэгдээд явчихдаг. Тэгэхээр эндээс чинь ингээд давхар бас хэмнэлтүүд үүснэ гэж ойлгож байгаа. Тэгэхээр ер нь бол татвар төлөгчдийн мөнгөөр цахимжилт хийснээрээ бид нар

илүүтэйгээр хэмнэлт үүсгэж байж л илүү үр дүнд хүрнэ гэж тооцож байна.

Цахим эрүүл мэнд дээр бол 29 хувийн гүйцэтгэлтэй байсан. Надад бол сүүлийн байдлаар энэ цахим эрүүл мэндийн зээлийн нийт дүн нь 19 тэрбум 500. Авсан санхүүжилт нь 8.8 тэрбум төгрөгийн л санхүүжилт авсан, авах үлдэгдэл нь 10 тэрбум байсан. Тэгээд ерөнхийдөө бол энэ төслийг бүтэн цахим эрүүл мэнд дээр авчихсан зүйл байхгүй. Харин “Ухаалаг засаг 1” төслийн хүрээнд бол хэрэгжилтийн үнэлгээ хангалттай гэж үнэлэгдэж байгаа. Тийм учраас “Ухаалаг засаг 2” үргэлжилж хэрэгжинэ гэдэг дүгнэлттэй байна. Цахим яам байгуулагдсанаар бол татвар төлөгчдийн мөнгийг илүү ухаалгаар, амьдралд нь үр өгөөжөө өгөхөөр л зарцуулах ёстой. 2-т бол “Ухаалаг засаг 2” төслийн хүрээнд бид мэргэжлийн худалдан авалтыг хийж, амьдрал дээр үр өгөөжтэйгөөр энэ төслийн хэрэгжилтийг хангуулна.

О.Цогтгэрэл: Төр дээр асар их дата мэдээлэл цуглаж байгаа байх. Энэ дээр хиймэл оюун ухаан гэдэг зүйлийг хэр зэрэг ашиглаж байгаа болоод ашиглах чадавх, ашиглалт хэр зэрэг байдаг юм. Эндээс дахиад дүгнэлт хийгээд ургуулаад төрийн бодлого шийдвэр болоод энэ улс орны хөгжил дэвшилд ашиглаж байгаа энэ дата ашиглаж байгаа ашиглалт ер нь ямар байдаг юм.

Н.Учрал: Нийтийн мэдээллийн хуулиар болоод Хувь хүний мэдээлэл хамгаалах хуулиар бол нөгөө нээлттэй өгөгдлийн жагсаалтыг Засгийн газар батлах ёстой. Тэгээд боловсруулагдаагүй мэдээллийн 606 жагсаалтыг сая Засгийн газраас баталчихсан. Тэр 606 жагсаалтыг бид нар олон нийтэд нээлттэй болгож байгаа. Тэгснээрээ нөгөө хувийн компаниуд, бизнес эрхлэгч нар нь дата ашиглаад бизнесээ хийхэд нөгөө боловсруулагдаагүй мэдээллийг ашиглах ийм бололцоог бүрдүүлнэ. Үндэсний аюулгүйн зөвлөлтэй хамтраад

Үндэсний статистикийн хороотой хамтраад бид нийтийн мэдээллийн нэгдсэн санг бий болгохоор бас зорьж ажиллаж байгаа. Ухаалаг засгийн хүрээнд ч гэсэн энэ ажил бол хийгдэнэ. Одоо бол бид нар яг боловсруулагдаагүй мэдээллийг ашиглаж байгаа сайн үзүүлэлт алга. “Ухаалаг засаг 1” төслийн хүрээнд тэр хувийн компани Интерактив гэдэг компаниар энэ төрийн энтерпресс архитектур хийгдсэн. Одоо бол Зам, тээврийн хөгжлийн яам дээр энэ sendbox дээр туршаад Зам, тээврийн хөгжлийн яам дээр ийм сайн шийдлийг хийгээд туршсан байгаа. Зам, тээврийн хөгжлийн яам дээр очоод үзэх юм бол энэ төслийн хүрээнд жишээ нь өнөөдөр хэдэн вагон явж байна, орж байна, гарч байна, машин хэдэн цагийн үед хэд явж байна гээд бүх тооцоолуурууд нь салбарын хэмжээнд яг тэр архитектурыг нь хийчихсэн. Тэгэхээр ер нь салбар болгон ийм өөрийн интерпресс архитектуртай болоод мэдээллийн нэгдсэн сантай болж чадах юм бол түүний зардалд их зардал хэмнэнэ гэж ойлгож байгаа. Үндэсний статистикийн хороо, Цахим хөгжил, харилцаа холбооны яам хамтраад энэ нийтийн мэдээллийн санг бий болгоод биг дата төрийн шийдвэр гаргалтад ашиглах ажил дээр хамтарч ажиллаж байгаа. Статистикийн хороо дээр Азийн хөгжлийн банкны төсөл хэрэгжинэ. Тэгээд ингээд бид бол энэ жилдээ нийтийн мэдээллийн нэгдсэн санг бий болгоно гэж бас та ойлгож болно.

Сая Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргаар ахлуулсан бүтээмжийн Үндэсний хороо хуралдаад шийдвэр гаргасан. Үүний үр дүнд бид нар улсын зардлаар хийгдсэн бүх салбарын судалгааг нэгтгэж байгаа. Энийг судлаачид, иргэд ашиглах бололцоотой болно. Яагаад гэхээр нийтийн мэдээллийн ил тод байдлын хуулийн 68 төрлийн мэдээлэл дотор ил болгох үүрэг нь байгаа. Тэгэхээр улсын төсвөөр хийгдсэн бүх судалгаануудыг олон нийтэд нээлттэй болгоно. Тэр судалгаануудыг

ашиглах бололцоог эндээс бүрдүүлж байгаа. Тэгэхээр ер нь бол таны хэлснээр бид нар биг дата шийдвэр гаргалтад ашиглах чиглэлээр бол онцгой анхаарч бас ажиллаж байгаа. Одоо бол яг биг дата шийдвэр гаргалтад ашиглаад байгаа тийм ухаалаг төрийн байгууллага алга байна шүү дээ. Дээрээс нь хиймэл оюун ухааныг хэрэглэж байгаа анхны тохиолдол бол боомт дээр хийгдэнэ гэж хүлээлттэй байна. Хувийн хэд хэдэн компанийн шийдлүүдийг танилцуулсан. Сонсож байгаа. Энэ хил, гааль дээр боомтууд дээр энэ ажил нэлээн их үр дүнтэй бол бас явагдах эхлэл тавигдаж байна. Бид Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар, иргэдийн өргөдөл гомдлуудыг шийдвэрлэх чиглэлийг нөгөө чатботоор албан ёсны хариу өгөөд хиймэл оюун ухаан хариу өгдөг ажлыг зохион байгуулна.

Энэ и-бизнесийн хүрээнд хиймэл оюун ухаанаар зөвшөөрлийг цахимжуулахгүй бол үр дүнд хүрэхгүй. Тийм учраас ухаалаг засгийн хүрээнд бид нар энэ зөвшөөрлийг цахимжуулах ажлыг хиймэл оюун ухаанаар шийдвэрлэе гэдэг ажлын даалгавар боловруулна. Үгүйгээр зүгээр нөгөө и-бизнес гэж хэлчхээд зөвшөөрлийг онлайнар бүртгэж аваад байгаагаа зөвшөөрлийг цахимжуулсан гэж хэлэх нь зохимжтой биш. Шууд иргэддээ хиймэл оюун ухаан өгдөггүй байх юм бол ард нь дахиад л нэг хүмүүс ажиллаад л тэрийг шийддэг байвал дахиад л авлига нүүрлэнэ шүү дээ.

О.Цогтгэрэл: Хиймэл оюун ухаан ашиглаж байгаа байдал НӨАТ-ын мэдээллийн систем дээр тодорхой хэмжээгээр байдаг юм болов уу гэж бас ойлгосон. Жишээ нь тэнд бол хувийн мэдээлэл биш байдлаар бизнес, эдийн засгийн шийдвэр гаргалтад ер нь бизнесүүдэд өгөх асар их том мэдээ, материал тэнд байгаа байх гэж. Ер нь бол энэ маш их хэрэгтэй материалууд төр дээр цуглаж байгаа байх. Тэр дээр бас зөв зүйтэй байдал дээр их анхаарах, ашиглах бололцоотой болгох ёстой байх.

Түүрүүн тэр цахим гарын үсэг гэдэг зүйл бас ярилаа. Тэрэнд 400-аад мянган иргэн дээр очсон гэж хэлэх шиг болсон. Ер нь хэдэн иргэн авах ёстой билээ. Гол нь иргэдийн ашиглалт яг ямар байгаа юм. Дахиад болж өгвөл нэг тоон утгаар гэдгийг чанарын утгаар нь яг нэг хүчээр тэтгэврээ авахад ч юм уу, нэг хүчээр хэдэн хүн бүртгүүлчхээд байна уу. Ер нь явсаар байгаад энэ дижитал шилжилт гэдэг юм чинь явсаар байгаад бараг тоон гарын үсгийг дижитал гарын үсгийг хэр зэрэг ердийн ажил амьдралд ашиглаж эхэлж байна вэ. Иргэд гэдэг өөрөө их том энэ шилжилтийн том шалгуур үзүүлэлт байх л даа. Тэгэхээр энэ дээр нэг тодорхой хариултууд өгөөч. Тоон гарын үсгийн ашиглалт бодит байдал дээр ингээд хүчээр шахалтаар заавал ингэж байж тендерт ор гэдэг ч юм уу. Ингэж байж татварын албатай харьц гээд нэг хэдэн хүнд хүчээр өгчихсөн. Яг ердийн иргэдийн амьдралд хэр зэрэг ашиглалттай байгаа бол.

Н.Учрал: Тоон гарын үсэг 494,072 өнөөдрийн байдлаар. Төрөөс олгогдсон 14,249, Улсын Бүртгэлийн ерөнхий газраас бие дааж олгосон 393,369 буюу иргэний үнэмлэх дээр олгосон. Хувь хүмүүс өөрсдөө санаачилга гаргаад өөрсдөө хүсэлт тавиад 86,454 олгогдсон. Тэгэхээр тоон гарын үсэг дээр бол энэ чинь нэг хүн хэдэн ч тоон гарын үсэгтэй байж болно. Тоон гарын үсгийг нөгөө янз бүрийн дивайсаар авч болно. Иргэний үнэмлэх дээрээ суулгаад чипээр авч болж байна. Интернэтийн ямар нэгэн cloud орчинд байршуулж болж байна. Улсын бүртгэл өөрөө аппликэйшнтэй байгаа e-sign гээд. Тэр аппликэйшн дээр суулгаад авч болж байна. Бүх төрлийн сонголтыг өгч байгаа. Тоон гарын үсгийн хэрэглээ бол өнөөдөр 52 хувьтай л байна. Тухайн гарын үсэг бол төрийн байгууллагууд манлайлж хэрэглэж эхлэхгүй бол цаашидаа иргэд хэрэглэхэд бэрхшээлтэй. Ерөөсөө л манай байгууллага цахимаар болж байна гэхэд нөгөөдөх нь цахимаар бичиг солилцож чадахгүй байхаар чинь хоорондоо солилцох ямар ч бололцоогүй

байхгүй юу. Тэгээд бүгдээрээ л ийшээ орж байж. тоон гарын үсгийг нь нэвтрүүлэхгүй манайх цахимаар, цахим гарын үсэг хэрэглэдэггүй юм. Танайх хэрэглэдэг юм гээд байх юм бол энэ ч ерөөсөө үр дүнд хүрэхгүй байгаа учраас тэр бичиг солилцоонуудыг бүх ажил дээр энэ тоон гарын үсгүүдийг хэлж өгсөн. Хуулиараа бол цахим гарын үсгийн хуулиар 16 насанд хүрээд иргэний үнэмлэхээ авсан хүн бүр эрх үүсэж байгаа юм. Тэгээд цахим гарын үсгийн хууль дээр бүртгэлийн байгууллагаас иргэн болгондоо нэг удаа тоон гарын үсэг дээр нь олгож эхэлсэн шүү дээ. Тэгээд харин нэмэлтээр тоон гарын үсгээ авах юм бол тухайн иргэн мөнгөө төлөөд тэр cloud орчноос байна уу, бүртгэлийнх байна уу, хувийн нөгөө тоон гарын үсгийн гэрчилгээжүүлэх байгууллагуудаас байна уу чөлөөтэй авах бололцоо нь бол хүн бүрд нээлттэй байгаа. Тэгээд тоон гарын үсэг цаашидаа түгжрэлийг бууруулахад, төвлөрлийг сааруулахад хамгийн бол бас чухал түлхэц үзүүлнэ гэж үзэж байгаа. Ашиглалтыг нэмэгдүүлэхэд бол түрүүн миний хэлсэн төрийн цахим үйлчилгээг зохицуулахтай холбоотой хуулийн давхардал хийдлийн хууль их хэрэгтэй байгаа. Яагаад гэхээр яг хууль дээр цагаан дээр хараар цаасаар энэ материалыг бүрдүүлнэ гээд заачихсан учраас энэ чинь заавал цаасаар нэхэгдээд байгаа юм. Тэгээд тоон гарын үсгийг хуулиар буюу тэр 169 хуулийн давхардлыг арилгах дээр бол хийж байна. Дээрээс нь тоон гарын үсгийг нь нэмэгдүүлэхээр бол бид нар ТҮЦ машинуудаар тоон гарын үсгийг олгож эхэлсэн. Тэгэхээр та бүхэн бол тэр түрүүн миний хэлээд байгаа тэр банкнуудын манай тэр дата төвийн ТҮЦ машинуудаар тоон гарын үсэг олголт эхэлж байгаа. И-Монголиа дээр киоскууд нээгдээд явна. Тэгэхээр нэг цэгийн үйлчилгээ, киоскууд бүх төрлийн хувийн арилжааны байгууллагууд, тэр аль ч байгууллагын киоскуудаар тоон гарын үсгийг бид нар олгож эхэллээ гэхээр хэрэглээнд нэвтрүүлэх тал дээр тал

талаас л шахаж шаардаж ажиллаж байгаа.

О.Цогтгэрэл: Минут бас бага байх шиг байна. Энэ мэдээлэл технологийн салбарын мэдээллийн технологийн салбарын Монгол Улсын эдийн засагт оруулж байгаа үүрэг оролцоог та яг юу гэж бодож байна. Танай салбарынхан. Энэ хандлага нь яг ямар нөхцөл байдалтай байна. Би бараг өөрийн дүгнэлтээ хэлэхэд үнэхээр яг энэ салбарт ажиллаж байгаа нэг хэсэг маш дэврүүнээр маш олон технологийн компаниуд, стартап компаниуд, залуучууд маш их ийшээ орж орж байсан. Яг бодит байдалдаа дахиад л нөгөө үр дүнгээ л харвал үр дүн их тааруу. Үндсэндээ яг иргэд ашиглаж байгаа мэдээллийн технологийн төслүүд гэвэл UBCab нэг гайгүй байх шиг байгаа юм. Өөр бас яг юу байна вэ. Зүгээр ашигтай ажиллагаа нь мэдэхгүй. Ингээд үзэхээр энэ салбар өөрөө энэ зөвхөн төрийн цахим шилжилт биш ер нь энэ Монгол Улсын мэдээллийн технологийн салбарын хөгжил, эдийн засагт оруулж байгаа үүрэг оролцоо гэдэг юм. Яг бодит байдал дээр нэгдүгээрт бодит байдал, хоёрдугаарт нь бид нарын энэ алслагдмал болоод орон зай нь ийм хавчигдмал байдалтай орны хувьд ач холбогдол өгөх ёстой орны хувьд бодит үр дүн бол асар их тааруу ийм нөхцөл байдалтай явж байна л гэж ойлгодог. Тэгэхээр энэ нөхцөл байдлууд дээр та нар ямар дүгнэлт тавьдаг юм. Цаашидаа яг үнэхээр энэ дээр стратегийн гэдэг юм уу том бодлогын чиглэл ямар өөрчлөлт хийж байж эндээс цаашиа гарах ёстой юм бол. Илүү эдийн засагт орох үүрэг оролцоо нэмэгдэх ёстой бол ямар бодлого байгаа вэ гэж.

Н.Учрал: Программ хангамжийн компаниудын өрсөлдөх чадвар бол нэмэгдэж байгаа. Төрийн ямар нэгэн оролцоогүйгээр өөрсдөө өсөж хөгжиж, дэвжиж байгаа. Тийм учраас бол бид нар илүү саад тотгор болохоосоо илүүтэйгээр дэмжиж ажиллаж гээд

эхний шатанд бол энэ программ хангамжийн худалдан авалтаа шилэн болгож өглөө. Энэ бол манай салбарынханд бас их сайн ажил болсон гэж үнэлэгдсэн. Хуучин бол тухайн компанийн туршилага дээр үндэслэж төр худалдан авалт хийдэг байсан. Тэр компани хэдэн жил ажилласнаас шалтгаалж ингээд эхлэхээр цөөхөн хэдэн хуруу дарам компани тендер авдаг. Олон улсад өрсөлдөхөд төрийн ажлыг тодорхой хэмжээнд хийсэн гэдэг ийм түүх үлдэх юм бол тэр компаниудын өрсөлдөх чадвар нэмэгддэг гэж өөрсдөө компаниуд бас хэлж байгаа юм. Жишээ нь энэ байгууллага бол И-Монголиа системийг энэ компани хийсэн юм гээд хэлбэл энэ түүх үлдэх юм бол олон улсад өрсөлдөх чадвар нь нэмэгдэнэ гээд. Тийм учраас бид нар энэ төрийн худалдан авахдаа и-тендертэй цахим дэлгүүрээ уяад тэр майндголиа дээр бүтээгдэхүүн байршуулаад эхэлчихээр 3 хүнтэй компани байгаад 3 сар ажилласан компани ч гэсэн бүтээгдэхүүнийхээ чанараар өрсөлдөх бололцоотой болж байгаа юм.

2 дугаар сард зохион байгуулагдах тэр цахилгаан холбооны байгууллагаас зохион байгуулагдах дэлхийн том чуулган дээр Оюун санаагаа олборлоё гэж Монголын Топ софтвэр хөгжүүлэгч компаниудын үзэсгэлэнг Цахим хөгжил, харилцаа холбооны яам хамтарч зохион байгуулах гэж байгаа. Дэлхийн том технологийн компаниуд оролцоно. Хөрөнгө оруулагч нар танилцуулгаа хийнэ. Хөрөнгө оруулагч нарыгаа урина. Дээрээс нь миний танд бас онцгойлж хэлэх нэг зүйл бол оюуны өмч, их кодыг нь төр эзэмшихээ больё л гэж байгаа юм. Жишээ нь И-Монголиаг “Аствиин” гэдэг компани хийсэн юм байна. Гэтэл тэр компанийн оюуны өмчийг нь төр эзэмшээд суугаад байдаг юм. Гэтэл тэр оюуны өмчийг нь төр эзэмшихгүй байвал Африкийн нэг оронд И-Монголиаг зарж болно шүү дээ. Тэр компани. Төрийг эзэмшихэд дараагийн нэг дарга ирдэг. Төрийг ашигладаг ч юм байдаггүй шүү

дээ. Төр зөвхөн лицензээр эзэмш. Оюуны өмчөө тухайн компани өөрөө эзэмшээд хаана борлуулах нь өөрсдийнх нь асуудал байж гэж үзэж байгаа юм. Тэгээд энэ харилцаа холбоо мэдээлэл технологийн салбар бол илүү харьцангуй ер нь бол либералчилсан бодлогыг барих нь бол бас зохимжтой юм байна гэдгийг хэлэх ёстой. Дээрээс нь нөгөө хүн цагаар үнэлэгддэг учраас бид нар барилга байшин шиг яг одоо ингээд нэг тийм тодорхой тоо гаргаад үнэлэх асар их бэрхшээлтэй. Ялангуяа энэ оюун санаанд бүтэж байгаа зүйлийг. Би 2019 онд Оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулах хуулийг батлуулсан. Энэ хуулийн хүрээнд зохиогчийн эрхийн гэрчилгээгээр программ хангамжуудын материаллаг бус баялгийг.../минут дуусав/

Г.Занданиатар: Микрофон таслахгүй тавьдаг чинь дундаас нь таслаад асууж бариад мэтгэлцээд яваад байж болохоор л тавьчихсан. Бүлгээс асуултууд тавьж, хариулт авч дууслаа. Протоколд тэмдэглэх зорилгоор би ажлын хэсгийг бас танилцуулъя.

Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын Ням-Осорын Учрал, Цахим Хөгжил Харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга Чулуунцэцэгийн Золбаяр, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Сүхээгийн Тэнгис, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Цахим хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Бадамдоржийн Билэгдэмбэрэл, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Харилцаа холбооны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Хатанбаатарын Энхманлай, Харилцаа холбооны зохицуулах хорооны Зохицуулалтын бодлогыг хэрэгжүүлэх газрын дарга Бавуужав Мянгарнаран, харилцаа холбооны зохицуулах хорооны Өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын газрын дарга Алтайн Лувсан-Очир, Харилцаа холбооны зохицуулах хорооны

Радио давтамж хяналт зохицуулалтын газрын дарга Зандраагийн Амгалан, Харилцаа холбооны зохицуулах хорооны Зах зээл, үнэлгээ судалгааны газрын дарга Данзандоржийн Ариунболд, Харилцаа холбооны зохицуулах хорооны Хуулийн хэлтсийн дарга Төмөрийн Ууганбат, Үндэсний дата төвийн захирал Мөнхдоржийн Баттулга, И-Монгол академийн захирал Лхагвасүрэнгийн Энхбат.

Үдээс хойших нэгдсэн хуралдаанаар Ерөнхий сайдын мэдээллийг сонслоо. Гишүүд Ажлын хэсэгт баярлалаа. Цөөнхийн бүлгээс асуусан.

Баталсан хууль тогтоолуудын эцсийн найруулгыг сонсьё.

Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Дагалдан гарсан Монгол Улсын Засгийн гарын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулга сонссонд тооцлоо.

Хуулийн төсөл буцаах тухай Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонсоод тооцлоо.

Хөгжлийн зорилт хөтөлбөрөө яах билээ. Засгийн газраас татан авахаар хойшлуулсан болон Дэгийн тухай хуулиар хууль санаачлагч байхгүй учир энэ асуудлыг хойшлууллаа.

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул чуулганы нэгдсэн хуралдаан өндөрлөснийг мэдэгдье ээ.

ДУУНЫ
ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ
БУУЛГАЖ,
ХЯНАСАН:

БИЧЛЭГЭЭС
ТЭМДЭГЛЭЛ
ШИНЖЭЭЧ
Э.СУВД-ЭРДЭНЭ